

МОНГОЛ УЛС ДАХЬ БИЧИЛ УУРХАЙН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН СУДАЛГАА



2014



The Asia Foundation

Improving Lives, Expanding Opportunities



УУЛ
УУРХАЙН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation

Энэхүү гарын авлагыг Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр АНУ-ын Азийн сан, Уул уурхайн яамтай хамтран хэрэгжүүлж буй *“Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II”* төслийн хүрээнд хэвлэв. Уг хэвлэлийн агуулга нь зохиогчийн байр суурийг илэрхийлж буй бөгөөд АНУ-ын Азийн сан болон санхүүжүүлэгч байгууллагуудын байр суурийг илэрхийлээгүй болно.

МОНГОЛ УЛС ДАХЬ БИЧИЛ УУРХАЙН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН СУДАЛГАА

Холимог судалгааны аргаар хийгдсэн судалгаа
2013 оны 10 сар

Хүлээлгэн өгсөн

АНУ-ын Азийн сан
Г.Чагдаржавын гудамж 9
Улаанбаатар 14210
Монгол улс

Энэхүү төслийг АНУ-ын Азийн Сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж байгаа болно.

Гүйцэтгэсэн:



Siriusstraat 14
Paramaribo, Suriname
Tel: (597) 457885

Зохиогч:

Мариэкэ Хээмскерк
Утас: +597 8910049
И-мэйл: mheemskerk@yahoo.com

Товчилсон болон гадаад үгс

АХБ	Азийн хөгжлийн банк
аймаг	Муж
БУ	Бичил уурхай
ХМХ	Хүүхдийн мөнгө хөтөлбөр
БҮ	Бие үнэлэгчид
зуд	Хүйтэн, цас ихтэй өвлийн улиралд тохиолддог байгалийн гамшигт үзэгдэл бөгөөд хунгар цасан доороос мал өвс тэжээлээ олж идэж чадахгүйд хүрч, цочир хүйтэн, өлсгөлөнгийн улмаас мал олноор үхэж үрэгддэг.
БОХТОН	Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь
Жонш	Кальци болон флюритээс бүрдсэн (CaF ₂) энэхүү эрдэсийг металлург, хими болон тусгай зориулалттай шилний зэрэг олон төрлийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг. Жонш өнгө, талстын өвөрмөц шинжтэй бөгөөд үнэт эдлэл, чимэглэл гэх мэтийн гоёл чимэглэлийн бүтээгдэхүүн хийхэд ч бас ашиглагдана.
ТХТЖТ	Тогтвортой хөгжлийн төлөө жендер төв
гэр	Монголын тал хээр нутгийн нүүдэлчин ард түмний өв уламжлан хэрэглэж ирсэн зөөврийн сууц юм. Монгол гэр нь яс мод болон эсгий бүрээс гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮНО	Үндэсний нийт орлого
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
Төгрөг	Монгол төгрөг (тэмдэглэгээ: ₮) 1.00 ам. доллар =1,697.48 төгрөг (2013 оны 10 сарын 20)
N	Түүврийн хэмжээ
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ТББ	Төрийн бус байгууллага
нинжа	Хууль бус алт олборлогчдын албан бус нэр. Тэд алтаа угаахдаа ногоон өнгөтэй хувин/түмпэн ашигладаг байсан бөгөөд хувингаа нуруун дээрээ үүрээд явж байгаа нь нинжа яст мэлхийнүүдийн тухай өгүүлдэг хүүхэлдэйн киноны баатруудтай адилхан харагддаг байжээ.
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
сум	Засаг захиргааны хоёрдугаар түвшний нэгж
НБХСХ	Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
АС	АНУ-ын Азийн сан
НҮБ-ын ХХ	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын ХАС	НҮБ-ын хүн амын сан
Ам. доллар	Америк доллар

Талархал

Энэхүү судалгааг явуулахад дэмжлэг үзүүлсэн бүх хүмүүст ялангуяа судалгаанд хамрагдсан бичил уурхайчид, бичил уурхайн суурьшлын бүсийн үйлчилгээ үзүүлэгч иргэд, биднийг бичил уурхай дахь ажлын байр, ажилтайгаа танилцуулан, бусад бичил уурхайчидтай уулзуулахад туслалцаа үзүүлсэн бичил уурхайн нөхөрлөл болон ТББ-ын тэргүүнүүдэд гүн талархал илэрхийлье.

Энэхүү судалгааг Швейцарийн хөгжлийн агентлагийн (ШХА) санхүүжилтээр АНУ-ын Азийн сангийн хэрэгжүүлж буй “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь” II төслийн хүрээнд АНУ-ын Азийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын захиалгаар хийсэн болно.

АНУ-ын Азийн сангийн чадварлаг судлаачдын багийн дэмжлэггүйгээр судалгааны мэдээлэл, баримтыг цуглуулах боломжгүй байсныг энд дурдмаар байна. Тус баг, зөвлөхийн хамтаар хээрийн судалгааны ажлын хийхдээ хүнд нөхцөлд уртасгасан цагаар ажилласан. Мөн бичил уурхайн талаар суурь мэдээллийг өгч, Монголын уул уурхайн салбарын онцлогийг ойлгоход дэмжлэг үзүүлснээс гадна судалгааны тайлангийн төсөл хувилбартай танилцан, санал, бодлоо хуваалцсан. ШХА-ийн ТБУ төслийн зүгээс ч бидэнд тодорхой санал зөвлөмж өгч, бичил уурхай дахь жендерийн харилцааны талаар иж бүрэн ойлголтыг бий болгоход гүн туслалцаа үзүүллээ.

Түүнчлэн Монголын уул уурхайн салбар дахь жендерийн нөхцөл байдал болон жендерт суурилсан хүчирхийллийн талаар тодорхой ойлголт авахад гүн туслалцаа үзүүлсэн жендер судлаач Изабел Кэинд талархаснаа илэрхийлье.

Энэхүү судалгаанд тусгасан үзэл бодол нь зөвхөн зохиогчийн үзэл бодол бөгөөд судлаачид, хамтран ажилласан байгууллагууд үүнд АНУ-ын Азийн сан, Швейцарийн хөгжлийн агентлаг болон бусад байгууллагуудын байр суурь, үзэл бодлыг илэрхийлээгүй болно. Орчуулгын болон тайлбарын үүднээс гарсан аливаа алдаа, дутагдлыг зохиогч өөрөө хариуцна.

Хураангуй

Танилцуулга болон оршил: ШХА-ын санхүүжилтээр АНУ-ын Азийн сангийн хэрэгжүүлж буй “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II” төслийн үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангах стратеги боловсруулахад нь зориулж бичил уурхай дахь жендерийн тэгш байдлын энэхүү судалгааг хийв. Монгол Улс нь нийт 2.8 сая хүн амтай бөгөөд хойд Азид орших далайд гарцгүй улс юм. Монгол Улс дахь жендерийн өнөөгийн хэв байдал бүрэлдэн тогтоход нийгэм соёлын хүчин зүйлс тэр дундаа нэгэн жарны турш үргэлжилсэн социалист нийгэм (1924-1989) болон зах зээлийн эдийн засагт шилжсэн шилжилтийн 23 жил голлон нөлөөлж иржээ. Монгол Улс хүйсийн тэгш байдлыг хангах чиглэлээр хэд хэдэн хууль тогтоомж батлан гаргасан бөгөөд эмэгтэйчүүд нь эрчүүдээс боловсролын түвшингээр дээгүүр, эрүүл мэндийн хувьд ч илүү сайн аж. Гэхдээ нөгөө талаар улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо улам бүр буурч, цалингийн зөрүү нэмэгдэж, эдийн засгийн голлох салбаруудад эрчүүдийн давамгайлал бий болсон нь ажиглагдах болов. Төрөөс хэрэгжүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээнүүд гэр бүл тэр дундаа эмэгтэйчүүдэд нийгмийн болон санхүүгийн наад захын баталгааг бий болгоход дэм болж байна.

Өнөөдөр Монгол Улсад 30-100 орчим мянган бичил уурхайчид бий гэсэн тоо бий. 1990-ээд оны эхээр байгаль цаг уур, улс төр, эдийн засаг, нийгмийн нөлөөгөөр олон иргэд ажилгүй болж, улмаар амь зуухын эрхэнд бичил уурхай эрхлэх болов. Бичил уурхайчид гол төлөв алт, жонш, нүүрс олборлох бөгөөд хууль бусаар бичил уурхай эрхлэгч иргэдийн 15-18 орчим хувь нь хүүхдүүд буюу голдуу эрэгтэй хүүхдүүд ажээ. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журамд бичил уурхайчин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгайлан заасан ямар нэг зүйл заалт байдаггүй. Бичил уурхайчид дунд эмэгтэйчүүд тухайн уурхай дээрээ 19.4 хувиас эхлээд 45-50 хүртэлх хувийг эзлэх бөгөөд тэд голдуу алтны шороон ордод ажиллана. Эр, эм хүмүүсийн онцлог, биеийн хүчний чадавхиас шалтгаалаад ажил үүргийн хувиарлалт нь гэр бүлдээ болон уурхай дээр өөр өөр байна. Эмэгтэйчүүд гэрийн ажлаа давхар хийдгээс үүдээд уурхай дээр эрчүүдээс богино цагаар ажиллаж, арай бага орлого олдог бол эрчүүд уурхайд ажиллах явцдаа гэмтэл бэртэл авах, архи согтууруулах ундаа хэрэглэх нь илүү ажээ. Өмнө нь хийгдсэн бусад судалгаанаас харахад бичил уурхайн орчимд охид эмэгтэйчүүдийн хувьд биеэ үнэлэх, бэлгийн хүчирхийлэлд өртөх, бэлгийн замын халдвар авах, үр хөндүүлэх зэрэг явдлууд олон тохиолддог тухай баримттайгаар өгүүлсэн нь бий.

Арга зүй: Энэхүү судалгааг хоёр төрлийн эх сурвалжаас авсан мэдээ, тоо баримтан дээр тулгуурлан хийв. Эхнийх нь Нийгмийн Бодлого, Хөгжлийн Судалгааны Хүрээлэнгээс хоёр мянган орчим бичил уурхайчдын дунд явуулсан тоон судалгаа, харин хоёр дахь нь алтны шороон, үндсэн орд болон жоншны орд дээрх бичил уурхайнууд 2013 оны 8 дугаар сарын 11-17 ны хооронд ажиллаж цуглуулсан мэдээлэл юм. Бичил уурхай дээр газар дээр нь очиж ажиллахдаа бичил уурхайчдыг хүйс харгалзалгүйгээр хамруулсан гурван удаагийн зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, бичил уурхайн нөхөрлөлийн 10 гаруй тэргүүнтэй нүүр тулсан ярилцлага, 35 бичил уурхайчид болон уурхайн ойр орчимд худалдаа, үйлчилгээ үзүүлэгч иргэдтэй хийсэн хагас системчилсэн ярилцлага болон ажиглалтын аргыг ашигласан болно. Зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр эр, эм бичил уурхайчдын уурхай болон гэр бүл доторх ажил үүргийн хувиарлалтыг гаргав.

Үр дүн: НБХСХ-ийн судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын гуравны нэг нь (30.7%) эмэгтэйчүүд байв. Ерөнхийдөө алтны үндсэн ордны уурхайд ажилладаг эмэгтэйчүүдийн тоо харьцангуй бага. Өвлийн улиралд бичил уурхай эрхлэгчдийн тоо тал хувиар буурдаг ч хүйсийн төлөөллийн хувьд бараг тэнцүү болдог байна. Эмэгтэйчүүд уурхай дээр нөхөр аль эсвэл гэр бүлийн өөр хэн нэг гишүүнтэй голдуу хамтран ажилладаг ч ганцаараа бие даан ажилладаг эмэгтэйчүүд ч мөн бий. Нас, боловсролын түвшний хувьд эр, эм бичил уурхайчдын хооронд төдийлөн ялгаа байдаггүй. Гэрийн ажил, үр хүүхдээ харах нь гол төлөв эмэгтэйчүүдийн үүрэг байх бөгөөд дээрх ажилд эрчүүдээс илүү их цаг зарцуулдаг тул эмэгтэйчүүдийн гэр бүл дэх

энэхүү үүрэг уурхай дахь ажил үүргийн хуваарилалтанд ч мөн нөлөөлнө. Харин эрчүүд мод хагалах, ус авах, эд хогшил болон бусад зүйлсийн эвдрэл гэмтлийг засварлахаас гадна зарим үед хүүхэд харах зэргээр гэрийн ажилд тусалдаг аж. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь эрчүүд өрхийн тэргүүн, амьжиргааг залгуулагч гол хүн гэж үзсэн бол үүнээс арай цөөн тооны оролцогчид эхнэр нөхөр хоёр адил тэгш үүрэгтэй гэжээ. Өрхийн орлогыг зарцуулахдаа эхнэр нөхөр хоёр гол төлөв харилцан ярилцаж, шийдвэр гаргадаг байна. Хэдийгээр зарим нэг өрхийн тэргүүнүүд бие даан шийдвэр гаргадаг ч гол төлөв эхнэрүүд шийддэг аж.

Эмэгтэйчүүдийн гэрийн ажилд цаг их зарцуулдаг тул эрчүүдтэй харьцуулахад арай цөөн өдөр, бага цагаар бичил уурхай дээр ажиллана. Гэрийн ажлын хувиарлалттай нэгэн адил уурхай дээр ч гэсэн ажил үүргийн хувиарлалт хүйсээс шалтгаалан өөр байх нь бий. Ажил үүргийн хувиарлалтанд учирч болох эрсдэл, биеийн хүчний чадавхи зэрэг нөлөөлдөг ч хатуу нарийн чанд тогтоогдоогүй бөгөөд боломжтой үед хэн хэн нь бүх ажлаа хийнэ. Эрчүүд чулуу бутлах, малтах, тэслэх, хүдэр ялгах, ачих буулгах зэрэг олборлолттой холбоотой бүхий л хүнд ажлыг нугалж, харин хүдэр баяжуулах болон бусад туслах ажилд тэр бүр оролцохгүй. Угаах, боловсруулах цех бэлдэх зэрэг хүдэр баяжуулахтай холбоотой ажлууд болон хоол, цэвэрлэгээ хийх, алт худалдаж авах зэрэг бусад туслах үйлчилгээг эмэгтэйчүүд голлон хариуцдаг ч зарим үед хүдэр татаж гаргах, чулуу ялгах, шуудайлах зэрэг олборлолттой холбоотой ажлуудыг ч мөн хийнэ.

Эрэгтэй уурхайчдын дийлэнх нь эрчүүд уурхайн ажилд эмэгтэйчүүдээс илүү гэсэн бол эмэгтэйчүүд тийм ч их ялгаа байхгүй хэмээн үзжээ. НБХСХ-ийн судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдагсдын дийлэнх уурхайд ажиллах нь эмэгтэйчүүдэд тохиромжтой ажил биш хэмээн үзсэн байна. Уурхайд ажиллах нь бие махбодийн хувьд ихээхэн хүч шаардсан хүнд хэцүү ажил байдаг тул эрчүүдийн 62.7 хувь эмэгтэйчүүдийн 52.3 хувь нь ийнхүү хариулжээ. Ялангуяа уурхайн гүнд ажиллах нь эмэгтэйчүүдэд тун тохиромжгүй гэв. Харин зарим уурхайчид хариулахдаа амьдралын шаардлагын улмаас эмэгтэйчүүд ч гэсэн орлого олох хэрэгтэй, тэгээд ч тэд олон төрлийн ур чадвартай байдаг учраас уурхайд ажиллах нь тохиромжтой хэмээн үзсэн байна.

Энэхүү судалгааг хийсэн бичил уурхайнууд дээр ихэнх бичил уурхайчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон байсан бөгөөд зөвхөн цөөн тооны эрэгтэй бичил уурхайчид л бие даан ажиллаж байв. Харин судалгаанд хамрагдсан эмэгтэй уурхайчдын 44 хувь нь, эрэгтэй уурхайчдын дөрөвний нэг (24.6 хувь) хувь нь эмэгтэйчүүдээр ахлуулсан нөхөрлөлийн харьяанд ажилладаг байна. Энэ нь эмэгтэй уурхайчид ихтэй газруудад түлхүү анзаарагдав. Нөхөрлөлийн тэргүүнээр эр, эм аль нь ч ажилласан ялгаагүй хэмээн эрчүүдийн 48.2 хувь, эмэгтэйчүүдийн 49.8 хувь нь үзжээ. Хэдийгээр нөхөрлөлийн тэргүүнээр эр хүн ажиллахыг илүүд үздэг хүмүүсийн тоо арай их байсан ч эмэгтэйчүүд ч мөн адил удирдан зохион байгуулах, менежмент, нөлөөллийн ажил хийх чадвартай гэж үзэх хүмүүс олон байлаа. Зохион байгуулалтанд орсноор ялангуяа аюулгүй ажиллагааг хангах, тогтвортой ажлын байраар хангагдах, мэдээллийн хүртээмж нэмэгдэх болон эрүүл мэндээ хамгаалах талаар олон давуу тал бий болдог гэдгийг эр, эм бичил уурхайчид аль аль нь хүлээн зөвшөөрсөн байна. Бичил уурхайчид хүйсээс хамааралгүйгээр нөхөрлөлийн хүрээнд эрх тэгш байх бөгөөд шийдвэр гаргах, орлого хуваарилахад тэгш оролцоотой.

Эрчүүдийн хувьд ажлын байр байхгүй, харин эмэгтэйчүүдийн хувьд ажилгүй болсон нь бичил уурхай эрхлэх гол шалтгаан болжээ. Тэдний аль алинийх нь хувьд бичил уурхай орлогын цорын ганц эх үүсвэр нь бөгөөд орлого нь тогтмол биш ч гэсэн Монгол улсад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр байдаг аж. Иймээс уурхайчдын дийлэнх нь дараагийн таван жилд ч бичил уурхайгаа үргэлжлүүлэн эрхлэхийг хүсч байна. Ирээдүйн төлөвлөгөөний хувьд судалгаанд хамрагдагсад малтай болох, жижиг бизнес, газар тариалан эрхлэх аль эсвэл ямар нэгэн ажилд орох зэргээр орлогын өөр эх үүсвэр бий болгоход хөрөнгө оруулах сонирхолтой гэдгээ илэрхийлжээ. Бичил уурхай эрхлэх нь биеийн хүнд хөдөлмөр учраас хүүхдүүдээ бичил уурхайчин болгохыг хүсдэггүй хэмээн дийлэнх нь хариулжээ.

Чанарын судалгаа хийх явцад дээрх бичил уурхайнуудад охид, эмэгтэйчүүд болон эрчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гардаг гэх зүйл төдийлөн ажиглагдсангүй. Бичил уурхайн нөхөрлөлүүд уурхай дээр архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосноор гэмт хэрэг, хүчирхийлэл тэр дундаа жендерт суурилсан хүчирхийлэл буурахад илт нөлөөлжээ. Бичил уурхайн улмаас байгаль орчинд учирч буй хамгийн ноцтой хор хөнөөлийг газрын эвдрэл хэмээн үзсэн байна. Эрчүүдээс илүүтэйгээр эмэгтэйчүүд усны бохирдлыг байгаль орчны тулгамдаж буй ноцтой асуудалл тооцсон нь гэрийн ажилтай нь холбоотой байж болно.

Бичил уурхайчдын дийлэнх нь эр, эм бичил уурхайчдын өмнө тулгардаг хүндрэл, бэрхшээлүүд ялгаатай гэж үзжээ. Эмэгтэйчүүдийн хувьд гэр орноо авч явахад илүү үүрэгтэй, дээр нь биеийн хүчний хувьд эрчүүдээс сул дорой байдаг нь тэдэнд учирдаг хамгийн гол хүндрэл ажээ. Бичил уурхай эрхлэхээр шинээр шилжин ирсэн залуу эмэгтэйчүүдийн хувьд бага насны хүүхдээ өөр хэн нэгний асрамжид үлдээх нь хамгийн хэцүү гэв. Үүнээс гадна ганц бие өрх толгойлсон эхчүүдийн хувьд бичил уурхайн ажлаа эх байх үүрэгтэйгээ хослуулан хийх нь ихэд хүндрэлтэй байдаг гэнэ.

Хэлэлцүүлэг ба дүгнэлт: Чанарын судалгааг цөөн тооны бичил уурхай дээр хийх боломжтой байсан тул энэ судалгааны мэдээлэл нь нийт бичил уурхайчдын нөхцөл байдлыг бүрэн төлөөлөх хэмжээний өргөн цар хүрээг хамраагүй байж болно. Гэвч НБХСХ-ийн судалгаа болон өмнө нь хийгдсэн бусад судалгаанууд бидний хээрийн ажлын дүнд олж авсан мэдээллийг бататгасан. Тиймээс чанарын судалгааны мэдээлэл, тоо баримт бичил уурхай дахь (зохион байгуулалтанд орсон) жендерийн харилцааны талаар үнэн бодит дүр төрхийг харуулж чадсан гэдэгт бид итгэлтэй байна. Судлаачдын ажигласнаар жендерийн тэгш байдлыг дэмждэг социалист нийгмийн өв уламжлал Монголд одоог хүртэл хадгалагдсаар байгаа бөгөөд бичил уурхай дээр ч ажиглагдаж байна. Бичил уурхайн салбарт жендерт суурилсан ажил үүргийн хуваарь тодорхой байдаг ч эр, эм хүмүүс ерөнхийдөө ижилхэн ашиг хүртэнэ. Бичил уурхай дахь ажил үүрэг болон ажиллах цагийн хуваарь хүйсээс шалтгаалан өөр байх хэд хэдэн шалтгаан бий. Үүнд: биеийн хүчний чадавхийн ялгаа, эмэгтэйчүүдийг хамгаалах хандлага, эрүүл мэндтэй холбоотой асуудлууд, эмэгтэйчүүдийн ар гэр, үр хүүхдээ асран хүмүүжүүлэх үүрэг, хариуцлага зэргийг дурдаж болно. Хэдийгээр эрэгтэй бичил уурхайчид долоо хоногт илүү олон цагаар ажиллаж, хүнд хүчир ажлыг нь нугалдаг ч уурхайгаас олсон ашгаа нөхөрлөлийн гишүүд эн тэнцүү хувааж авдаг.

Бичил уурхайн дэд салбар бүхэлдээ жендерийн тэгш байдал хангагдсан мэт харагддаг ч хэд хэдэн үзүүлэлтээс үүдээд уурхайчид тэр дундаа эрчүүд эмэгтэйчүүдийг бичил уурхайн ажилд тохиромжгүй хэмээн үздэг байна. Гэхдээ эмэгтэйчүүд эрчүүдээс илүүтэйгээр эмэгтэй бичил уурхайчдын чадвар, чадамжийн талаар илүү эерэг бодолтой аж. Харин энэ бүхнээс үл хамааран дийлэнх уурхайчид эр, эм хүмүүс аль аль нь уурхай эрхлэх болон бичил уурхайн нөхөрлөл, ТББ удирдах тал дээр адилхан ур чадвартай гэж үзжээ. Ажлын цагийн уян хатан байдал, нөхөрлөлийн гишүүдийн орлогын тэгш хуваарилалт, удирдах чадвараа сайжруулан бичил уурхайн тэргүүнээр ажиллаж, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх боломж зэргээс харахад бичил уурхай нь эмэгтэйчүүдийн хувьд амьжиргаагаа залгуулах боломжийн арга хэлбэр юм.

Агуулга

Товчилсон болон гадаад үгс	ii
Талархал	iii
Хураангуй	iv
1. Удиртгал	1
1.1 Ерөнхий мэдээлэл	1
1.2 Судалгааны зорилго	1
1.3 Тайлангийн загвар	1
2. Оршил	2
2.1 Монгол Улс	2
2.2 Монгол Улс дахь жендерийн харилцаа	3
2.3 Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэл	5
2.4 Монгол Улс дахь бичил уурхайн дэд салбар	7
2.5 Бичил уурхай болон жендертэй холбоотой Монгол Улсын бодлого, хууль эрх зүйн орчин	8
2.6 Монгол Улс дахь бичил уурхайн дэд салбар ба жендерийн асуудлууд	10
3. Арга зүй	14
3.1 Баримт, бичгийн судалгаа	14
3.2 НБХСХ-ын тоон мэдээлэл	14
3.3 Жендэрийн хээрийн судалгаа	14
3.3.1 Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг	16
3.3.2 Мэдээлэл цуглуулах ярилцлага	17
3.3.3 Бичил уурхайчид болон уурхайн ойр орчим худалдаа, үйлчилгээ үзүүлэгч иргэдтэй хийсэн ярилцлага	17
3.3.4 Ажиглалтын хуудас	19
3.4 Богино хэмжээний судалгаа	19
4. Үр дүн	20
4.1 Бичил уурхайн хүн амын хүн ам зүйн бүрдэл	20
4.2 Бичил уурхайчдын гэрийн ажлын үүрэг, хуваарилалт хүйсээр	22
4.3 Бичил уурхай дахь жендерт суурилсан хөдөлмөр хувиарлалт	24
4.4 Бичил уурхайн ажил эмэгтэйчүүдэд тохиромжтой юу?	29
4.5 Ажиллах цагийн ялгаа	31
4.6 Нөхөрлөл дэх эр, эм гишүүдийн хүлээх үүрэг, хариуцлага болон байр суурь.....	32
4.7 Бичил уурхай амьжиргаагаа залгуулах арга хэлбэр болох нь	34
4.8 Бэлгийн дарамт, хүчирхийлэл ба аюулгүй байдал	40

4.9	Эрүүл мэнд ба байгаль орчин	43
4.10	Уурхайд амжилттай ажиллахад тулгардаг жендерийн онцлог бүхий саад бэрхшээлүүд	46
5.	Хэлэлцүүлэг ба дүгнэлт	48
	Зөвлөмж	51
	Ашигласан материал	56
Хавсралт 1.	Судалгааны хэрэглэгдэхүүн	58
	Бичил уурхайд ажилладаггүй эмэгтэйчүүдтэй хийх ярилцлага	58
	Мэдээлэл цуглуулах ярилцлагын тайлбар	59
	Асуулга болон ярилцлага хосолсон хэлбэр	60
	Ажиглалтын хуудас	65
Хавсралт 2.		74

1. Удиртгал

1.1 Ерөнхий мэдээлэл

Швейцарийн хөгжлийн агентлагтай дэмжлэгтэйгээр АНУ-ын Азийн сан, Уул уурхайн яамтай хамтран “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийг 2013 оны 8 сараас эхэлсэн бөгөөд төсөл нийт 3.5 жилийн хугацаанд хэрэгжинэ. Төсөл орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, улмаар бичил уурхай эрхлэгчдийн зохистой ажлын байраар хангагдах эрхийг нь баталгаажуулах замаар орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой. Төсөл зорилгоо биелүүлэхийн тулд доорх гурван үр дүнд хүрнэ. Үүнд:

1. Эрх бүхий байгууллагууд нөхөн сэргээлтийн тогтвортой ногоон аргачлалыг батлана.
2. Бичил уурхайн байгаль орчны төлөвлөгөөг сумын түвшинд хамтын санхүүжилтээр хамтран хэрэгжүүлэх талаар оролцогч талууд зөвшилцөж, санал нэгдэнэ.
3. Орон нутгийн оролцогч талууд бичил уурхайн байгаль орчны төлөвлөгөөг хамтран санхүүжүүлж, хамтран хэрэгжүүлнэ.

1.2 Судалгааны зорилго

Энэхүү судалгаа нь бичил уурхайн дэд салбар дахь жендерийн нөхцөл байдлын талаар цогц дүн шинжилгээ хийж, *Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II* төслийн бүхий л үйл ажиллагаанд тусган уялдуулах үндсэн зорилготой. Жендерийн тэгш байдлын судалгааг хийснээр эр, эм хүйсийн хүмүүсийн хэрэгцээ шаардлага, хөдөлмөрийн хуваарь, оролцоо, нөөц боломж, хөрөнгийн хяналт, шийдвэр гаргах эрх мэдэл зэргийг тодорхойлж, төслийн хүрээнд жендерийн мэдрэмжтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх үндэс суурийг бий болгоно.

1.3 Тайлангийн загвар

Тайланг боловсруулахдаа Монгол Улсын тухай ерөнхий мэдээлэл, жендерийн харилцаа болон бичил уурхайн дэд салбарын тухай товч мэдээлэл, гутгаар хэсэгт ашигласан аргачлал болон мэдээллийн дүн шинжилгээний талаар товч тайлбар, дөтгөөр хэсэгт судалгааны үр дүнг оруулсан болно.

2. Оршил

2.1 Монгол Улс

Монгол улс нь БНХАУ болон ОХУ хооронд орших Хойд Азийн далайд гарцгүй орон (Зураг 1). Хоёр аравны найман сая хүн ам нь 1.5 сая хавтгай дөрвөлжин километр газар нутагт тархан суурьшсан бөгөөд дэлхийн хамгийн сийрэг суурьшилтай оронд тооцогддог. Хүн амыг хүйсээр нь авч үзвэл эмэгтэйчүүдийн тоо эрчүүдээс бага зэрэг илүү (Хүснэгт 1). Цаг уурын хувьд Монгол орон эрс тэс уур амьсгалтай урт хүйтэн өвлийн улиралтай бөгөөд 1-р сард дундаж температур -30 градус хүртэл буурна. Зарим жилүүдэд хахир хүйтэн, цас ихтэй өвлийн улмаас зуд болж хэдэн сая мал хорогддог. Харин зуны улирал нь богино, халуун байдаг.

Зураг 1: Аймаг болон голлох хотуудыг харуулсан Монгол улсын газрын зураг



Монгол улс 20-р зууны эхэн үед тусгаар тогтнолоо зарлаж, тэр үеэс хойш Зөвлөлтийн нөлөөнд ихээр автжээ. 1989 оны сүүл 1990 оны эхээр Монгол улсад ардчилсан хувьсгал өрнөж, коммунист дэглэм задран унаж, улмаар шинэ үндсэн хуулиа батлан, олон намын тогтолцоо бүхий зах зээлийн эдийн засагт шилжин орлоо. Шилжилтийн энэ хүнд үед улс орны эдийн засаг хямарч, ажилгүйдэл нэмэгдснээр албан бус салбар тэр дундаа хууль бусаар алт олборлох нь эрс нэмэгдэж, хүйсийн тэгш бус байдал илрэх болсон байна.

Монгол улсын ДНБ 10.3 тэрбум ам. доллар, нэг хүнд ногдох ҮНО 5,100 ам. долларт хүрснээр дундаас доош орлоготой орны тоонд багтан оров (Дэлхийн банк 2013 он). Монголын эдийн засгийн голлох салбар нь хөдөө аж ахуй болон уул уурхай юм. Монгол орон арвин их байгалийн нөөц, эрдэс баялагтай бөгөөд үйлдвэрлэлийн дийлэнх хувийг зэс, нүүрс, молибден, тугалга, вольфрам болон алт олборлолт эзэлдэг. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед эрдэс баялгийн томоохон ордуудыг ашиглалтанд оруулах нь эдийн засгийн өсөлтийг хангах чухал эх үүсвэр болдог. Монгол орны талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг мэдээлэл хуудсанд оруулав (Хүснэгт 1).

2.2 Монгол Улс дахь жендерийн харилцаа

Монгол улс дахь жендерийн хэв маяг бүрэлдэн тогтоход жаран жил үргэлжилсэн социалист нийгэм болон 1990-ээд оноос эхлэлтэй зах зээлийн эдийн засаг руу шилжих шилжилтийн үеийн нийгэм, соёлын хүчин зүйлс ихээхэн нөлөөлжээ. Социализмын үед эмэгтэйчүүдийн байр суурь улам бэхжиж, Зөвлөлт улсын тусламжтайгаар төрөөс охидын боловсролыг дэмжин ихээхэн хөрөнгө оруулалт хийсэн нь боловсролтой эмэгтэйчүүдийн шинэ үе бүрэлдэн тогтоход чухал нөлөө үзүүлэв. Улмаар эмэгтэйчүүд жирэмсний амралт авч, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдан, төрийн санхүүжилттэй цэцэрлэг, сургуульд үр хүүхдээ хүмүүжүүлэх болов. Ийнхүү эмэгтэйчүүдийн гэрийн ажил болон асаргаа сувилгааны ажилд зарцуулах цаг нь багассанаар хөдөлмөрийн зах зээлд эрчүүдтэй тэгш эрхтэйгээр оролцох болж, ижил хэмжээний цалин хөлс авах боломж бүрджээ (АХБ Монгол улс 2010 он).

“Хүйсийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” хэмээх Мянганы Хөгжлийн гуравдугаар зорилтыг Монгол улс хүлээн авч, хэрэгжүүлснээр хүний хөгжлийн чиглэлээр дорвитой ахиц гарахад нөлөөлсөн байна. Эмэгтэйчүүдийн мэргэжил, боловсролыг дээшлүүлэн, нийгэм, соёлын түвшинд эзлэх байр суурийг нь сайжруулж, улмаар хөгжлийн бодлого, хөтөлбөр дэх оролцоог илүү өргөн хүрээнд нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурал Мянганы Хөгжлийн гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэх тогтоолыг 2005 онд батлав. Зорилтын хэрэгжилтийн талаарх НҮБХХ-ийн Хүний хөгжлийн 2013 оны илтгэлд дурдсанаар, насанд хүрсэн эмэгтэйчүүдийн 83 хувь нь, эрэгтэйчүүдийн 81.8 хувь бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой аж.

Гэсэн ч жендерийн нөхцөл байдлыг (динамик) нарийн нягтлан харвал хүйсийн тэгш бус байдал Монгол Улсад оршин тогтносоор байна. Эрүүл мэнд, боловсролын үзүүлэлтүүдээр эмэгтэйчүүд илүү ч улс төр дэх оролцоо нь улам үр буурч, эрчүүд, эмэгтэйчүүдийн цалин хөлсний зөрүү нэмэгдэж, эдийн засгийн голлох салбаруудад эрчүүдийн давамгайлал бий болжээ. Нэг жишээ дурдахад 2012 онд улсын хэмжээний ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ 54.3 хувь, эрчүүдийнх 65.5 хувь байсан бол УИХ-ын гишүүдийн 12.7 хувь нь л эмэгтэйчүүд байв (НҮБХХ 2013 он). Эдийн засаг, хөдөлмөрийн зах зээл дээрх өөрчлөлт, үр хүүхдээ асрах, ар гэрийн ажил хийх болон тэтгэвэрт эрт гардаг зэрэг нийгмийн хүчин зүйлс эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг бууруулж байна. Азийн Хөгжлийн Банкнаас (2010 он) ‘Өнөөгийн нийгэм дэх жендерийн тэгш бус байдлыг нэн яаралтай шийдвэрлэхгүй бол урт хугацааны жендерийн асуудал үүсч мэднэ’ хэмээн анхааруулжээ. Эрчүүдийн дунд амиа хорлолтын түвшин өндөр, дундаж наслалт нь доогуур, архидалт их байдгаас гадна жендэрт суурилсан хүчирхийлэл болон ажилгүйдлээс шалтгаалан Монгол дахь жендерийн харилцаа улам бүр өөрчлөгдөж байна (эх сурвалж өмнөхтэй адил).

Хүснэгт 1. Монгол улсын тухай товчхон мэдээлэл

Үзүүлэлт	Хэмжээ
ГАЗАР ЗҮЙ, ХҮН АМ	
Нутаг дэвсгэрийн нийт хэмжээ	604,247 миль (1,565,000 км²)
Үржил шимт газар, нутгын хэмжээ	0.4% (2011)
Нийт хүн ам	2.78 сая (2010)
Эрэгтэй	1.35 сая
Эмэгтэй	1.43 сая
БОЛОВСРОЛ	
Бичиг үсэг тайлагдалт нийт (хүйсээр ялгаагүй)	97.4% (2010)
Сургуулийн элсэлт, бага сургууль (бага сургуулийн насны хүүхдийн эзлэх %), нийт (хүйсээр ялгаагүй)	98.8% (2011)
Их, дээд сургуульд элсэгчдийн хүйсийн харьцаа (хувиар)	1.5 : 1 (2011)
ЭРҮҮЛ МЭНД	
Дундаж наслалт- эмэгтэй	72.5 (2011)
Дундаж наслалт- эрэгтэй	64.6
ЭДИЙН ЗАСАГ	
ДНБ, ам. доллараар (2012 оны байдлаар)	US \$ 10.3 тэрбум
ДНБ-ийн жилийн өсөлт	12 %
Нэг хүнд ногдох ҮНО, ам.доллараар, PPP (2012оны байдлаар)	US\$ 5,100
Амьжиргааны доод түвшингээс доогуур амьдралтай хүн ам хувиар	27.4% (2012)
ХӨГЖИЛ	
Хүний Хөгжлийн Индексийн үзүүлэлтээр	186 орноос 108-т (НҮБ-ын ХХ 2013)
Сайжруулсан усны эх бүхий хөдөө орон нутгийн иргэдийн эзлэх хувь	53% (2011 оны тоо баримт)
Цахилгаан эрчим хүчинд холбогдсон хүн амын эзлэх хувь	86.2% (2010)
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	
Нийт хүн амын дунд ажиллах хүчний эзлэх хувь, (15-с дээш насны)	59.8% (2011)
Эрэгтэй	65.5%
Эмэгтэй	54.3%
Хөдөлмөр эрхэлж буй 7-14 насны эмэгтэй хүүхдийн эзлэх хувь	8.6% (2007 оны тоо баримт)
Хөдөлмөр эрхэлж буй 7-14 насны эрэгтэй хүүхдийн эзлэх хувь	11.4% (2007 оны тоо баримт)
ЖЕНДЕР	
CPIA жендэрийн тэгш байдлын үнэлгээ (1=муу 6=сайн)	4 (2012)
Өрхийн тэргүүн нь эмэгтэй гэр бүлийн эзлэх хувь (Өрх толгойлсон эмэгтэйчүүд)	28.5% (2008)
Жендерийн тэгш бус байдлын индексийн үзүүлэлтээр	148 орноос 56-р байранд (НҮБХХ 2013)
УИХ дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувь	14.9% (2012)
Сайдын түвшний албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн хувь	7.1% (2012)

Эх сурвалж: Дэлхийн банкны мэдээллийн сан, (өөрөөр заагаагүй бол) Монгол улс: <http://data.worldbank.org/country/mongolia>

2008 оны 9 дүгээр сарын өмнөхөн Монгол улсын эдийн засаг огцом өсч, нийгмийн халамжийн хүртээмж эрс нэмэгдэв. Энэ нь эмэгтэйчүүдэд тэр дундаа тогтмол ажил эрхэлдэггүй ядуу эмэгтэйчүүдэд ихээхэн тус нэмэр болов. Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг хамруулсан Хүүхдийн Мөнгө Хөтөлбөр (ХМХ) ядууст чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрийн эхний хөтөлбөр байсан бөгөөд хүүхэд бүрт сар бүр 3000 төгрөг (2.14 ам доллар) олгожээ. Харин 2012 оны 10-р сараас эхлэн Монгол улсын Засгийн газар 0-18 насны бүх хүүхдэд сар бүр 20,000 төгрөг (12.5 ам. доллар) олгож эхэлсэн байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг тогтмол өссөн ч тэгш бус байдал тэр дундаа хот, хөдөөгийн ялгаа нэмэгдэж, эмэгтэйчүүдийн албан бус салбарт (бичил уурхайг оролцуулаад) ажил хөдөлмөр эрхлэлт мөн ихэслээ. Албан бус салбар нь албан ёсны салбартай харьцуулахад цалин хөлс доогуур, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамруулдаггүй. Эмэгтэйчүүдийн хувьд ажилд орох боломж эрчүүдээс илүү хязгаарлагдмал бөгөөд цалин хөлс доогуур байхаас гадна бүхий л салбар, мэргэжлийн удирдах албан тушаал, менежерийн түвшинд гол төлөв эрчүүд ажилладаг байна (П.Болормаа 2011 он).

2.3 Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэл

Монгол улсын хэмжээнд жендерт суурилсан хүчирхийлэл тулгамдсан асуудлын нэг болжээ. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өнөөгийн нийгмийн “хамгийн тулгамдсан асуудлуудын нэг” хэмээн Иргэний Альянс Төв тэмдэглэсэн байдаг (ШХА ба ИАТ 2008 он). ШХА-ийн мэдээллээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл (бие махбодь, сэтгэл зүйн) сүүлийн жилүүдэд ихэссээр л байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэлийн талаар сүүлийн үеийн үнэн бодит тоо баримт олоход хэцүү ч олон төрлийн эх сурвалжийн мэдээллийг нэгтгэсэн тайлангаас харахад сэтгэл түгшээсэн дүр зураг нэгэнт үүсчээ. АХБ-ны тайланд дурдсанаар (2010 он) эмэгтэйчүүдийн гуравны нэг нь гол төлөв гэр бүл дотроо жендерт суурилсан хүчирхийлэлд ямар нэг байдлаар өртдөг байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв болон Хүүхдийн төлөө үндэсний газраас 1999 онд хийсэн эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай судалгаагаар арван эмэгтэй тутмын нэг, нийт хүүхдийн 60.2% хувь нь бие махбодийн хүчирхийлэлд өртөж байна (2003 оны НҮБ-ын ХАС-аас иш татав). Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын 98 хувь нь эмэгтэйчүүд юм. Харин АНУ-ын Төрийн департаментийн тайланд дурдсанаар 35-аас доош насны ажилгүй эмэгтэйчүүдийн тэн хагас нь ажлын байран дахь бэлгийн дарамтад өртсөн хохирогчид байдаг гэнэ.

ХЭҮТ, ИАТ болон Хүний эрх, хөгжил төвийн 2009 оны тайлан судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь гэр бүлийн хүчин буюу бэлгийн халдлагийн хохирогч байв. Гуравдагч тал энэ хэргийн тухай мэдээлж, хууль сахиулах байгууллага оролцохоос нааш гэр бүлийн хүчин буюу бэлгийн халдлага үргэлжилдэг хэмээн судалгаанд оролцогч гурван эмэгтэй тутмын нэг нь хариулжээ.

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид бусдаас ичин нөхцөл байдлыг нуун дарагдуулдагаас гэр бүлийн хүчирхийлэл ялангуяа танил болон гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг хүчин, бэлгийн халдлага цагдаагийн бүртгэл статистикт ямагт дутуу бүртгэгддэг. Энэ төрлийн гэмт хэргийн талаар статистик баримт тоо дутуу гардгийн бас нэгэн шалтгаан нь гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг зөвхөн бие махбодийн хүчирхийлэл мэтээр үзэж, харин сэтгэл зүйн дарамт хүчирхийллийг хүчирхийлэлд тооцдоггүйтэй холбоотой (НҮБ-ын ХАС 2003 он).

Түүнчлэн гэр бүл доторх бэлгийн хүчирхийлэл, үүнээс үүдэлтэй цус ойртолт зэргийг төдийлөн сайн тодорхойлоогүй аж (эх сурвалж өмнөхтэй адил).

ТББ-уудын хийсэн судалгаа Монгол улс дахь жендэрт суурилсан хучирхийллийн талаарх дүр зургийг гаргахад тодорхой хувь нэмэр оруулсан ч зарим судалгааны түүврийн хэмжээ маш бага байдгаас жендэрт суурилсан хучирхийлэл, цар хүрээ, тархалт болон бусад холбоотой асуудлын талаарх (жишээ нь согтууруулах ундааны хэрэглээ жендэрт суурилсан хучирхийлэл хоёрын хоорондын уялдаа, харилцан хамаарал гэх мэт) тоон болон чанарын найдвартай мэдээлэл дутагдалтай байсаар байна (АНУ-ын Азийн Сан 2013 он).

Гэр бүлийн болон жендэрт суурилсан хучирхийлэл ихсэх өөр нэгэн үндсэн шалтгаан нь эрчүүдийн ажилгүйдэл, эдийн засгийн хямрал, архидалт нэмэгдсэнтэй холбоотой (Пүрэвжав 2011 он; НҮБ-ын ХАС 2003 он). Ихэнх судалгаануудад эрчүүдийн архи, согтууруулах ундааны хэрэглээг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбон авч үздэг. Учир нь танилын хүрээнд үйлдэгддэг бэлгийн хүчирхийллийн талаарх судалгаанд хамрагдагсадын дийлэнх нь “согтууруулах ундааны хэрэглээ”-тэй холбон тайлбарлажээ (ХЭҮТ, ИАТ, ХЭХТ 2009 он).

АХБ-ны тайланд (2010 он) жендэрт суурилсан хучирхийлэл нэмэгдсэн шалтгааныг социалист нийгмээс зах зээлийн эдийн засагт шилжсэн шилжилтийн үетэй мөн холбон авч үзсэн байна. Тухайлбал, охид эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэрэг сүүлийн жилүүдэд гарсан үзэгдэл учраас дээрх гэмт хэргийн үндэс суурь, учир шалтгааныг төдийлөн тодорхойлж чадаагүй аж (АХБ 2010 он). Ажлын байран дахь бэлгийн дарамт нь жендэрт суурилсан хучирхийллийн нэг төрөл бөгөөд Монгол Улсын хувьд харьцангуй шинэ ойлголт юм (UNIFEM 2002 он, НҮБ-ын ХАС 2003 он).

Монгол Улс дахь бичил уурхайн дэд салбарт жендэрт суурилсан хучирхийлэл байдаг эсэх, ямар хэлбэрээр, хэр түгээмэл тохиолддог тухай маш бага мэдээлэл бий. НҮБ-ын ХАС-ийн (2007 он) бичил уурхай дахь ЖСХ-ийн талаар албан бус мэдээллээр энэ төрлийн гэмт хэрэг гол төлөв согтууруулах ундааны хэрэглээтэй холбогдон гардаг аж. Энэхүү тайланд дурдсанаар согтуурхсан бичил уурхайчид эмнэлгийн ажилчдын эсрэг аман болон биет түрэмгийлэл үзүүлдэг тухай нэгэн эмчийн хэлснийг иш татсан байна. Күйнсландын Их Сургуулийн Тогтвортой Ашигт малтмалын хүрээлэнгийн Уул уурхайн нийгмийн хариуцлагын төвөөс 2013 оны 1-10 сарын хооронд явуулсан “Монголын уул уурхайн суурин дахь жендэрт суурилсан хучирхийлэл болон уурхайн дэд бүтэц, харьцуулсан дүн шинжилгээ” сэдэвт судалгаа илүү дэлгэрэнгүй ойлголт, мэдээлэл өгөх нь дамжиггүй. Харамсалтай нь бид энэхүү судалгааны дүнтэй танилцаж амжсангүй.

Одоогоор хүмүүсийг бичил уурхайд ажиллуулахаар аль эсвэл биеийг нь үнэлүүлэх зорилгоор худалдаалдаг эсэх мэдээлэл олдоогүй. Мөн жендэрт суурилсан хучирхийлэл гардаг талаар нотлох баримт бүхий хоёрдогч эх сурвалжийн мэдээлэл ч ирээгүй болно.

Ерөнхийдөө улсын хэмжээнд (гэр бүлийн хүчирхийлэл болон хүн худалдаалах гэмт хэрэг нэмэгдсэн) эмэгтэйчүүд хамтран амьдрагч болон бусад эрчүүдийн зүгээс хучирхийлэлд өртөх эрсдэл нэмэгдсэн бөгөөд цаашдаа бичил уурхай дахь эр, эм хүмүүсийн харилцаанд нөлөөлөх магадлалтай.

2.4 Монгол Улс дахь бичил уурхайн дэд салбар

Бичил уурхайчдыг зөвшөөрөлгүйгээр, хуулиас гадуур ажилладагтай нь холбогдуулан *нинжа*ⁱ буюу хууль бусаар алт олборлогчид хэмээн нэрлэнэ. Сүүлийн жилүүдэд Монгол улсын засгийн газраас бичил уурхайн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарал хандуулж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журмыг 308-р тогтоолоор батлан, бичил уурхайчдыг нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулахаар хуульчилж өгөв. Хэдийгээр журам гарч, зохицуулалтын арга механизм бий болсон ч хууль бусаар ашигт малтмал олборлогч бичил уурхайчид оршсоор л байна.

Улсын хэмжээнд 30 мянгаас (АМГ 2005 он) 100 мянга (Грэйсон 2004 он) орчим бичил уурхай эрхлэгч иргэд байдаг гэсэн тоо бий. Нийт бичил уурхайчдыг 100 мянга гэж тооцвол Монгол улсын нийт ажиллах хүчний 20 хувьтай тэнцэнэ (Бжеррегаард 2009 он). Дэлхийн Банкны тооцоогоор бичил уурхайчид, уурхайн ойр орчим үйлчилгээ үзүүлэгч иргэд болон үүсмэл ажлын байр буюу уурхайгаас орлого олдог орон нутгийн жижиг бизнес эрхлэгчид (дэлгүүрийн эзэн, ажилтнууд, хоолны газрууд, болон бусад бизнес) зэрэг нийт 600 (хүн амын 20 хувь) орчим мянган Монголчууд ямар нэг хэмжээгээр бичил уурхайгаас хамааралтай болохыг үгүйсгэхгүй. (Эфтимий 2012 он). 2013 оны 1-р сарын байдлаар ШХА-ийн ТБУ төслийн тооцоолсноор 5000 орчим бичил уурхай эрхлэгчид нөхөрлөлд нэгджээ. Энэхүү судалгаанд хамрагдсан бичил уурхайчид бүгд зохион байгуулалтанд орж, нөхөрлөл байгуулсан иргэд байлаа. Тэд өөрсдийгөө *нинжа* гэж нэрлэдэггүй, харин албан ёсоор зохион байгуулалтанд орж, орон нутгийн удирдлагатайгаа аман гэрээ байгуулан ажиллаж байгаа бичил уурхайчид гэсэн юм. “Нинжа” хэмээх энэ нэр өөрөө сөрөг утгатай учраас тэд энэ нэрэнд дургүй ажээ.

1997-2002 оны хооронд болсон хахир хүйтэн өвөл, цас зудны улмаас хэдэн зуун толгой мал хорогдож, олон мянган айл өрх амьжиргааны эх үүсвэргүй болсноор бичил уурхай хүчээ авч эхлэв. Мөн нөлөө бүхий эрх мэдэлтэнгүүд ч байгалийн баялгийг хараа хяналтгүй, дураар олборлож эхэлсэн байна. Ийнхүү арвин их байгалийн баялаг, харьцангуй либерал гэмээр ашигт малтмалын хууль зэргээс үүдэн хөдөө орон нутгийн иргэд бичил уурхай руу хошуурчээ (Пүрэвжав 2011 он). Өнөөдөр бичил уурхайн дэд салбараас МУ-ын ДНБ-нд жил бүр 811 сая гаруй ам.доллартай тэнцэх орлого төвлөрч, (Эфтимий 2012 он) дээр нь тухайн орон нутагт уул уурхайтай холбоотой үйл ажиллагаанд жилдээ 505 сая орчим ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгийг зарцуулж байна.

Бараг бүх аймагт бичил уурхай хөгжиж, малчид, тэтгэвэрийн хөгшид, ажилгүйчүүд, бага цалинтай ажлаа түр хугацаагаар болон бүр мөсөн орхисон иргэд, дампуурсан бизнес эрхлэгчид зэрэг олон төрлийн ажил мэргэжилтэй хүмүүс ажиллах болов (Бжеррегаард 2009 он). Мөн зуны амралтаараа оюутнууд эцэг, эхийнхээ хамтаар сургалтын төлбөрөө олох зорилгоор алтны орд дээр ажиллах болсон байна. Хэдийгээр бичил уурхайгаас их хэмжээний олз олох нь ховорхон ч нэг *нинжа* долоо хоногт дунджаар 10 ам. доллар олдог гэсэн судалгаа бий (Грэйнгер 2013 он). Ийнхүү Монгол улсын шилжилт хөдөлгөөний нэг шалтгаан нь бичил уурхай болж, зарим гэр бүл, хувь хүмүүс түр хугацаагаар оршин суудаг бол нөгөө хэсэг нь тухайн газартаа нэгмөсөн шилжин ирдэг болжээ (IPEC 2007 он). Бидний олж мэдсэнээр хууль бус бичил уурхайд ажиллахаар бусад улс орноос Монгол улсад ирсэн хүн тэнгэрийн од шиг цөөн буюу бараг байхгүй.

ⁱ Ногоон, хуванцар хувин нуруун дээрээ үүрсэн хууль бус бичил уурхайчид “Нинжа яст мэлхий” хүүхэлдэйн киноны дүртэй адилхан харагддаг учраас “Нинжа” хэмээх нэр томъёо үүсчээ. (Бжеррегаард 2009)

Энгийн тоног төхөөрөмж болон биеийн хүч, тэсвэр тэвчээртээ тулгуурлан ажиллах бичил уурхайчид бие даан аль эсвэл цөөн хүний бүрэлдэхүүнтэй бүлэг болон ажилладаг. Бичил уурхайчид олон төрлийн эрдэс олборлодог ч хамгийн түгээмэл нь алт, жонш болон нүүрс юм. Гэхдээ голдуу алт олборлох бөгөөд алтны үндсэн орд, шороон орд гэсэн хоёр төрлийн алтны орд дээр ажилладаг. Ямар төрлийн эрдэс олборлож байгаагаас шалтгаалан уурхайн ажиллагаа өөр ч ихэнхдээ нүх, түнел ухах, ус зайлуулах, хөрсийг хөндийлөх, өрөмдөх, тэслэх, бутлах, боловсруулах, усыг гадагшлуулах замаар олборлолт хийнэ (IPEC 2007 он).

Албан бусаар бичил уурхай эрхлэгчдийн 15-18 орчим хувийг хүүхдүүд эзэлдэг байх магадлалтай бөгөөд сургуулийн амралтын үеэр энэ тоо хоёр дахин нэмэгддэг байна. Тэдний 21.5 хувь нь алтны уурхайд, 15 хувь нь жоншны уурхайд ажилладаг (ОУХБ 2007 он). Бичил уурхайд ажиллаж буй хүүхдүүд олон цагаар нарийхан, бөгчим, тоос шороотой, хүчилтөрөгч бага нүх, түнелд ажиллах бөгөөд тэдний хөдөлмөрийг ОУ-ын хэмжээнд хамгийн хүнд хүчир хөдөлмөрт тооцдог. Хүүхдүүдийн дийлэнх нь өөртөө ахадсан хүнд зүйл өргөхөөс гадна мөнгөн ус бүхий хортой нөхцөлд ажиллаж байна. Нэг хэсэг нь хурц үзүүртэй эргэдэг тоног төхөөрөмж дээр ажиллах бол нөгөө хэсэг нь тэсэрч дэлбэрэх бодистой байнга харьцана (ОУХБ 2007 он). Ихэнх хүүхдүүд 12 наснаас эхлэн уурхай дээр ажилладаг ч 8 нас хүрээгүй байхдаа ажиллаж эхэлсэн хүүхдүүд ч мөн бий. Дээрх хүүхдүүдийн тал хувь нь 15-17 насныхан бол 20 орчим хувь нь 5-12 настай бөгөөд насанд хүрэгсэдтэй мөр зэрэгцэн уурхайн бараг бүхий л үйл ажиллагаанд оролцож байна (IPEC 2007 он).

Дэлхийн бусад улс орнуудын уул уурхай, тэр дундаа бичил уурхайд хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг их байдаг тухай баримт нотолгоо бий (Азийн сан 2008 он). Азийн Хөгжлийн Банкнаас 2010 онд гаргасан жендерийн тэгш байдлын судалгаанд хүний наймааны талаар “Хүний наймааны цар хүрээ болон арга барил улам бүр өөрчлөгдөж, илүү зохион байгуулалттай, өргөн хүрээг хамрах болсон” гэжээ. Монгол орны хувьд охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрчүүдийг бичил уурхайд ажиллуулахаар тээвэрлэн авчирсан ч байж болно. Гэсэн хэдий ч энэ тухай тодорхой судалгаа, мэдээлэл байхгүй.

2.5 Бичил уурхай болон жендертэй холбоотой Монгол Улсын бодлого, хууль эрх зүйн орчин

Хүйсийн тэгш байдлыг хангах үүднээс Монгол улс **Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль** зэрэг нилээд хэдэн хууль тогтоомжуудыг батлан гаргасан (Пүрэвжав 2011 он). МУ-ын Үндсэн хуулийн 14-р зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш” хэмээн заасан байдаг (МУ-ын Засгийн газар 1992 он). Мөн хүйсээр нь ялгаварлан гадуурхахыг хориглож “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүн бүр тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ...” (эх сурвалж өмнөхтэй адил) хэмээн заажээ.

1999 онд батлагдаж, 2003 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Хөдөлмөрийн тухай хуулинд хөдөлмөр эрхлэхэд хүйсээр нь ялгаварлан гадуурхах, жирэмсэн болон хөхүүл, мөн бага насны хүүхэдтэй эхчүүд (3-аас доош насны хүүхэдтэй) болон ганц бие, өрх толгойлсон эхчүүдийн эрхийг хамгаалсан заалтууд бий (МУ-ын Засгийн газар 2003 он). Харамсалтай нь дээрх заалтууд албан бус хөдөлмөр эрхлэлтэнд төдийлөн хэрэгждэггүй.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 онд, **Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль** 2012 онд тус тус батлагдсан нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд нэг чухал алхам болов.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод (2007-2021 он) хүйсийн тэгш бус байдлыг 2015 он гэхэд арилгана хэмээн заасан (МУ-ын Засгийн газар 2008 он). Монгол Улсад хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах бодлогод (4.2 хэсэг) “Жендэрийн тэгш байдлыг гэр бүл, эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, хүний эрхийн хүрээнд хангах бодлогыг хэрэгжүүлнэ” гэжээ. Түүнчлэн Монгол улс “өмчийн болон хөдөлмөрийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийг адил, тэгш оролцуулах соёлыг хэвшүүлэх” зорилт дэвшүүлэн ажиллаж байна (эх сурвалж өмнөхтэй адил).

Уул уурхай, байгалийн баялагтай холбогдуулан **Монгол Улсын Үндсэн хуулинд** “Газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц төрийн өмч мөн” хэмээн зааж өгсөн. Иргэнд газар өмчлүүлэхэд газрын хэвлий хамаардаггүй (6-р зүйл). Газрын хэвлий дэх эрдэс баялгийг **Ашигт малтмалын тухай хуулиар** (2006 он) зохицуулна. Уул уурхайн компаниуд Ашигт Малтмалын Газраас олгодог тусгай зөвшөөрөл болон тухайн орон нутгийн засаг захиргаатай байгуулсан газар, ус ашиглах тухай гэрээний үндсэн дээр хайгуул, олборлолт хийдэг. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хүйсийн ялгаа, ялгаварлан гадуурхалт байдаг эсэх тухай ямар нэгэн судалгаа одоогоор хийгдээгүй байна. Бидний хийсэн хээрийн судалгааны үеэр орон нутгийн захиргаа, доод шатны нутгийн захиргааны байгууллагын түвшинд яриа хэлэлцээр, нөлөөлөл хийхэд эмэгтэйчүүдийн нөлөө их байдгийг олонтаа дурдсан. 2010 онд МУ-ын Засгийн газар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, улмаар **“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох”** журмыг баталсан (МУ-ын Засгийн газрын 308-р тогтоол). Бичил уурхайн дэд салбарын хууль эрх зүйн хүрээг тодорхойлсон энэхүү баримт бичигт 18-аас доош насны хүүхлийг бичил уурхайд ажиллахыг хориглосон юм. Тус тогтоолоос өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан ЗГ-ын 72-р тогтоолоор жирэмсэн болон 0-3 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг бичил уурхайд ажиллахыг мөн хориглосон байсан. Харин шинэ тогтоол, журмаар бичил уурхай дахь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар тодорхой заалт оруулаагүй байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд зааснаар хууль ёсоор бичил уурхай эрхэлж, нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдахын тулд иргэн өөрөө тухайн орон нутгийн оршин суугч байх аль эсвэл бүртгүүлсэн байх ёстой (308-р тогтоолын 7.4.3). Өнөөдөр бичил уурхайчид тухайн орон нутаг, сумандаа бүртгэлгүй нь тэдэнд тулгарч буй гол бэрхшээл юм. Оршин суугчаар бүртгүүлэхэд жендерийн үүднээс хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх талаар тодорхой мэдээлэл байхгүй.

Хууль эрх зүйн бас нэгэн чухал баримт бичиг **“Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”** (2006 он)-ийн хүрээнд албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, хууль эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгаалалд хамруулах үүргийг Засгийн газар хариуцах болов. Ингэснээр халамж, үйлчилгээг хүртэхийн тулд тухайн иргэн ажиллаж байгаа сумандаа бүртгүүлсэн байхыг шаардах болжээ. Харамсалтай нь бичил уурхайчдын ажлын нөхцөл, амьдралын хөдөлгөөнт хэв маяг болон бүртгэл хийлгэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлээс үүдээд ихэнх нь бүртгэл хийлгэдэггүй нь хэд хэдэн судалгааны дүнгээс харагдаж байна.

МУ-ын **Үндсэн хууль, Газрын хэвлийн тухай хууль** болон **Усны тухай** хуулиуд уул уурхайн салбарт нэгэн адил мөрдөгдөнө. Эдгээр хуулиудад жендертэй холбоотой буюу аль нэг хүйсийг нөгөөхөөс нь илүүчилсэн зүйл заалт байхгүй. Гэсэн ч хуулийн хэрэгжилтийн явцад эр, эм хүмүүс адил тэгш эрх эдэлж чаддаггүй байх магадлал өндөр бөгөөд энэ судалгаагаар энэ асуудлыг хөндсөн болно.

2.6 Монгол Улс дахь бичил уурхайн дэд салбар ба жендерийн асуудлууд

Монгол улсын бичил уурхайн салбарт харьцангуй олон эмэгтэйчүүд ажиллаж байгаа нь тэдний хүсэл, сонирхолтой холбоотой хэмээн П.Болормаа, АНУ-ын Азийн сангийн БО хөтөлбөрийн Ахлах Зөвлөх тайлбарласан байдаг. Түүний бичсэнээр:

...Уул уурхайн томоохон компаниудад эмэгтэйчүүд ажиллах боломж хомс. Тэгээд ч ядуурлын түвшин хөдөө орон нутагт улам бүр нэмэгдсээр байна. Монгол улс жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр бодлогын үүрэг амлалт авсан ч эмэгтэйчүүд өөрсдөө хөдөлмөр эрхлэх тэгш эрхийнхээ төлөө зүтгэж байна. Иймд тэд уул уурхайн томоохон компаниудтай харьцуулахад тавигдах шаардлага, шалгуур багатайгаар нь бичил уурхай руу ихээр татагддаг... (2011: 197) гэжээ.

Бичил уурхайн чиглэлээр өмнө хийгдсэн бусад судалгаануудад жендерийн асуудлыг тусгайлан авч үзээгүй, ихэнх тоо баримтуудыг нэгдмэл байдлаар гаргасан байдаг нь эр, эм хүмүүсийн туршлага, үзэл бодлыг ялган, салгаж авч үзэх боломжгүй болгожээ. Гэхдээ энэхүү судалгааг хийх явцад Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын хүн амын сан/Монголын нийгмийн эрүүл мэндийн сургууль болон зарим Монголын зарим судлаачид бичил уурхай дахь эр, эм хүмүүсийн оролцооны ялгаатай тал, хоорондын харилцааны талаар урьдчилсан мэдээлэл, ойлголтоо бидэнтэй хуваалцсан. Дээрх санал бодлыг мөн багцлан орууллаа.

Хүн амын жендерийн тэнцвэргүй байдал

- Бичил уурхайчдийн дийлэнх нь эрчүүд бөгөөд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 19.4 хувь (Навч болон бусад 2006 он), 35.3 хувь (НҮБ-ын Хүн амын сан болон Нийгмийн эрүүл мэндийн сургууль 2007 он), 40-45 хувь (АХБ 2010 он), 45-50 хувь (Бжеррегаард 2009 он) хэмээн хувьчлан гаргасан хэд хэдэн тоо баримт байдаг.
- ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын судалгааны дүнгээс харахад уул уурхайд үндсэн болон туслах ажил хийдэг хүүхдүүдийн 70-82 хувь нь эрэгтэй хүүхэд байх боломжтой (ИРЕС 2007 он; Навч болон бусад 2006 он). Гэхдээ зарим аймагт эрэгтэй, эмэгтэй хүүхдийн харьцаа тэнцүү, зарим тохиолдолд эмэгтэй хүүхдүүдийн тоо давамгайлах нь ч бий.
- Ерөнхийдөө эрчүүд нь эмэгтэйчүүдээсээ насны хувьд илүү залуу. (Навч болон бусад 2006 он; НҮБ-ын ХАС/Нийгмийн эрүүл мэндийн сургууль 2007 он)
- Бичил уурхайчин эрчүүд гол төлөв ганц бие бол эмэгтэйчүүдийн ихэнх нь гэр бүлтэй. (НҮБ-ын ХАС/Нийгмийн эрүүл мэндийн сургууль 2007 он)
- Эмэгтэйчүүд нь эрчүүдээсээ боловсролын түвшингээр өндөр. (НҮБ-ын ХАС/Нийгмийн эрүүл мэндийн сургууль 2007 он).

Уурхай, уурхайн эргэн тойрон дахь ажил, үйлчилгээ болон ажлын ачаалал жендерээс хамааралтай.

- Алтны шороон ордонд хөрөнгө оруулалт тэглээ шаардагдахгүй, дээр нь 4-5 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг болон ажиллах шаардлага байдаггүй тул эмэгтэйчүүд алтны шороон орд дээр илүүтэй ажиллана.
- Эр, эм хүмүүсийн бие бялдрын хөгжил ялгаатай байдгаас үүдэн бичил уурхай болон гэр бүл доторх ажил, үүргийн хуваарь өөр. Эрчүүд уурхай дээр чулуу бутлах, тэслэх, ухах зэрэг хүнд ажлыг голлон хийх бол эмэгтэйчүүд алт угаах, газрын гадарга дээрх туслах ажлуудыг хариуцна. (Бжеррегаард 2009 он). Эмэгтэйчүүд ихэвчлэн алт ялган авахын тулд хөрсийг хуулан, түмпэнд хийж угаах, ус зөөх зэрэг ажлуудыг хийдэг (НҮБ-ын ХАС/Нийгмийн эрүүл мэндийн сургууль 2007 он). Өрөмдөх, тэслэх зэрэг хүнд ажлыг зөвхөн эрчүүд хийх бөгөөд бусад ажлын хувьд хүйсийн ялгаа байхгүй (Навч болон бусад 2006 он).
- Эмэгтэйчүүд ялангуяа залуу бүсгүйчүүд биеийн хувьд эрчүүдээс жижиг, илүү уян хатан тул "түннел ухагч" хийх нь элбэг бөгөөд газар доогуур мөлхөн нүх ухна. Заримдаа тэр нүх нь 15 метр хүртэл гүнзгий (Бжеррегаард 2009 он).
- Эмэгтэйчүүд уурхайн ажил эрхэлдэг эсэхээс үл хамааран гэрийн ажлаа давхар хийж, үр хүүхдээ асарна (Бжеррегаард 2009 он) Өөрөөр хэлбэл эрчүүдээс хоёр дахин их ачаалалтай. Шинээр шилжин ирсэн эмэгтэйчүүдийн хувьд гэр бүл, найз нөхдөөсөө хол, тусалж дэмжих хүнгүйн улмаас давхар ажлыг амжуулахад нилээд хүндрэлтэй аж.
- Мөнгөн устай холбоотойгоор эр, эм хүйсийн ялгааны талаар судалгааны тайлангуудад зөрүүтэй мэдээлсэн байдаг. НҮБ-ын ХАС/Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн 2007 онд хийсэн судалгаанд мөнгөн усаар алт бариулах ажлыг эрчүүд голдуу хийдэг гэсэн бол олон улсын хөдөлмөрийн байгууллагын хууль бус алт олборлолтын талаар хийсэн судалгааны тайланд (Навч болон бусад 2006 он) эмэгтэйчүүд илүүтэй оролцдог гэжээ. (Мөн Бжеррегаард 2009 он харна уу).
- Эрчүүд эмэгтэйчүүдийг бодвол жилийн дөрвөн улиралд ямар нэг амралтгүйгээр ажилладаг ч хүйсийн хувьд төдийлөн ялгаагүй (Навч болон бусад 2006 он).
- Эмэгтэйчүүд гэр орны ажлаа хийх, үр хүүхдээ харж хандах үүрэгтэй учраас уурхай дээр түр хугацаагаар ажиллах нь элбэг. Харин эрчүүд илүү олон өдөр/долоо хоногоор ажилладаг ч тийм ч их зөрөөгүй.
- Бичил уурхай дахь хүүхдүүдийн хувьд хөвгүүд охидоос илүү олон цагаар ажилладаг байна (Өдөрт хөвгүүд 11.4 цаг, охид 8.7 цаг; Навч болон бусад 2006 он).
- Бичил уурхайчин эмэгтэйчүүд орон гэрээсээ олон хоног, сараар хол байх нь бий. Тиймээс хамгийн бага хүүхдээ уурхай руу авч явдаг байна. Харин сургуулийн насны хүүхдүүд нь ах эгч нарынхаа асрамжинд гэртээ үлдэнэ. Ихэвчлэн айлын том охид дүү нараа харж, хандах үүргийг хүлээх аж.
- Уурхай дахь эмэгтэйчүүдийн бие үнэлэлтийн талаар зарим нэг мэдээлэл байдаг ч эрчүүдийн бие үнэлэлтийн талаар ямар нэг мэдээлэл байхгүй.

Жендерт суурилсан орлогын ялгаа

- Эрчүүд эмэгтэйчүүдээс илүү их ашигт малтмал олборлож, энэ хэрээрээ ч орлого ихтэй.
- Хүүхдүүдийн дунд ч гэсэн хөвгүүд охидоос илүү аж. ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагаас 2006 онд хийсэн хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгаанаас харахад хөвгүүд сард дунджаар 6.1 гр алт олборлодог бол охид 5.7 гр алт олборлодог гэжээ. Жоншны бичил уурхайд ажилладаг хөвгүүд сард дунджаар 14.3 тонн, харин охид 5.1 тонн буюу хөвгүүдээс даруй 3 дахин бага ашигт малтмал олборлодог байна.

Уурхайтай холбоотой ажлын байр, эрүүл мэндийн эрсдлүүдийг хүйсээр нь ялган харах нь

- Эрчүүд осолд илүүтэй өртдөг. НҮБ-ын Хүн амын сан болон Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн 2007 онд хийсэн судалгаагаар эрчүүдийн осолд өртсөн тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2.4 дахин их байна.
- Өнөөг хүртэл Монголд хийгдсэн судалгаа, бусад баримт мэдээллээс харахад мөнгөн ус ашиглан хүдэр баяжуулах үйл ажиллагаан дахь эр, эм хүмүүсийн оролцооны талаар зөрүүтэй мэдээлэл их. Мөнгөн устай ойр ажиллах нь жирэмсэн эмэгтэйчүүд болон урагт нэн аюултай.
- Бичил уурхай эрхэлдэг хүүхдүүдийн хувьд хөвгүүд охидоос илүү осолд өртдөг.
- Эрчүүд согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх нь их учраас эрүүл мэндээр доройтохоос гадна ажлын байрандаа эрсдэлд ордог ажээ.
- Эмэгтэй бичил уурхайчид олон согтуу эрчүүдийн дунд айдастай ажиллаж, амьдарч байдгаа илэрхийлсэн. Согтуу эрчүүд догшин ширүүн зан авир гаргах, зодолдох явдал их гардаг. Иймд эмэгтэйчүүд согтуу эрчүүдтэй тааралдахгүйн тулд үйл хөдлөлөө хүртэл хязгаарладаг гэнэ. (Бжеррегаар 2009 он).
- Бие даан бичил уурхай эрхэлж байгаа, ганц бие болон өрх толгойлсон эмэгтэйчүүд хамгаалах хүнгүйн улмаас архи ууж согтуурсан эрчүүдийн хүчирхийлэлд илүүтэй өртөнө.
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл Монгол улсын хэмжээнд ноцтой асуудал нэгэнт болжээ. Бие махбодь болон сэтгэл зүйн хувьд хохиролтой дээрх хүчирхийлэл бичил уурхайн сууринд шилжин суурьшсан эмэгтэйчүүд ойр дотны хүрээлэл болох гэр бүл, найз нөхдөөсөө хол байдгаас үүдээд илүүтэй өртдөг байна. (Бжеррегаард 2009 он).
- Хөвгүүд охидоос илүүтэйгээр архи, тамхи хэрэглэдэг.
- АНУ-ын Азийн сангийн өөр нэгэн судалгаа уурхайн суурьшлын бүсд эмэгтэйчүүд бие үнэлдэг болохыг тогтоосон. Монгол улсад өнөөг хүртэл хийгдсэн судалгаанууд охидын бие үнэлэлтийн талаар тодорхой нотлох баримтгүй, гол төлөв цуу яриаг үндэслэсэн байдаг. Харин эрчүүд, хөвгүүд бие үнэлдэг талаар ямар нэгэн мэдээлэл, баримт огт байдаггүй.
- Уурхайн суурьшлын бүст охид, эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийллийн хохирогч болох эрсдэл өндөр. Гэхдээ энэ төрлийн гэмт хэрэг хэр түгээмэл гардаг болон хэр өргөн тархсан нь тодорхойгүй. (НҮБ-ын ХАС/Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль 2007 он)
- Уурхайн суурьшлын бүс дэх сургуулийн насны охид жирэмслэх, үр хөндүүлэх, бэлгийн замын халдвар авах үзэгдэл нэмэгдэж байгааг эмнэлэгийн ажилтнууд мэдээлсэн. (НҮБ-ын ХАС/Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль 2007 он)
- Бэлгийн замын халдварт өвчин ихэссэн нь эр, эм хүмүүст аль алинд нь нөлөөлж байна. Ялангуяа охид эмэгтэйчүүдийн өвчин авах магадлал өндөр.
- Газар дор, усан дотор хүнд нөхцөлд ажилладаг тул бичил уурхайчин эмэгтэйчүүдийн хувьд бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад давсаг шээсний замын үрэвсэл, эмэгтэйчүүдийн өвчин тусах, жирэмсэний болон төрөх явцад хүндрэл гарах магадлал илүү өндөр.
- Бичил уурхайчин эмэгтэйчүүд бүртгэлгүйн улмаас жирэмсэн байх хугацаандаа төрөхийн өмнөх үзлэг, эмчилгээг хүртэж чаддаггүй (НҮБ-ын Хүн амын сан 2007 он).
- Уурхайн үйл ажиллагаатай холбоотой усны бохирдол тухайн орон нутгийн иргэдийн тулгамдсан асуудал болоод байна. Өрхийн усны хэрэглээг бүрдүүлэгч гол хүн нь эмэгтэйчүүд байдаг учраас эрчүүдээс илүүтэйгээр эмэгтэйчүүдэд энэ асуудал нөлөөлнө. (Бжеррегаард 2009 он). Бохирдол ихтэй орчинд цэвэр ус олох нь цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардана.
- Уурхайн суурьшлын бүс эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж чаддаггүй тул өвчлөл ихтэй. Ялангуяа хүүхдүүд их өвдөнө. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь өвдсөн тохиолдолд тэднийг асрах үүргийг эмэгтэйчүүд хүлээнэ (Бжеррегаард 2009 он).

Нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж

- Уурхайд ажилладаг эмэгтэйчүүд эрчүүдээс илүүтэйгээр эрүүл мэндийн даатгалд хамрагджээ (НҮБ-ын ХАС/Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль 2007 он).
- Эмэгтэйчүүд эрчүүдээс хоёр дахин илүүтэйгээр уурхайн суурьшлын бүс дэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шаардсан байна.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж хомс байдаг нь эмэгтэйчүүдэд илүү нөлөөлдөг байна. Тэд өвчтэй хүүхэд болон бусад хамаатан саднаа асарч хамгаалах үүрэгтэй. Мөн шаардлагатай тохиолдолд эмнэлэгт үзүүлэх хэрэгтэй болдог.
- Өөр нэгэн судалгааны дүнгээс харахад эмэгтэйчүүд гэмтэл бэртэл авсан үедээ өөрөө өөрийгөө эмчлэх гэж оролдох нь их бол эрчүүд гэмтсэн үедээ тогтмол эмнэлгийн үйлчилгээ авдаг гэнэ (Бжеррегаард 2009 он).

“Ази-номхон далайн эмэгтэйчүүд, хууль, хөгжил” форумаас бичил уурхай эрхлэгч эмэгтэйчүүдийн дунд явуулсан судалгааны дүгнэлтэнд:

“Эрүүл мэнд болон аюулгүй байдал эмэгтэй нинжа нарын хамгийн их сэтгэл түгшээсэн асуудал байна. Дээр нь ажлын ачаалал хүнд, үр хүүхдээсээ хол байх, түүнчлэн залуу охидын архи согтууруулах ундааны хэрэглээ зэрэг нь тэдэнд тулгардаг бусад бэрхшээлүүд юм”(Бжеррегаард 2009:39) гэжээ.

3. Арга зүй

Судалгааны дараагийн хэсэгт тусгасан үр дүнг хоёр төрлийн мэдээллийн эх үүсвэрээс цуглуулсан болно. Эхнийх нь Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгээс Монгол орон даяар бичил уурхайн сайтуудаас авсан судалгааны тоон баримт бол нөгөөх нь гурван бичил уурхай дээр ажиллаж, цуглуулсан чанарын судалгааны баримт юм. Мэдээлэл цуглуулсан аргуудыг дэлгэрэнгүй тайлбарлав.

3.1 Баримт, бичгийн судалгаа

Эрдэм шинжилгээний ажлууд, судалгааны тайлангууд, хууль эрх зүйн баримт бичгүүд, вэб хуудас, албан бус бичвэрүүд зэрэг Монгол дахь бичил уурхайн дэд салбартай холбоотой бүхий л хэвлэн нийтлэгдсэн баримт бичгийг тус судалгааны зөвлөх нягтлан, шүүж үзсэн болно. Дээрх баримт бичгүүд МУ-ын Засгийн газар, ОУ-ын байгууллагууд (ОУХБ, АНУ-ын Азийн сан, ШХА), бие даасан зөвлөхүүд, судлаачид болон Уул уурхайн яам болон ШХА-ийн хамтран хэрэгжүүлж буй Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд Монгол дахь бичил уурхайн амьдрах болон ажиллах орчны талаар урьдчилсан ойлголттой болоход дөхөм үзүүлж, улмаар илүү нарийвчилсан асуулга боловсруулахад ашиглагдсан болно. Түүчлэн, чанарын болон тоон судалгаанд хамрагдаагүй албан бус бичил уурхайн талаар тодорхой мэдээлэл авлаа.

3.2 НБХСХ-ын тоон мэдээлэл

НБХСХ нь зохион байгуулалтанд орсон 1855 бичил уурхайчдыг хамарсан судалгааг 2013 оны 8 сарын 20-оос 10 сарын 14-ний хооронд хийсэн бөгөөд бичил уурхайчдын ажил, үүргийн талаарх төрөл бүрийн асуулт бүхий асуулгыг ашиглав. Мөн жендэртэй холбоотой асуудлыг тодорхойлох үүднээс жендэрийн зөвлөхийн дэмжлэгтэйгээр үнэлгээ хийх зорилгоор 16 асуултын хариулт бүхий мэдээллийг авсан. Судалгаанд тоон үзүүлэлтүүдийг ашиглах бүртээ НБХСХ-ийн судалгааны талаар дурдсан болно. Судалгаанд зөвхөн зохион байгуулалтанд орсон бичил уурхайг хамруулсан тул судалгааны үр дүн албан бус бичил уурхайн салбарын нөхцөл байдлыг бүрэн дүүрэн харуулаагүй байхыг үгүйсгэхгүй.

3.3 Жендэрийн хээрийн судалгаа

2013 оны 8-р сарын 11-17ны хооронд жендэрийн судалгааны баг гурван өөр уурхай дээр ажиллаж, бичил уурхай эрхлэгч эр, эм хүмүүсийн үүрэг, хариуцлага болон хоорондын харилцааны талаар мэдээлэл цуглуулав. Жендэрийн судалгааны багт зөвлөх болон бичил уурхай болон жендэрийн судалгаа хийж байсан туршлага бүхий АНУ-ын Азийн сангийн дөрвөн ажилтан ажилласан болно. Судалгааг:

1. **Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон дахь “Буданч” алтны үндсэн орд**
Улаанбаатар хотоос 135 орчим км-ийн зайд оршино. Түнхэл дэх эмнэлэг, сургууль, төрийн захиргааны байгууллагууд нь дээрх бичил уурхайтай хамгийн ойр бөгөөд тус тосгоноос бичил уурхайн газарт хүрэхийн тулд шороон замаар 20 орчим км явдаг. Бичил уурхайн сууринд уурхайчид гэр болон модон байшинд амьдардаг бөгөөд гэрэл цахилгаанд холбогдоогүй тул оройдоо лаа ашиглана. Буданчийн алтны үндсэн ордод нийт 30-40 хүний бүрэлдэхүүнтэй таван нөхөрлөл идэвхтэй ажиллаж байлаа. Тэдний ердөө 3-4 нь л эмэгтэйчүүд байв (10 хувь). Түнхэл багтай харьцангуй ойрхон учраас уурхайчид хоол хүнсээ гол төлөв тосгоноос авдаг байна. Иймд уурхайн ойр орчим хүнсний худалдаа

эрхлэгчид байсангүй. Уурхайчид Борнуур аль эсвэл Мандалын боловсруулах цех рүү алтаа тээвэрлэн, борлуулдаг тул тэнд алт худалдан авдаг иргэд ч байгаагүй.

Зураг 1. Буданчийн алтны үндсэн ордны уурхайн нэвтрэх хэсэг



2. **Дархан-Уул аймгийн Шарын гол, "Буянтын Хөндий" алтны шороон орд** нь Улаанбаатар хотоос хойшоо 210 км-т оршдог. Бичил уурхайн суурингаас хамгийн ойр суурьшлын бүс нь 10км-ийн зайд байрлах Шарын гол бөгөөд 15 минутын дотор хүрэх боломжтой. Буянтын Хөндий нь харьцангуй шинэхэн байгуулагдсан бичил уурхайн газар бөгөөд биднийг хээрийн судалгааны ажлаар ирэхээс ердөө хэдхэн хоногийн өмнө орон нутгийн засаг даргатайгаа аман гэрээ байгуулан, ажиллаж эхэлсэн байлаа. Орон нутгийн бичил уурхайн ТББ нийт 64 нөхөрлөлтэй, 600 орчим бичил уурхайчид ажилладаг. Үүнээс 40 орчим хувь нь эмэгтэйчүүд юм. Харин уурхай дээрх 7-8 худалдаа, үйлчилгээ үзүүлэгч иргэд байдаг бөгөөд тэдний дийлэнх нь эмэгтэйчүүд байлаа. Гурван эмэгтэй нь бичил уурхайчдын ТББ-ын уурхайчдын өдөр, оройн хоолыг бэлтгэх үүрэгтэй. Гэсэн хэдий ч уурхайчдын дийлэнх нь хоол ундаа сумын төвөөс бэлтгэдэг. Тус уурхайд 4-5 алт худалдан авагчид ажилладаг бөгөөд ТББ-ын зүгээс зохицуулдаг байна.

Уурхайд хамгийн ойр байрлалтай эмнэлэг, бага сургууль, төрийн үйлчилгээ, бүртгэлийн төв сумын төв дээр байрладаг. Гэрэл цахилгаанд холбогдоогүй тул уурхайчид жижиг дизель цахилгаан үүсгүүрийг ашигладаг. Ундны усаа машинаар зөөвөрлөнө. Сумын төвд амьдардаг зарим бичил уурхайчид өдрийн цагаар уурхай дээр ажиллаад, оройдоо гэртээ харьдаг ч зарим нь уурхай дээр дээд тал нь 3-5 хоногоор байрлан ажилладаг байна.


3. **Дорноговь аймгийн Айраг сумын "Алтат" жоншны бичил уурхайн сайт** нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 350 км зайд оршдог бөгөөд автомашин болон галт тэргээр зорчин хүрэх боломжтой. Сумын төвөөс машинаар аль эсвэл мотоциклээр 8 км (10 мин) зам туулаад уурхайд хүрнэ. Бичил уурхайчид нь олборлосон жоншоо тээвэрлэн тухайн газрын эзэмшигч болох уурхайн компанид (Хөхтөр ХХК) зарж борлуулдаг аж. Хамгийн ойрын эмнэлэг, бага сургууль, төрийн үйлчилгээ, бүртгэлийн газар Айраг суманд байрлана. Дизель үүсгүүр ашиглан цахилгаан гарган авдаг. Бичил уурхайчид хоол, хүнс, ундны усаа сумын төвөөс бэлтгэнэ. Алтат ордод нийт зургаан бичил уурхайн нөхөрлөл

ажилладаг бөгөөд нийт 30 орчим бичил уурхайчинтай. Тэдний ердөө гурваас дөрөв нь л эмэгтэйчүүд юм. Уурхайчид гэрт аль эсвэл хуучин галт тэрэгний чиргүүлэнд хоноглодог байна. Хээрийн судалгааны ажил хийсэн бичил уурхайн орд руу зорчдог нийтийн тээвэр гэж байдаггүй. Бүх газрууд утасны сүлжээтэй. Дээрх уурхай дээр биднийг судалгаа авч байх үед 18-аас доош насны хүүхдүүд ажиллаж харагдаагүй. Судалгааны үеэр чанарын судалгааны мэдээллийг хийхийн тулд мэдээлэл цуглуулах олон төрлийн арга хэрэгслүүдийг ашигласан. Энэ талаар доор дэлгэрэнгүй тайлбарлав.

3.3.1 Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг

Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг хийхдээ 10-20 бичил уурхайчдыг нэг гэрт цуглуулан (Зураг 3) төслийн танилцуулга, уулзалтын зорилгыг тайлбарлаж, улмаар хоёроос дөрвөн багт хуваасан. Баг тус бүрт цаас, өглөө босох, хоол хийх, жолоо барих, мод хагалах, хүүхэд харах, уурхайн ажил хийх (түмпэндэх, ухах) зэргийг дүрсэлсэн зурган картуудыг өгч, өдөр тутмын ажлаа өглөөнөөс орой хүртэл нь хуанли байдлаар үзүүлэх даалгавар өгөв. Ажлаа дүрслэхдээ эр, эм хүмүүсийн хэнийх нь үүрэг болохыг мөн түүнчлэн өвөл, зунаар ялган харуулахыг хүсэв (Дүрс 2).

Зураг 2. Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг; Айраг сумын жоншны уурхай дээрх оролцогчид (зүүн тал) болон зуны улиралд алтны шороон орд дээр ажилладаг хүмүүсийн өдөр тутмын ажлыг харуулсан хуанли (баруун тал)



Бүлгүүд 30 орчим минут ажилласны дараагаар чиглүүлэгчийн хүссэний дагуу хуанлигаа ханан дээр бэхлэж, тус бүр нэг хүн бүлгээс гарч ирэн хуанлигаа тайлбарласан юм. Тайлбарын үндсэн дээр сонирхолтой өвөрмөц болон ялгаатай зүйлсийг онцлон ярилцав.

3.3.2 Мэдээлэл цуглуулах ярилцлага

Гурван уурхайн орд дээр нийт 10 удаагийн ганцаарчилсан ярилцлага хийж, нөхөрлөлийн гишүүдээс хамгийн их мэдээлэлтэй хүмүүс болох нөхөрлөл, ТББ-ын тэргүүнүүдээс нээлттэй асуулт асууж, хариулт авлаа. Ярилцлага хийхдээ доорх хэд хэдэн зүйлд голлон анхаарсан болно. Үүнд:

- Нөхөрлөл/ТББ дахь эр, эм хүмүүсийн үүрэг, хариуцлага, эзлэх байр суурь;
- Эр, эм бичил уурхайчдын үүрэг, эзлэх байр суурь;
- Уурхайн ойр орчим худалдаа, үйлчилгээ үзүүлэх салбарт ажиллаж байгаа эр, эм хүмүүсийн үүрэг, хариуцлага, үүнд биеэ үнэлэлт ч бас орсон.
- Өрхийн төсвийн талаар шийдвэр гаргах; эр, эм хүмүүсийн үүрэг, хариуцлага
- Бичил уурхайд болон түүний ойр орчимд гарч буй бэлгийн, гэр бүлийн болон танилын хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэл;
- Бичил уурхайн нөхөрлөл дэх эрх мэдэл болон жендерийн харилцаа.

Зураг 3. АНУ-ын Азийн сангийн судалгааны багийн гишүүн Шарын голын алтны шороон орд дээр ажилладаг бичил уурхайчнаас ярилцлага авч байгаа нь.



3.3.3 Бичил уурхайчид болон уурхайн ойр орчим худалдаа, үйлчилгээ үзүүлэгч иргэдтэй хийсэн ярилцлага

Жендерийн судалгааны баг нээлттэй болон хаалттай асуултуудыг хослуулан ашигласан нийт 35 ярилцлага хийхдээ (Дүрс 4, 5) эр, эм бичил уурхайчдыг жигд хамруулахыг зорьсон. Ярилцлаганд онцолсон асуултууд:

- Бичил уурхай эрхлэх болсон шалтгаан;
- Уурхайд болон уурхайн эргэн тойрон дахь жендерт суурилсан үүрэг, хариуцлагын хуваарилалт;
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бичил уурхайд ажиллаж байгаа байдал болон зан авирын талаарх ойлголт;

- Орлого, зарлага
- Бичил уурхай эрхэлж эхлэх болон болиход эрэгтэй, эмэгтэй хүмүүст тулгардаг саад бэрхшээл;
- Хувь хүний зорилго, хүсэл тэмүүлэл;
- Байгаль орчны доройтол, тэдний амьдралд нөлөөлөх нөлөөллийн талаарх тэдний бодол;
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн талаарх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үзэл бодол.

Бичил уурхай эрхэлдэггүй ч бичил уурхайчдад худалдаа, үйлчилгээ үзүүлдэг эмэгтэйчүүдтэй мөн уулзсан. Үүнд алтны бичил уурхайн орд болон түүнтэй ойролцоох газруудад худалдаа, үйлчилгээ үзүүлдэг дөрвөн эмэгтэйтэй ярилцсан болно. Харин жоншны уурхайн ойр орчим энэхүү ажил үйлчилгээ эрхлэгч иргэдтэй таарсангүй.

Зураг 4. АНУ-ын Азийн сангийн хоёр судлаач Түнхэл багийн алтны үндсэн ордны бичил уурхайчдаас ярилцлага авч байгаа нь.



3.3.4 Ажиглалтын хуудас

Судалгааны баг бичил уурхайд ажиллахдаа тухайн ордны талаарх мэдээллийг ажиглалтын хуудсанд тэмдэглэв. Хуудасны ихэнхи асуултыг ажиглалт хийснээр бөглөх боломжтой ч зарим асуултанд хариулахын тулд ярилцлага хийх шаардлагатай байлаа. Ажиглалтын хуудсанд дэд бүтэц, амьдрах орчин (тав тух болон амьжиргааны түвшин), иргэний болон эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж, хамгийн ойрын тосгон хүртэлх зай, ундны ус болон цахилгааны хангамж, хүн амын тоо болон бүтэц /хүүхэд эмэгтэйчүүдийг багтаасан/, жендерт суурилсан ажил үүргийн хуваарилалт зэрэг олон асуулт орсон юм.

Судалгаанд хэрэглэсэн арга хэрэгслүүдийн талаар хавсралт 1-т оруулав.

3.4 Богино хэмжээний судалгаа

ШХА-ийн саналыг харгалзан, бичил уурхайн орд дахь жендерт суурилсан хүчирхийлэл, түүнчлэн бичил уурхай, түүний ойр орчимд ажиллаж, амьдарч буй эмэгтэйчүүд жирэмслэлтээ хэрхэн зохицуулдаг талаар богино хэмжээний нэмэлт судалгааг мөн хийв. Үүнд зохион байгуулалтанд орсон бичил уурхайн төлөөлөл нийт 12 оролцогчоос хариулт авсан болно.

4. Үр дүн

4.1 Бичил уурхайн хүн амын хүн ам зүйн бүрдэл

Бичил уурхайгаар алт олборлогч иргэдийн дийлэнх нь эрчүүд байдаг ч эмэгтэйчүүд ч бас багагүй хувийг эзэлнэ. Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн зохион байгуулалттай бичил уурхайд хийсэн судалгаанд хамрагдагсдын гуравны нэг хувь нь эмэгтэйчүүд байсан бөгөөд насны хувьд эрчүүдээсээ бага зэрэг ахимаг байв. Хэдийгээр насны зөрүү бага ч гэсэн энэ үзүүлэлт статистик мэдээллийн хувьд ач холбогдолтой үзүүлэлтэнд тооцогддог. Тодруулбал эмэгтэйчүүдийнх 17-66, эрчүүдийн нас 17-69 насны хооронд хэлбэлзэнэ. Боловсролын түвшингээрээ эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчид ижил, өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 90 гаруй хувь нь ерөнхий боловсролын дунд сургуулийн 8-р ангийг төгсчээ. Ярилцлага өгсөн бичил уурхайчдын тал хувь нь дунд сургууль дүүргэсэн байлаа.

Чанарын судалгааны мэдээлэл цуглуулсан бичил уурхайн газруудаас алт олборлогч бичил уурхайчид болон нөхөрлөлийн тэргүүнүүд бичил уурхайд эмэгтэйгээсээ илүү эрчүүд олноороо ажиллаж байгааг батлан хэлсэн. Гэхдээ уурхайн ордны төрлөөс шалтгаалаад жендерийн тэнцвэрт байдал хамаардгийг мөн онцолж байлаа. Судлаачдын баг жоншны уурхай дээр ажиллахдаа маш цөөхөн эмэгтэйчүүдтэй таарсан бөгөөд бичил уурхайчдын хэлснээр улирлаас үл хамааран жоншны уурхай дээр ажиллагч иргэдийн ердөө 15-20 хувь нь л эмэгтэйчүүд байдаг ажээ. Алтны үндсэн орд дээр ч биеийн хүчний их шаарддаг тул эмэгтэйчүүд эрчүүдээс цөөн. Бидний уулзсан нөхөрлөлийн тэргүүний хэлснээр алтны үндсэн ордны нийт бичил уурхайчдын 30 орчим хувь нь л эмэгтэйчүүд гэнэ. Харин алтны шороон ордны хувьд эр, эм бичил уурхайчдын тоо харьцангуй тэнцвэртэй буюу эмэгтэйчүүд 40 хувь, эрчүүд 60 хувийг бүрдүүлж байлаа. Дээрх бүх орд дээр ажилладаг бичил уурхайчдын тоо өвлийн улиралд тал хувиар буурдаг ч эр, эм хүмүүсийн эзлэх хувь хэмжээнд өөрчлөлт гардаггүй аж.

Статистик тоо баримтаас (НБХСХ-ийн судалгаа) харахад дээрх орд газруудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ төдийлөн зөрүүтэй биш (График 6). Алтны үндсэн ордод ажилладаг бичил уурхайчдын 22.4 хувь, шороон ордны 33.4 хувь, үндсэн болон шороон орд хосолсон уурхайн 33.3 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байна. Харин жоншны бичил уурхайн хувьд 32 хувь нь эмэгтэйчүүд.


Дээрх тоо, хувь хэмжээ НҮБ-ын ХАС (2007 он)-ийн хууль бусаар алтны уурхайд ажилладаг иргэдийн хүйсийн харьцааг судалсан судалгааны дүнтэй зөрж байна. Тус судалгаагаар алтны үндсэн ордын бичил уурхайчдын 29 хувь нь эмэгтэйчүүд бол алтны шороон орд дээр ажиллаж байгаа бичил уурхайчдын 39 хувь нь эмэгтэйчүүд байдаг гэжээ.

Хууль бус бичил уурхай дээр хийгдсэн өмнөх судалгаануудад хүүхдүүд тэр дундаа эрэгтэй хүүхдүүд ихээр ажилладаг тухай дурдсан байдаг (IPEC 2007 он; MNEC 2011 он) ч манай судалгааны баг 18-аас доош насны хүүхдүүдтэй таараагүй.

Хагас бүтэцчилсэн ярилцлагын үеэр судалгааны баг бичил уурхайчдаас амьдардаг газрынх нь талаар нь тодруулж асуухад (Зураг 7) хүйсээс шалтгаалан хүмүүсийн хариултанд ялгаатай зүйл нилээд ажиглагдав. Ярилцлаганд хамрагдсан эрэгтэй бичил уурхайчдын дөрөвний гурав нь найзууд болон хамтран ажиллагч нөхөрлөлийн гишүүдтэйгээ хамт амьдардаг гэсэн бол эмэгтэйчүүдийн дийлэнх нь бичил уурхай дээр аль эсвэл ойролцоох сумын төвд нөхөр,

хүүхдийн хамт амьдардаг гэж хариулжээ. Энэ нь эмэгтэйчүүд нөхрөө дагаж бичил уурхай эрхэлдэг аль эсвэл уурхайн газар нөхөртэйгээ хамт ажилладаг гэсэн бидний цуглуулсан өмнөх мэдээллийг бататгаж байгаа юм. Бичил уурхайд ажилладаг ганц бие эмэгтэйчүүд өөрийн нас биенд хүрсэн хүү болон гэр бүлийн бусад гишүүдтэй гол төлөв хамтран ажилладаг байна. Гэхдээ бие даан ганцаараа ажиллаж буй эмэгтэйчүүд ч мөн бий. Эрчүүдийн хувьд нөхөрлөлийн гишүүдтэй хамт амьдардаггүй бол эхнэртэйгээ (хүүхэд) хамт амьдардаг гэжээ.

График 6. Бичил уурхайн орд бүр дэх эр, эм хүмүүсийн эзлэх хувь



Зураг 7. Говь дахь бичил уурхайчны гэр



4.2 Бичил уурхайчдын гэрийн ажлын үүрэг, хуваарилалт хүйсээр

Гэрийн ажлын үүрэг хуваарилалт эмэгтэйчүүдийн бичил уурхай дахь оролцоонд чухал нөлөөтэй. Алтны үндсэн орд дээрх зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр нэг оролцогч “Эмэгтэйчүүдэд уурхайгаас гадна гэрийн ажил ихтэй тул бичил уурхайн үйл ажиллагаанд төдийлөн оролцож чаддаггүй” гэсэн бол өөр нэгэн бичил уурхайчин хэлэхдээ эхнэр маань үр хүүхдээ харж хандах шаардлагатай тул түүнийг уурхай дээр ажиллуулахыг хүсдэггүй гэж хариулсан байна.

Уламжлал ёсоор эмэгтэйчүүд гэрийн ажил болон үр хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдээ асран халамжлах үүрэгтэй. НБХСХ-ийн судалгаанд хамрагдсан эр, эм бичил уурхайчдын гэрийн ажлын хуваарилалт болон зарцуулдаг хугацааны талаарх хариултыг Дүрс 9-т харуулав. Судалгааны дүнгээс харахад эмэгтэйчүүд эрчүүдээс илүү олон цагийг өөрөөр хэлбэл өдөрт дунджаар нэгээс гурван цагийг гэрийн ажилд зарцуулдаг бол эрчүүдийн дийлэнх нь цэвэрлэгээ хийх, хоол хийх, хувцас угаах зэрэгт огт оролцдоггүй аж.


НБХСХ-ийн судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 57.8 хувь нь үр хүүхдээ асран халамжлах нь эмэгтэйчүүдийн үүрэг гэдэгтэй санал нэгдсэн байна. Үүнд эмэгтэйчүүдийн 67.4 хувь, эрчүүдийн 53.6 хувь нь санал нийлснээс харвал хүүхэд өсгөх тал дээр эмэгтэйчүүд илүү хуучинсаг буюу уламжлалт байр суурийг хадгалдаг аж. Харин гуравны нэг орчим хувь (31 хувь) нь үүнтэй санал нийлээгүй бөгөөд 11.2 хувь нь мэдэхгүй хэмээн хариулжээ.

Бүлгийн хэлэлцүүлгийн үеэр эрчүүд хүүхэдтэйгээ тоглох, мод хагалах, тавилга хэрэгслийн жижиг хэмжээний эвдрэлийг засч янзлах, ус авах гэх зэргээр гэрийн ажилд тусалдаг гэдэгтээ эр, эм хүмүүсийн аль аль нь санал нийлжээ (Зураг 8). “Эрчүүд шургуу хичээнгүйлэн ажилладаг ч, хажуугаар нь үр хүүхдээ асарч хамгаалах зэргээр гэрийн бусад ажилд ч мөн тусалдаг...” хэмээн нэг эмэгтэй бичил уурхайчин хариулсан байна. Үүнд өглөөгүүр эхнэр, нөхөр хоёрын аль нэг нь хүүхдээ цэцэрлэг/сургуульд нь хүргэж өгч байхад нөгөөх нь өглөөний цайгаа бэлдэнэ Алтны шороон ордод ажилладаг өөр нэгэн эмэгтэйн тайлбарласанаар: “Бид хэт давамгайлсан байр суурь эзлэхийг хүсдэггүй. Тиймээс бидний хувьд жендэрийн эрх тэгш харилцаатай” гэв. Гэхдээ бүлгийн хэлэлцүүлгээс гарсан энэхүү үр дүн статистик тоо баримттай зөрж байгаа юм. Тоон үзүүлэлтээс харахад ярилцлага хийсэн эрчүүдийн дөрөвний гурав нь хүүхэд харахад огт оролцдоггүй гэж хариулжээ (Дүрс 3).

Зураг 8: Зуны улиралд эр (баруун тал), эм (зүүн тал) хүмүүсийн өдөр тутмын ажил үүрэг



График 9. Гэрийн ажилд эр (N= 1285), эм (N=570) хүмүүсийн зарцуулдаг цаг/ өдөрт



Эмэгтэйчүүд ар гэрийн ажлаа хийх, үр хүүхдээ асарч халамжлах гээд олон ажлыг нугалдаг учраас бичил уурхай эрхлэлтэнд зарцуулах цаг багатай. Ялангуяа бага насны хүүхэдтэй эхчүүдийн хувьд эрчүүдийн нэгэн адил өдөр шөнийн ээлжинд өөрөөр хэлбэл өглөө 8-аас орой 8 хүртэл аль эсвэл орой 8-аас өглөө 8 хүртэл ажиллах боломжгүй. Эмэгтэй бичил уурхайчид ихэнх тохиолдолд хагас цагаар ажиллахад тохиромжтой ажил, үүргийг гол төлөв хариуцдаг байна. Нэгэн эмэгтэйн хэлснээр: *“Би хааяа туслах зорилгоор л уурхай дээр ажилладаг. Эрчүүдийг гэртээ ирэхэд хоол нь бэлэн байх хэрэгтэй”* гэв.

Бичил уурхай дахь хөдөлмөр хуваарилалт гол төлөв жендэрт суурилдаг ч төдийлөн чанд хатуу мөрдөгддөггүй. Өөрөөр хэлбэл шаардлагатай тохиолдолд аль ч хүйсийн хүмүүс бүхий л ажлаа хуваан хийж болдог. Ганцаарчилсан, бүлгийн ярилцлага болон ажиглалтан дээр тулгуурлан уурхай дахь эр, эм хүмүүсийн ажил үүргийн хуваарийн ерөнхий дүр зургийг гаргалаа. Ашигт малтмалын төрлөөс хамааран ордууд олборлох арга технологи болон ашиглалтаараа өөр өөр ч ажил үүргийн хуваарилалтын хувьд ижил төстэй юм. Хүснэгт 2-т энэхүү ажил үүргийн хуваарилалтыг багцлан харуулав. Гэхдээ энэ нь тухайн ажил үүргийг аль нэг хүйсийн хүн хийж гүйцэтгэх ёстой гэсэн үг биш. Ерөнхийдөө гол төлөв эрэгтэй аль эсвэл эмэгтэй хүмүүсийн хийдэг ажлыг харуулав.

Хүснэгт 2. Бичил уурхай дахь эр, эм хүмүүсийн голлон хийдэг ажил, үүрэг

[illegible]

Бичил уурхай дахь эрчүүдийн гол төлөв хариуцан хийдэг ажил үүргийн талаар асуухад хамгийн түгээмэл хариулт нь “уурхайн бүх төрлийн ажил” тодруулбал уурхайн олборлолттой (газрын гүнээс алт бүхий материал гарган авах) холбоотой бүхий л ажил байсан бөгөөд харин баяжуулах болон туслах үйлчилгээнд тэр бүр оролцдоггүй гэжээ.

Уурхай дээр хийгдсэн бүлгийн хэлэлцүүлгээс харахад эрэгтэй бичил уурхайчид газар доорх олборлолт болон нүх ухах зэргээр уурхайн олборлолтын хамгийн хүнд хүчир ажлуудыг нугалдаг (Зураг 10). Жоншны уурхай дээр ярилцлаганд хамрагдсан эмэгтэйчүүд нүх ухдаггүй гэж хариулжээ. Алтны үндсэн ордны ТББ-ын тэргүүн нэгэн эрэгтэйн хэлснээр эмэгтэйчүүд газар дороос хүдэр чирж гаргаж чаддаггүй тул тэдний хувьд газар дор ажиллах нь тохиромжгүй гэсэн байна. Биеийн хүч ихээр шаарддаг бусад хүнд хүчир ажлуудыг ч мөн л эрчүүд л хийнэ. Шороон ордны бичил уурхайн нөхөрлөлийн тэргүүн эмэгтэй ярихдаа “Уурхай дээрх бичил уурхайчин эрчүүд их сайн хүмүүс. Учир нь тэд биеийн хүч ихээр шаардсан хүнд хүчир ажлуудыг эхнэрээрээ хийлгэхийг хүсдэггүй” гэв. Үндсэн орд дээр эмэгтэйчүүд цөөхөн ажилладагийн бас нэг шалтгаан нь газрын гүнд ажиллахад тулгардаг эрсдэлүүд юм. Иймд эрчүүд өөрийн эхнэр болон бусад эмэгтэйчүүдийг эрсдэлд оруулахыг хүсдэггүй аж.

Зураг 10. Эрэгтэй уурхайчид нүх ухаж байгаа болон газар доор ажиллаж байгаа нь




Уурхай дээрх ажил үүргийн хуваарилалтын талаар урьдчилан бэлдсэн асуулгын дагуу эр, эм бичил уурхайчидтай хийсэн ярилцлагаас харахад тэдний өгсөн хариултауд өмнө нь бидний олж мэдсэн ерөнхий хандлагатай тохирч байлаа. Газар ухах ажилд бараг бүх эрчүүд (95.2 хувь) оролцдог гэсэн бол тун цөөн тооны эмэгтэйчүүд л энэ ажлыг хийдэг аж (Дүрс 10). Хүдэр бутлах ажил эрчүүдийн бас нэгэн түгээмэл эрхэлдэг ажил байсан бөгөөд энэ нь гол төлөв алтны үндсэн ордтой хамааралтай. Түүнчлэн тэсэлгээг (алтны үндсэн орд) зөвхөн эрчүүд тэр дундаа тэсэлгээгээр мэргэшсэн тодорхой туршлагатай эрчүүд л хийдэг ажээ.

Эр, эм бичил уурхайчдын хэн хэн нь түмпэн аль эсвэл резинэн дэвсгэр ашиглан хүдэр угаах, нарийн ховилоор хүдэр угаах, жижиг усны насосоор хүдэр угаах, ховилын хайрцаг ашиглан хүдэр угаах (угаах болон усны шахуурга ашиглах) (Дүрс 11, 12) зэрэг баяжуулах ажил хийдэг. Алтны шороон орд дээр бидэнтэй тааралдсан алт угаагчид аль нэг нөхөрлөлийн гишүүн байгаагүй, харин 2-3 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг хүмүүс байлаа (Хайрцаг 1). Жоншны

уурхай дээр бичил уурхайчид олборлосон түүхий эдээ том уурхайн компаниудад зардаг тул баяжуулахтай холбоотой ажлыг хийдэггүй байна. Алтны үндсэн ордны хувьд бичил уурхайчид хүдрээ баяжуулахаар өөр газар руу тээвэрлэдэг гэсэн бол ердөө ганцхан хүн (эр) л өөрөө угааж баяжуулдаг гэж хариулав.

График 11. Асуулга болон ярилцлага хослуулсан аргачлалаар гаргасан эр, эм хүмүүсийн бичил уурхай дахь ажил үүргийн хувиарлалт



Уурхай дахь эмэгтэйчүүдийн гол ажил нь чулуу ялгах ажил (Дүрс 11). Жоншны уурхай дээр газрын өнгөн хэсэгт гаргасан хүдрийг ялгах, гүн хөх ягаан өнгийн зэрэглэл өндөртэй хүдрийг цайвар өнгийн доогуур зэрэглэлийн хүдрээс ялгадаг бол үндсэн орд дээрх эмэгтэйчүүд гол төлөв тээвэрлэх үеэр унагасан жижгэвтэр хүдрийг цуглуулдаг байна.

Зураг 12. Эмэгтэй алт угаагчид ажил дээрээ



Хоол хийх болон бусад туслах ажлуудыг гол төлөв эмэгтэйчүүд хийдэг. Бидний очсон уурхайн ордууд дээр дүрэм, журам хатуу учраас бие даасан туслах үйлчилгээ үзүүлдэг иргэд байгаагүй. Уурхайчдын хэлснээр орд дээр цэнгээний газар, хоолны газар, эмсийн хүрээлэн болон бусад төрлийн бизнесийн газар нээж ажиллуулах нь хориотой ч ТББ болон нөхөрлөлийн гишүүд энэ төрлийн үйл ажиллагааг бага хэмжээнд эрхэлдэг байна. Тухайлбал, алтны шороон орд дээр тухайн ТББ-ын удирдах зөвлөлийн эмэгтэй гишүүд удирдах зөвлөлийн гишүүнийхээ хувьд цалин авдаггүй учраас хоолны газар ажиллуулж, хөнгөн зууш заран орлого олдог. Долоогоос найман эрчүүд нийлж, ойролцоох тосгон (сум) болон уурхайн газрын хооронд тээвэр хийдэг аж.

Хайрцаг 1. Эмэгтэй алт баяжуулагч нарын ажиллах нөхцөл

Дархан-Уул аймгын Шарын гол суман дахь алтны шороон ордны боловсруулах сайтад ажилладаг Алтанцэцэгⁱ хэмээгч дунд эргэм насны нэгэн эмэгтэй хиймэл нуурын эрэг дээр ажилладаг юм. Нуураас 1 км зайд байрлах бичил уурхайн нөхөрлөл ухсан шороогоо түүний ажилладаг хиймэл нуур дээр авчирч, хүдрээ угааж боловсруулдаг. Алтанцэцэг болон түүнтэй хамтрагчид ямар нэгэн химийн бодис ашигладаггүй. Тус нуурын эрэг дээрх өөр хоёр баяжуулах газар байх бөгөөд нэгэнд нь 3 эмэгтэй, харин нөгөө газарт нь нэг хос ажилладаг ажээ.

Бичил уурхайчид авчирсан шороогоо өөрсдөө угаах бөгөөд Алтанцэцэг болон түүний хамтрагчид бүх бэлтгэлийг нь хангаж, тоног төхөөрөмжийг цэвэрлэх, шаардлагатай материалуудыг бэлдэх, эргийн шугам хэсгээр гулгамтгай шавар үлдээхгүй байх зэргээр баяжуулах газрыг цэвэр байлгах үүрэгтэй. Үүнийхээ шанд баяжуулах цех дээр ажилладаг хүмүүсийн хаягдал буюу нуур руу урсан орсон шороог тэд угаадаг бөгөөд төлбөр авахгүй.

Алтны орд дээр ажилладаг нөхөрлөлүүдэд тэдний туслалцаа хэрэгтэй байдаг тул алт угаагчид хамгийн эрт ажилдаа ирж, хамгийн орой тарна. Иймээс Алтанцэцэг ч гэсэн олон цагаар ажиллах шаардлагатай болно. Бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд энэ ажлыг хийхэд хүндрэлтэй. Харин Алтанцэцэгийн хувьд хүүхдүүд нь өсч, том болсон учраас уртасгасан цагаар ажиллах боломжтой аж. Түүний хэлснээр өрх гэрийнхээ орлогыг бүрдүүлэх нь түүний ганц зорилго.

Өвлийн улиралд хүдэр баяжуулах ажил хийх хэцүү хэмээн Алтанцэцэг дурдаад, “Баяжуулах төхөөрөмж болон замыг бэлдэхийн тулд газар ухах, усны эргэн тойронд байгаа гулгамтгай шаврыг зайлуулах хэрэгтэй. Дээр нь өвөл ус хөлдчихсөн байдаг тул алт угаах усаа гэсгээн, бүлээсгэх хэрэгтэй” гэв. Алт угаадаг хүмүүс ажлын шаардлагын улмаас байнга хүйтэн усан дотор зогсдог бөгөөд хэдийгээр резинэн гадуур хувцас өмсдөг ч ус маш хүйтэн байдаг байна. Хүдэр угаах ховилын дэвсгэр өвөлдөө хөлдчихдөг учраас гэсгээх хэрэгтэй. Зуны улиралд хүдэр угаах ховилын хайрцаг руу хоолойгоор ус татаж угааж болдог бол харин өвлийн улиралд хоолой хөлдчихдөг тул хувин, дэвсгэр ашигладаг аж.

ⁱ Түүний жинхэнэ нэр биш

Тус бичил уурхай дээр алт худалдан авагч 3-4 эмэгтэйчүүд байсан бөгөөд нэг нь дээрх нөхөрлөлийн гишүүн аж. Түүний хэлснээр тэд бусад нөхөрлөлүүдээс ч алт худалдан авч, Улаанбаатар хотын дэлгүүр болон дархчуудад бага зэргийн үнэ нэмж зардаг аж. Тэрээр бизнесээ өөрийн хөрөнгөөр эхлүүлсэн байна. Алт худалдан авагчид нөхөрлөлүүдэд тоног төхөөрөмж худалдан авахад нь зориулан зээл олгодог аж.

Бүтэцчилсэн ярилцлагад хамрагдсан эр (61.9 хувь), эм (53.8 хувь) хүмүүсийн дийлэнх нь уурхайн зарим ажил эрчүүдэд илүү тохиромжтой гэсэн бол зарим нь эмэгтэйчүүдэд ч мөн тохиромжтой гэжээ. Тэдний үзсэнээр эмэгтэйчүүдийн ур чадвар, биеийн хүчинд хамгийн тохирсон ажлуудад дамарт өргүүр буюу тайл дээр ажиллах, түмпэндэж угаах, төхөөрөмжөө бэлдэх, хоол хийх, хаягдал ялгах болон бусад нарийн ажлууд ордог аж.

Тус бичил уурхайн ордны жендерт суурилсан ажил, үүргийн хуваарилалтын тухай судалгааны үр дүн өмнө нь хийгдсэн судалгаануудын дүнтэй нийцэж байна. Эр, эм хүмүүсийн биеийн хүчний ялгаа уурхай дахь ажил, үүргийн хуваарилалтанд шууд нөлөөтэй (Бжеррегаард 2009 он; Навч болон бусад 2006; НҮБ-ын ХАС болон Нийгмийн эрүүл мэндийн сургууль 2007 он). Судалгааны явцад бид уурхайн ажлуудыг жагсаахдаа хүйсийг нь мөн харгалзан үзүүлэв. Бусад судалгаануудын тайлангуудад энэ тухай оруулсан байдаг. Өрөмдлөг болон тээлгээ хийх нь эрчүүдийн ажил бөгөөд бусдыг нь аль ч хүйсийн хүн хийж болно гэсэн өмнөх судалгааны үр дүн (Навч болон бусад 2006) манай судалгааны дүнтэй тохирч байна.


Судалгааны үр дүнгүүд ижил байгаагаас харахад албан болон албан бус уул уурхайн салбарт жендерт суурилсан ажил үүргийн хуваарилалт адилхан (олборлох болон боловсруулах) аж. Бичил уурхай дээр эр, эм хүмүүс нөхөрлөлийн зохион байгуулалтад орж хамтран ажиллаж болно. Антропологич Хайгийн бичсэн Уянга орчмын алтны шороон ордны уурхайчдын тухай тайланд:

"Уурхай дээр хүмүүс 4-16 хүний (эр, эм) бүрэлдэхүүнтэй баг болон хамтран ажилладаг бөгөөд зарим нь гүнзгий нүхэн дэх хайрга чулууг жижиг, метал зээтүүгээр ухаж гаргадаг бол нөгөө хэсэг нь гаргасан хайргаа шуудайлж, гол руу аваачин угаахад тусалдаг. Хуванцар түмпэнд хайргаа дүүргээд усан дотор эргэлдүүлэн угаана." (Хай 2012: 10)

Бжеррегаардын судалгааны тайлангаас (2009) нэг ялгаатай зүйл ажиглагдсан нь биднийг бичил уурхай дээр ажиллах үед эмэгтэйчүүд (ялангуяа залуу) газрын гүнд түннель ухагчаар ажиллаж байгаатай таараагүй. Дээрх уурхайнуудад газрын гүнд ажиллах зэрэг хүнд, хүчир ажлыг эмэгтэйчүүд бараг л хийдэггүй хэмээн бичил уурхайчид бүгд хэлж байлаа. Зохион байгуулалтанд ороогүй бичил уурхай дээр нөхцөл байдал өөр байж болно. Гэхдээ бидэнд үүнийг баталгаажуулах боломж байгаагүй.

НБХСХ-ийн судалгаанд хамрагдсан оролцогчдоос эр, эм хүмүүсийн хэн нь уурхайн ажилд илүү байдгийг асуухад эмэгтэйчүүд эрчүүдээс илүүтэйгээр эмэгтэйчүүд гэж хариулжээ. Гэсэн хэдий ч төдийлөн олон хүн үүнтэй санал нийлээгүй. Хариултыг Дүрс 13-аас харна уу. Эндээс харахад эрчүүдийн дийлэнх нь эрчүүд эмэгтэйчүүдээс илүү гэж үзсэн бол ихэнх эмэгтэйчүүд эр, эм бичил уурхайчдын ур чадвар ялгаагүй адилхан хэмээн үзсэн байна.

График 13. Эр, эм хүмүүсийн хэн нь уурхайн ажилд илүү болох талаар бичил уурхайчдын өгсөн хариулт



4.4 Бичил уурхайн ажил эмэгтэйчүүдэд тохиромжтой юу?

Жендерийн тэгш байдлын судалгаа хийх үед ярилцлага болон бүлгийн хэлэлцүүлгийн үеэр бичил уурхайн уурхайчдаас эрчүүд нь эмэгтэйчүүдээс илүү ихээр ажилладаг шалтгааныг асуув. Дийлэнх нь эмэгтэйчүүд ар гэр болон үр хүүхдээ асрах зэрэг олон ажил давхар хийхээс гадна биеийн хүчний чадвар нь эрчүүдийнхээс доогуур байдагтай холбоотой гэсэн байна. (Дүрс 13). Тэдний дурдсан бас нэг шалтгаан нь бичил уурхай дээр амьдрах орчин нөхцөл хүнд байдагтай холбоотой гэнэ. Асуултанд хариулсан бичил уурхайчдаас цөөн хэд нь бичил уурхай дахь жендерийн харьцаа тэгш бус байгаагийн шалтгааныг эрчүүд уурхайн ажилд илүү байдгаас гадна өрхийн гол тэжээгч гэдэгтэй холбон тайлбарлажээ. Гэвч олонхи нь санал нийлээгүй. Ерөнхийдөө эр, эм хүмүүсийн аль аль нь эмэгтэйчүүд ажил хийж, мөнгө олох хэрэгтэй хэмээн үзсэн. Гэхдээ бичил уурхай тэр дундаа газар дор ажиллах нь эмэгтэйчүүдийн хувьд тун хүнд бас нэн эрсдэлтэй аж.


НБХСХ-ийн судалгаа болон жендерийн тэгш байдлын судалгааны ярилцлагад хамрагдсан оролцогчдын аль алинаас нь бичил уурхай эмэгтэйчүүдэд тохирсон ажил мөн эсэх талаар асуусан юм. Хэдийгээр уурхай дээр эмэгтэйчүүд олон төрлийн ажил эрхэлдэг ч, НБХСХ-ийн судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь (59.5 хувь) эмэгтэйчүүдэд тохиромжтой орлогын эх үүсвэр биш хэмээн хариулжээ. Эмэгтэйчүүдээс (52.3 хувь) илүүтэйгээр эрчүүд (62.7 хувь) ийнхүү үзсэн байна. Энэ хариултыг Монголчуудын дийлэнх нь “уурхайд ажиллах” гэдгийг газар дор малталт хийхтэй шууд холбон ойлгодогтой холбон тайлбарлаж болох юм. Бүлгийн хэлэлцүүлгийн үеэр алтны үндсэн ордод ажилладаг нэг эрэгтэй уурхайчин “эмэгтэйчүүд уурхайд ажилладаггүй” гэж хэлсэн нь үүнийг нотолж байна. Гэхдээ алтны үндсэн орд дээр эмэгтэйчүүд ажиллаж байгаатай бид олонтаа таарсан. Чулууг ялгах, хүдрийг дамарт өргүүрээр татан гаргах зэрэг уурхайн ажлуудыг эмэгтэйчүүд гол төлөв хийх бөгөөд “жинхэнэ уурхайн ажилд” тооцогддоггүй байхыг үгүйсгэхгүй. Хоол хийх, тоног төхөөрөмж цэвэрлэх зэрэг эмэгтэйчүүдийн хийдэг бусад ажлууд ч мөн тооцогдохгүй. Гэхдээ дээрх ажлуудыг хийдэг эмэгтэйчүүд ч бичил уурхайн нөхөрлөлийн гишүүн бөгөөд нөхөрлөлийн орлогоос тодорхой хувь хүртэнэ.

Судалгаанд хамрагдсан хүмүүсээс цөөн тооны эрчүүд (15.9 хувь), эмэгтэйчүүд (27.4 хувь) санал нийлэхгүй, харин ч эсрэгээр нь бичил уурхай эмэгтэйчүүдэд тохиромжтой ажил мөн гэж үзэв. Харин нийт оролцогчдын тавны нэг хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Бүтэцчилсэн ярилцлагад хамрагдсан хүмүүс бичил уурхай эмэгтэйчүүдээс илүү эрчүүдэд тохиромжтой байдаг шалтгааны талаар илүү дэлгэрэнгүй хариултыг өглөө (Дүрс 14). Хамгийн түгээмэл хариулт нь уурхайн ажил нь хүнд хэцүү нөхцөлд биеийн хүч ихээр шаарддагтай нь холбон тайлбарлажээ. Эмэгтэй бичил уурхайчдийн хариултаас харахад:

- “Эрүүл мэнд талаасаа эмэгтэйчүүдэд сөрөг нөлөө ихтэй.”
- “Эмэгтэйчүүд уурхайн ажлыг олон цагаар хийж чаддаггүй.”
- “Эмэгтэйчүүд бие бялдрын хувьд хангалттай хүчтэй биш.”
- “Эмэгтэйчүүдэд өөр хүлээсэн үүрэг, хариуцлага их” гэжээ.

График 14. Бичил уурхайн дэд салбарт эрчүүд олноор ажилладагийн үндсэн шалтгаан



Дээрх асуултанд эмэгтэйчүүдийн өгсөн хариултуудтай төстэй эрчүүдийн өгсөн тайлбар:

- “Бичил уурхай биеийн хүч ихээр шаарддаг”
- “Хүнд нөхцөлд ажилладаг нь эмэгтэйчүүдийн арьс, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг”
- “Эмэгтэйчүүд бие бялдрын хувьд хангалттай хүчтэй биш”
- “Эмэгтэйчүүд уурхай дээр ажиллаж байгаа хүмүүсийг хоол хүнсээр хангах жижиг бизнес эрхэлбэл илүү тохиромжтой.”
- “Эмэгтэйчүүд хоол хийх, аяга тавга угаах, үр хүүхдээ харах зэрэг гэрийн ажилд илүү тохиромжтой; харин уурхайн ажил биеийн хүч ихээр шаарддаг тул эрчүүдэд илүү зохимжтой.”

Бичил уурхайн ажил эмэгтэйчүүдэд тохиромжтой гэж үзсэн хүмүүс эмэгтэйчүүдэд орлогыг эх үүсвэр хэрэгтэйгээс гадна олон төрлийн ур чадвартай нь холбон тайлбарлажээ. Уурхайн ажил эмэгтэйчүүдэд тохиромжтой гэж үзсэн эмэгтэйчүүдийн хариултаас харахад:

- “Идэх хоолтой байхын тулд орлого олох боломжтой бүхий л зүйлийг хийх хэрэгтэй”
- “Эмэгтэйчүүд хариуцлагатайгаас гадна аливаа зүйлсийг удирдан зохицуулахдаа илүү сайн.”
- “Бичил уурхай эрхлэх амархан” гэжээ.

Эрчүүд мөн дээрхтэй төстэйгөөр хариулсан байна. Тухайлбал:

- “Бичил уурхайн ажил эмэгтэйчүүдийн хувьд хүнд ч гэлээ орлого олох өөр арга байхгүй”
- “Энэ ажил тийм ч хүнд биш” гэв.

4.5 Ажиллах цагийн ялгаа

Судалгааны дүнгээс харахад бичил уурхай дээр эрчүүд эмэгтэйчүүдээс илүү олон цагаар ажилладаг. Эрчүүд ихэвчлэн долоо хоногийн 6-7 өдөр ажиллах бөгөөд долоо хоногт 2-5 хоног ажиллах тохиолдол бараг байхгүй (Хүснэгт 3). Ингэхдээ өдөртөө 8-10 цагаар зарим тохиолдолд 10-аас илүү цагаар ажиллах нь бий (Хүснэгт 4).

Хүснэгт 3. Бичил уурхай дээр долоо хоногт ажиллах өдөр хоног

	Эр (N=1285)	Эм (N=570)	Нийт (N=1855)
Хариулаагүй	0.1%	0.3%	0.2%
1 өдөр	6.4%	6.3%	6.4%
2-3 өдөр	15.0%	21.6%	17.2%
4-5 өдөр	27.0%	34.8%	29.6%
6-7 өдөр	44.2%	28.2%	38.9%
Одоогоор ажиллаагүй	1.0%	2.5%	1.5%
Уурхайн ажил эрхэлж эхлээгүй	6.3%	6.3%	6.3%
Нийт	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 4. Бичил уурхайн өдөрт ажиллах цаг дунджаар

	Эр (N=1285)	Эм (N=570)	Нийт (N=1855)
Хариулаагүй	0.1%	0.3%	0.2%
1-2 цаг	6.5%	4.9%	6.0%
3-4 цаг	11.7%	18.1%	13.8%
5-7 цаг	22.2%	31.5%	25.3%
8-10 цаг	31.4%	22.2%	28.3%
10 цагаас илүү	20.7%	14.2%	18.6%
Уурхайн ажил хараахан эхлээгүй	6.3%	6.3%	6.3%
Одоогоор ажиллаагүй	1.0%	2.5%	1.5%
	100.0%	100.0%	100.0%

Эмэгтэйчүүд гэрийн ажил, үр хүүхдээ асрах зэрэг өөр олон үүрэг, хариуцлага үүрдэг тул уурхайд төдийлөн олон цагаар ажиллаж чаддаггүй. Тэд өдөртөө 3-4, зарим тохиолдолд 5-7 цаг л ажиллах аж. Бусад судалгаагаар ч энэ нь батлагдсан. Хууль бусаар бичил уурхай эрхэлж буй газруудад ч байдал мөн ижил.

Бүлгийн хэлэлцүүлгийн үеэр бичил уурхайчид үүнийг баталгаажуулсан бөгөөд тэдний хэлснээр эмэгтэйчүүд өдрийн турш угаалга цэвэрлэгээ, хоол бэлтгэл, хүүхэдтэйгээ тоглох болон бусад ар гэрийн ажлаа голлон хийдэг гэв. Эмэгтэйчүүд уурхай дээр цөөн цагаар ажилладаг ч ар гэрийн ажлын улмаас маш их ачаалалтай. Тэр дундаа зарим эмэгтэйчүүд өрх толгойлон, гэр орныхоо санхүүг бүрэн хариуцдаг тул уурхай дээр илүү уртасгасан цагаар ажиллан, гэр орны ажлаа ч давхар амжуулна. Монгол болон бусад улс орнуудад бичил уурхайд ажилладаг эмэгтэйчүүдийн талаар хийгдсэн судалгаануудад энэ талаар дурдсан байдаг. Бжеррегаардийн

(2009 он) үзсэнээр олон цагаар ачаалал ихтэй ажилладаг дээрх эмэгтэйчүүдээс илүүтэйгээр шинээр шилжин ирсэн эмэгтэйчүүд гэр орны ажилд нь туслах хамаатан садан, найз нөхөдгүйн улмаас бүр ч хүнд нөхцөлд ажиллаж амьдардаг аж.

Хайрцаг 2. Өвлийн улиралд алтны үндсэн орд дээр ажиллаж буй бичил уурхайчдын жирийн нэгэн ажлын өдөр

Өвлийн өглөө их хүйтэн учраас өрхийн гишүүд эрт босох гэж яардаггүй, ерөнхийдөө 7-8 цагийн хооронд босдог. Хэрэв цасан шуургатай байвал бичил уурхай руугаа явдаггүй харин бусад өдрүүдэд ажиллана.

Ажил 9 цагийн үед эхэлдэг. Эмэгтэйчүүд эхлээд хүүхдүүдээ сургуульд нь хүргэж өгөх бөгөөд уурхай руу явахаасаа өмнө хоолоо хийнэ. Өглөөгүүр уурхайчид ажлын байрны аюулгүй байдлын талаар ихэвчлэн ярилцдаг. Ихэнх эмэгтэйчүүд дамарт өргүүр ашиглан хүдэр татаж гаргадаг бол эрэгтэйчүүд нүх рүү орж хувинг хүдрээр дүүргэж өгнө. Нөхөрлөлийн гишүүд 12-13 цагийн хооронд өдрийн цайны завсарлагатай. Үүний дараа үдээс хойш 3 цаг хүртэл ажиллаад, эрэгтэй, эмэгтэй бичил уурхайчид хүдрээ баяжуулах цехрүү аваачна. Тэндээ оройн 6 цаг хүртэл ажилладаг. Алтаа ялган авсны дараа зарж борлуулан, олсон орлогоосоо зардлаа хасч, гарсан цэвэр ашгаа нөхөрлөлийн гишүүд тэнцүү хуваан авна.

Судалгааны дүнгээс харахад зохион байгуулалтанд орсон бичил уурхай дээр эмэгтэйчүүд цөөн цагаар (хагас цагаар) ажиллах боломж зохион байгуулалтанд ороогүй газруудтай харьцуулахад харьцангуй их. Учир нь тэд ихэвчлэн эр нөхөр аль эсвэл хамаатан садантайгаа хамт нэг нөхөрлөлд нэгдэн ажилладаг бол зохион байгуулалтанд ороогүй газруудад эмэгтэйчүүд гол төлөв ганцаараа бие даан ажилладаг байна. Түүнчлэн, зохион байгуулалтанд орсон газруудад бичил уурхайн нөхөрлөл болон ТББ-ууд нь шилжин ирсэн болон тухайн орон нутагт оршин суудаг эмэгтэйчүүд, гэр бүлийнхэнд нь бичил уурхайд ажиллахтай холбоотой үүсэх аливаа хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь тодорхой дэмжлэг туслалцаа үзүүлдэг аж.

Бичил уурхайд ажиллах цагийн хуваарь улирлаас шалтгаалан өөр өөр байх бөгөөд зун, өвлийн улиралд хамгийн их ялгаатай. Жишээ нь алтны бичил уурхайн бичил уурхайчид зун өглөө 8 цагаас эхлэн орой 5 цаг хүртэл ажиллаад, гаргаж авсан хүдрээ баяжуулах цехрүү аваачна. Тэд тэндээ оройн 8 цаг хүртэл ажиллаад, гэртээ харьдаг. Тэдний дараа шөнийн ээлжийн хүмүүс ирнэ.

Өвлийн улиралд (11 дүгээр сараас 2 дугаар сарын хооронд) агаарын хэм -30 градус хүртэл буурах бөгөөд бичил уурхайчид зун ажилладаг шигээ олон цагаар ажиллах боломжгүй. Алтны шороонд орд дээрх өвлийн улирлын жирийн нэгэн ажлын өдрийн дүрслэлийг Хайрцаг 2-оос харна уу.

4.6 Нөхөрлөл дэх эр, эм гишүүдийн хүлээх үүрэг, хариуцлага болон байр суурь

Сүүлийн жилүүдэд бичил уурхайчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж хамтран ажиллах болов. Энэхүү нөхөрлөлүүд нь гол төлөв нэг гэр бүлийн гишүүд аль эсвэл танил хүмүүсээс бүрдэнэ. Нэг орд газар аль эсвэл нэг бүс нутагт ажиллаж байгаа нөхөрлөлүүдийг төлөөлсөн толгой байгууллага нь ТББ юм.

Бидний судалгаа хийсэн бичил уурхайн газруудад бараг бүх бичил уурхайчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд оржээ. Ярилцлаганд хамрагдсан зарим бичил уурхайчдын хэлснээр нөхөрлөлд нэгдэлгүйгээр бие даан ажиллаж буй цөөхөн бичил уурхайчид байдаг бөгөөд тэд бүгд эрчүүд гэнэ. Нөхөрлөлийн тэргүүн хүний хүлээсэн үүргийн нэг нь нөхөрлөлөө сумын төвд бүртгүүлэх зэрэг захиргааны ажил байдаг бөгөөд нөхөрлөл болон ТББ-ын тэргүүнүүд

бичил уурхай эрхлэх газрын зөвшөөрөл авахын тулд орон нутгийн удирдлагуудтай хэлэлцээр хийж аман гэрээ байгуулна. Мөн түүнчлэн санхүүгийн болон ажлын байрны аюулгүй байдлыг хангахад анхаарна.

НБХСХ-ийн судалгаанд хамрагдсан нөхөрлөлийн гишүүдийн 30.6 хувь нь эмэгтэй тэргүүнтэй, харин 69.4 хувь нь эрэгтэй тэргүүнтэй гэв. Судалгаанд оролцсон эмэгтэй бичил уурхайчдын 44 хувь нь, эрчүүдийн дөрөвний нэг (24.6 хувь) хувь нь эмэгтэй тэргүүнтэй нөхөрлөлд харьяалагддаг гэсэн байна. Үүнээс харахад эмэгтэй бичил уурхайчид олноор ажилладаг газар нөхөрлөлийн тэргүүнээр эмэгтэй хүн сонгогдох магадлал өндөр. Бидний судалгаа хийсэн алтны шороон ордны уурхайд нийт 64 нөхөрлөл ажиллаж байснаас 50 нь эмэгтэй тэргүүнтэй, ТББ-ын удирдах зөвлөлийн есөн гишүүний зургаа нь, хяналтын зөвлөлийн таван гишүүний хоёр нь эмэгтэйчүүд байв. Тэдний нэг ТББ-ын нэг тэргүүн хэлэхдээ: “Эмэгтэйчүүд санхүүгийн асуудлыг зохицуулах, мөнгөтэй харьцахдаа эрчүүдээс илүү. Мөн аюулгүй ажиллагаан дээр илүүтэй анхаарч, зааварчилгаа зөвлөгөө өгдөг” гэв. Судалгааны үеэр хийсэн ажиглалтаас дүгнэхэд эрчүүд харьцангуй олноор *ажилладаг* алтны үндсэн орд болон жоншны бичил уурхай дахь нөхөрлөл болон ТББ-ын нилээдгүй хувийг эмэгтэйчүүд удирдаж байна.

Нөхөрлөлийн тэргүүнээр аль хүйсийн хүнийг илүүд үздэг талаар асуухад НБХСХ-ын судалгаанд оролцогчдын тал хувь нь буюу эрчүүдийн 48.2 хувь нь эмэгтэйчүүдийн 49.8 хувь нь хүйс огт хамаагүй гэжээ. Үүнээс харахад нөхөрлөлийн тэргүүний талаар эр, эм хүмүүс ижил байр суурьтай байна. Харин судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 29 хувь, эрчүүдийн 38.3 хувь нь нөхөрлөлийн тэргүүнд эр хүн илүү зохимжтой гэсэн бол эрчүүдийн 10.1 хувь, эмэгтэйчүүдийн 18.9 хувь нөхөрлөлийн тэргүүнээр эмэгтэй хүн ажиллахыг илүүд үздэг гэжээ. Дээрх хариултуудаас харахад, нийт бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь эрчүүд байдаг ч эр, эм хүмүүсийн аль аль нь нөхөрлөлийн тэргүүнээр ажиллахад хүйс чухал биш гэжээ.

Хэдийгээр нөхөрлөлийн тэргүүнээр эр хүн ажиллахыг арай илүүд тооцсон ч НБХСХ-ын судалгаа болон чанарын судалгааны ярилцлагаас дүгнэхэд эмэгтэйчүүд ч удирдах ажил хийх бүрэн чадамжтай хэмээн үздэг байна. Судалгаа хийсэн газруудад эмэгтэйчүүд зохион байгуулалттай холбоотой болон ТББ-ын зохион байгуулсан аливаа ажилд хамгийн их идэвхтэй оролцдог байна. Ярилцлага өгсөн хүмүүс ч нөхөрлөлийн эмэгтэй тэргүүний ажлын чанар, бүтээмжийг өндрөөр үнэлсэн. Эмэгтэйчүүдийг зохицуулалт хийх, аливаа асуудлын цаад нарийн учрыг нь олж харах, зохион байгуулахдаа эрчүүдээс илүү гэв. Ярилцлагын үеэр нэгэн эмэгтэй нөхөрлөлийн тэргүүн: “...эмэгтэйчүүд хүмүүстэй харьцахдаа эрчүүдээс илүү нээлттэй байдаг учраас өөрсдийн ашиг сонирхлыг илүүтэй хамгаалж чаддаг” гэж хэлсэн юм.

Зохион байгуулалтанд орох нь олон давуу талтай хэмээн эр, эм бичил уурхайчдын хэн хэн нь онцолж байлаа. Ялангуяа бичил уурхай эрхлэх газрын зөвшөөрөл авахын тулд орон нутгийн удирдлагуудтай гэрээ хэлэлцээр хийх боломж бүрддэг. Хэдийгээр зөвшилцөл аман гэрээ хэлбэрээр хийгддэг ч бичил уурхайг албан ёсоор эрхлэх боломжийг тодорхой хэмжээгээр бүрдүүлж, “хөөгдөх” эрсдэлийг бууруулдаг аж. Нэгэн эмэгтэй бичил уурхайчны хэлснээр: “Манай бичил уурхайн ТББ бидний эрхийг хамгаалдаг, харин сумын удирдлага бол хамгаалдаггүй” гэв. Ийнхүү зохион байгуулалтанд орсноор бичил уурхайчид эрсдэл, аюул багатайгаар ажиллах нөхцөл бүрдэж, улмаар нөхөн сэргээлт хийх урам зоригийг нь өдөөж өгдөг байна. Зохион байгуулалтанд орохын давуу талуудаас дурдвал:

- Бичил уурхайн зориулалтаар газар ашиглах зөвшөөрөл авах (аман гэрээгээр), орон нутгийн удирдлагуудтай ажил хэргийн сайн харилцаа үүснэ.
- Уурхайн осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх болон хөдөлмөрийн аюулгүй байдал сайжирна.
- Мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ.
- Эрүүл мэнд болон нийгмийн даатгалд хамрагдах боломж бүрдэнэ.
- Алтны шороон орд дээр бичил уурхайчдад зориулсан хоолны газар ажиллаж байсан бөгөөд ганц бие ээжүүд тэнд хөлсөөр хоол хийж байв.

Аль ч хүйсийн хүмүүст зохион байгуулалтанд орсны ач холбогдол, давуу тал ижил байдаг ажээ. Хүйсээс хамаарахгүйгээр нөхөрлөлийн тэргүүн хүн орон нутгийн удирдлагуудтай харилцаа тогтоож, яриа хэлэлцээр хийх бөгөөд ярилцлаганд хамрагдсан бичил уурхайчдын дурдсанаар эмэгтэйчүүд энэ тал дээрээ илүү чадварлаг гэнэ. Гэхдээ эмэгтэй нөхөрлөлийн тэргүүнүүд төрийн албан хаагчидтай харьцахдаа асуудлыг эрчүүдээс өөрөөр хөнддөг гэж хэлсэн хүн бидэнтэй таараагүй.

НБХСХ-ын судалгаанаас харахад бичил уурхайчдын дийлэнх нь нөхөрлөл дэх эр, эм хүмүүсийн үүрэг хариуцлага харилцан адил гэв. Судалгаанд оролцогчдоос энэ талаар лавлахад: “Нөхөрлөл/ТББ-ийн эр, эм гишүүд ижил тэгш эрхтэй бөгөөд хийж гүйцэтгэсэн ажлынхаа төлөө ижил цалин хөлс авдаг” гэж хариулсан юм. Судалгаанд оролцогчдын гуравны хоёроос дээш хувь нь (бөглөөгүй орхисон судалгааны хуудсыг тооцохгүйгээр 77.1 хувь) үүнтэй санал нийлсэн бол 8.1 хувь нь санал нийлээгүй. Судалгааны асуулгын хариултаас санал нийлэхгүй байгаа шалтгааныг олж харах боломжгүй бөгөөд санал нийлээгүй эр, эм бичил уурхайчдийн хариултанд төдийлөн ялгаатай зүйл ажиглагдаагүй болно.

Нөхөрлөлийн түвшинд гишүүд нас хүйс, эрхэлдэг ажил зэргээс үл хамааран шийдвэр гаргахад тэгш эрхтэйгээр оролцох боломжтой. Шийдвэр гаргахдаа ардчилсан зарчмаар санал хураах зэргээр шийдвэрлэдэг байна. Ярилцлаганд хамрагдсан зарим хүмүүс ч үүнийг дурдаж байлаа. Алтны үндсэн орд дээрх нэгэн нөхөрлөлийн тэргүүн эмэгтэй хэлэхдээ нөхөрлөл дотор эр, эм гишүүд эрх тэгш байдаг ч гэсэн шинээр нүх ухах зэрэг зарим нэг шийдвэрийг гаргахдаа түүний нөхөр (нөхөрлөлийн гишүүн) болон бусад эрэгтэй гишүүд голлон оролцдог гэв. Харин бусад уурхай дээр хийсэн ярилцлагын үеэр нүх ухах гэх мэтийн асуудлыг ч эр, эм хүмүүс хамтран шийддэг гэж хариулсан юм. Алтны шороон ордноос жишээ авч үзвэл, ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүд уурхай эрхлэх газартай холбоотой шийдвэр гаргахдаа бичил уурхайн нөхөрлөлийн долоо хоног тутмын хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг байна. Хуралд нөхөрлөлийн гишүүд хүйсээс үл хамааран тэгш эрхтэй оролцоно.

Тухайн орон нутаг, сумын оршин суугчаар бүртгүүлэхтэй холбогдуулан нөхөрлөлийн гишүүн эр, эм хүмүүсийн байр суурийн тухай асуухад нөхөрлөл/ТББ-ын тэргүүнүүд зөрүүтэй мэдээлэл өгсөн. ТББ-ын нэг тэргүүн эрэгтэйн хэлснээр өөр сумаас шилжин ирсэн бичил уурхайчид түр оршин суугчаар бүртгүүлэхдээ эрчүүд нь хурдан хугацаанд, харин эмэгтэйчүүд болон бичил уурхайчдын эхнэрүүд ар гэрийн ажлаа зохицуулах, үр хүүхдээ харах зэрэг ар гэрийн их ажлын улмаас харьцангуй удаан хугацааны дараа бүртгүүлдэг гэжээ. Харин өөр нэг орд дээр ажилладаг ТББ-ын тэргүүн эмэгтэйн хэлснээр эмэгтэйчүүд эрчүүдээс илүү зохион байгуулалт сайтай байдаг тул тэд түр оршин суугчаар бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтуудаа хурдан хугацаанд бүрдүүлж чаддаг гэж хариулжээ.

4.7 Бичил уурхай амьжиргаагаа залгуулах арга хэлбэр болох нь

Бичил уурхай нь Монголчуудын амьжиргаагаа залгуулах боломжит аргад тооцогдоно. Асуултуудыг урьдчилан бэлтгэсэн (бүтэцжсэн) ярилцлагын үеэр судалгааны багийн гишүүд бичил уурхай эрхлэх шалтгааныг асуухад дийлэнх нь өөр ажлын байр байхгүй гэсэн бол (Зураг 15) бичил уурхай эрхлэх нь бусад боломжит ажлын байрнуудаас илүү орлого олох боломжтой гэж олонх эмэгтэйчүүд хариулсан байна. Харин харьцангуй олон эрэгтэй бичил уурхайчид өмнөх ажлаасаа халагдсантайгаа холбон тайлбарлажээ.


График 15. Ярилцлаганд хамрагдсан эр, эм хүмүүсийн бичил уурхай эрхлэх болсон шалтгаан



Жендерийн тэгш байдлын судалгааны үеэр ярилцаганд хамрагдсан эр, эм уурхайчдын хувьд бичил уурхай тэдний өрхийн орлогын гол буюу цорын ганц эх үүсвэр гэжээ. Хээрийн судалгааг хийх хугацаа тун богино байсан учраас бичил уурхайчдын орлогын талаар тодорхой мэдээлэл олж авах боломжгүй байлаа. Гэсэн хэдий ч төрөөс баталсан цалингийн доод хэмжээ болон зарим тохиолдолд тусгай мэргэжлийн ажилтнуудын цалингаас дээгүүр орлого олдог гэсэн тооцоо бий. Ярилцлаганд хамрагдсан бичил уурхайчдын хэлснээр тэд нэг грамм алтыг 34-36 ам.доллараар худалдаалдаг бөгөөд энэ нь дэлхийн зах зээлийн тухайн үеийн ханшаас харьцангуй доогуур юм (тухайн үеийн ханшаар 1 грамм алт ойролцоогоор 43 ам.доллар).

Бичил уурхайчдад үндсэн цалин гэж байдаггүй бөгөөд орлого нь хүдэр олборлолтын хэмжээнээс шууд хамааралтай. Бичил уурхайн нөхөрлөл/ТББ-уудын тэргүүнүүдийн хэлснээр алтны үндсэн ордын бүтэн цагаар ажилладаг бичил уурхайчин долоо хоногт 300,000-400,000 төгрөг (178-237 ам.доллар), харин алтны шороон ордны бичил уурхайчин долоо хоногт дунджаар 200,000-300,000 (119-178 ам.доллар) төгрөг, жоншны уурхайн бичил уурхайчид долоо хоногт дунджаар 400,000 төгрөг (237 ам.доллар) тус тус олдог байна. Дээр дурдагдсан орлогын хэмжээ нь ярилцлаганд хамрагдсан бичил уурхайчдын хэлсэн судалгаа хийхийн өмнөх долоо хоногт 100-200 ам.долларын ашиг олсон хэмээн мэдээлэлтэй тохирч байна (График 16).

График 16. Ярилцлаганд хамрагдсан бичил уурхайчдын судалгааны өмнөх долоо хоногт олсон орлогын хэмжээ



Гэхдээ бичил уурхайгаас олох орлого төдийлөн тогтвортой бус. Алтны агууламж бүхий материалд хүртлээ уурхайчид нилээд хэдэн өдөр нүх ухах шаардлагатай байдгаас зарим долоо хоногт ямар ч орлогогүй, аль эсвэл маш бага орлоготой байх нь бий. Ихэнх бичил уурхайчдын ярилцлага хийхийн өмнөх долоо хоногт олсон орлогын хэмжээ өмнө дурдагдсан хэмжээнээс бага байлаа. Гэсэн ч тэдний орлого төрөөс тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу сарын 115 ам.доллараас (192,000 төгрөг) илүү аж.

Зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид болон ярилцлага өгсөн бичил уурхайчдын (бүх ордууд) хэлснээр нөхөрлөлүүд орлогоо гишүүн бүртээ тэнцүү хуваана. Учир нь уурхайн бүхий л ажил үүрэг өөрийн гэсэн үнэ цэнэтэй бөгөөд уурхайн салшгүй нэг хэсэг байдаг тул тухайн гишүүний эрхэлдэг ажил, үүргээс үл хамааран орлогыг тэнцүү хуваадаг аж. Алтны шороон ордны нэгэн бичил уурхайчин “Бид зардлаа хасаад үлдсэн хэсгийг тэнцүү хуваадаг. Энэ нь нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсны нэг давуу тал юм” гэв. Өөр нэгэн ордны бичил уурхайчин мөн л түүнтэй ижил зүйлийг хэлсэн бөгөөд тэрээр “Хүдрээ угаасны дараа зарж борлуулаад ашигаа тэнцүү хуваан авдаг. Орлогыг гишүүд бүрт тэнцүү хуваах учиртай” гэж хариулсан юм. Ихэнх нөхөрлөлүүд гэр бүлийн гишүүдээс бүрддэг бөгөөд энэ нь орлогоо тэнцүү хуваарилахад нөлөөлдөг байх магадлалтай. Нэгэн эмэгтэйн тайлбарласнаар тэрээр нөхөртэйгөө хожуулаа нэг нөхөрлөлд харъяалагддаг бөгөөд хэн нь илүү орлого олох нь тийм ч чухал биш, харин ч тэдний олсон орлого эцсийн дүндээ нэг л гэр бүлийн орлого болдог оршино гэв.

Зураг 17. Нөхөрлөлийн эр, эм гишүүд эргэлддэг төхөөрөмжөөр хүдэр гаргаж байгаа нь




Хоёрдогч эх сурвалжийн мэдээлээс харахад албан зохион байгуулалтанд ороогүй нинжа нар ч гэсэн бүлгээрээ ажиллан олсон орлогоо тэнцүү хуваан авна. Өвөрхайнгай аймгийн Уянга сум орчмын хууль бус алтны шороон ордод хийсэн угсаатны зүйн хээрийн судалгааны ажлынхаа тайланд Мете Мери Хайн бичсэнээр:

Ажлын өдрийн төгсгөлд уурхайчид (баг/бүлгээр ажилладаг) олсон орлогоо хуваан авна. Хамгийн сонирхолтой нь уурхайчдийн нас, хүйс, туршлага зэргээс үл хамааран орлогыг тэнцүү хуваана. Газрын гүнд ажиллах нь нуралт үүсэх, хорт утаанд хордох, хүчилтөрөгч дутагдах гээд олон эрсдэл дагуулдаг ч газрын гүнд ажиллаж байгаа хүн газрын гадарга дээр ажиллаж байгаа хүнтэй адил хөлс авдаг байна (2012: 11).

Манай судалгаа болон Мете Мери Хайн судалгааны зарим үр дүн бичил уурхайн өмнөх судалгаануудтай зөрсөн. Тухайлбал, зарим нэг судалгаанд эмэгтэйчүүд эрчүүдтэй адилхан ажилласан хэрнээ тэднээс бага цалин авдаг гэжээ (жишээ нь ХХЭЗОУХ 2007 он; Пүрэвжав 2011 он). Судалгааны дүн зөрсөнтэй холбогдуулан зарим нэг таамаглал дэвшүүлж болох юм. Тухайлбал, бие даан бичил уурхай эрхэлдэг эмэгтэй алт угаагч эрэгтэй алт угаагчаас арай цөөн цагаар ажилладаг учраас бага цалин авдаг байж болно. Иймд эмэгтэйчүүд ямар нэгэн байдлаар бусадтай бүлэг/нөхөрлөл болж ажилладаг эсэх нь тухайн эмэгтэйн цалин эрэгтэй бичил уурхайчнаас бага байх эсэхэд нөлөөлдөг гэж хэлж болох юм.

НБХСХ-ын судалгаанд оролцогчдоос гэр бүлийн нөхөр, эхнэрийн хэн нь тухайн өрхийн "тэжээгч" байдаг талаар асуухад эрчүүдийн тал хувь нь (51.2 хувь), эмэгтэйчүүдийн 39.3 хувь нь өрхийн тэргүүн нөхөр гэсэн бол, (График 18) оролцогчдын талаас бага буюу 42.8 хувь нь эхнэр, нөхөр хоёр адил хувь нэмэр оруулдаг учраас хожуулаа тухайн гэр бүлийн тэжээгч хэмээн хариулсан байна. Харин нийт судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 9.8 хувь, эрчүүдийн 5.4 хувь өрхийн гол тэжээгч нь эмэгтэйчүүд гэжээ.

График 18. "Өрхийн тэжээгч нь хэн бэ?" асуултын хариулт (N=1855)




НБХСХ-ийн судалгаанд оролцогчдоос өрхийн орлогын зарцуулалтыг эхнэр нөхрийн хэн нь голлон шийдвэрлэдэг тухай асуухад ихэнх нь хамтран шийддэг гэжээ (График 19). Гэхдээ энэ нь эхнэр нөхөр хоюулаа бүх асуудлаа хамтран шийдвэрлэдэг гэсэн үг биш харин тус тусын хариуцсан асуудлаа бие даан шийддэг гэсэн үг юм. Жишээ нь нэгэн эрэгтэй бичил уурхайчин "Эхнэр маань хоол хүнс болон бусад өдөр тутмын хэрэгцээндээ мөнгөө зарцуулах шийдвэр гаргадаг, харин би шаардлагатай үед зарим зүйлсийн талаар өөрөө шийдвэрлэдэг" гэв.

Өрхийн аль нэг тэргүүн шийдвэр гаргадаг хэмээн хариулсан тохиолдолуудад гол төлөв эхнэр нь өрхийн орлогыг хэрхэн зарцуулах талаар голлон шийдвэр гаргадаг байна. Өөр нэгэн эрэгтэй бичил уурхайчин "Бид хамтдаа шийддэг ч манай эхнэр илүү эрх мэдэлтэй" гэж хариулжээ. Бичил уурхайн нөхөрлөлийн нэгэн эмэгтэй тэргүүний хэлснээр "Эмэгтэйчүүдийн өрх гэрийнхээ асуудлуудыг голлон зохицуулж ирсэн туршлага нь нөхөрлөлийг тэргүүлэхэд их хэрэг болдог. Иймд нөхөрлөлийн эмэгтэйчүүд санхүү, нийгмийн асуудлыг зохицуулахдаа шийдвэр гаргах илүү эрхтэй байдаг. Ихэнх нөхөрлөлүүд гэр бүлийн гишүүдээс бүрддэг бөгөөд гэр бүл доторх өрхийн орлого, зарлага болон бусад асуудлуудын талаар эмэгтэйчүүд л гол шийдвэрийг гаргадаг" аж.

Цөөн хэдэн тохиолдолд өрхийн орлогыг хэрхэн зарцуулах талаарх шийдвэрийг эцэг, эх нь гаргадаг байна. Урьдчилан бэлтгэсэн асуултаар хийгдсэн ярилцлагад оролцогчид тун төстэй хариулсан бөгөөд дийлэнх нь өрхийн орлогыг зарцуулахдаа гэр бүлийн хүнтэйгээ зөвлөлдөж шийдвэр гаргадаг гэжээ.

График 19. Өрхийн орлогын зарцуулалтын талаар эхнэр нөхрийн хэн нь шийдвэр гаргадаг вэ?



Жендерийн тэгш байдлын судалгаанд хамрагдаж, ярилцлага өгсөн эр, эм хүмүүсийн бичил уурхай эрхэлж буй хугацаа нь төдийлөн ялгаагүй байлаа. Эрчүүдийн тал хувь нь, эмэгтэйчүүдийн 70 орчим хувь нь тав орчим жил, харин нийт судалгаанд хамрагдагчдын дөрөвний нэг орчим хувь нь 3-5 жил бичил уурхай эрхэлжээ. Үүнээс үзэхэд эр, эм хүмүүсийн аль алинийх нь хувьд бичил уурхай ажил мэргэжлийн хувьд ихээхэн чухал сонголт болдог бөгөөд нэгэнт сонгосон л бол олон жил тасралтгүй ажилладаг аж.

Бичил уурхайгаас боломжийн орлого олдог тул ойрын хугацаанд (ирэх таван жилдээ) үргэлжлүүлэн ажиллана хэмээн судалгаанд оролцогчдын дийлэнх нь хариулсан. Тэгээд ч өөр ажлын байр тэр дундаа боломжийн цалин хөлстэй ажил олох боломж (тухайн уурхайн ойр орчимд) хомс ажээ. Энэ талаар эр, эм бичил уурхайчдын хариулт төстэй байлаа.

Ойрын жилүүдэд бичил уурхайд ажиллахаа больж өөр зүйл хийх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн цөөн тооны бичил уурхайчид шалтгааныг доор харуулав:

- “Уурхайн ажил их хүнд.”
- “Хүү маань сургуулиа төгсчихсөн учраас сургалтын төлбөр олохоор уурхайд ажиллах шаардлагагүй болсон.”
- “Ирэх жил охин маань их сургуульд орох учраас бид Улаанбаатар хот руу нүүнэ.”
- “Эрүүл мэндэд сөрөг нөлөө багатай, аюул осолгүй ажил хийсэн нь дээр.”
- “Би хөгширч, бие махбодийн хувьд хүнд хүчир ажлыг хүчирхэхгүй болж байна” гэжээ.

Ашигт малтмалын нөөц шавхагдаж дуусвал яах вэ гэсэн асуултанд ихэнх бичил уурхайчид өөр орд газарт шилжин ажиллана гэсэн бол цөөн хэд нь мал маллана гэв. Харин үлдсэн хүмүүс нь энэ талаар хараахан бодож амжаагүй гэжээ.

Ирээдүйд хийх ажлынх нь талаар асуухад ярилцлага хийсэн бичил уурхайчдын дийлэнх нь мал худалдан авах, жижиг бизнес эрхлэх, газар тариалан эрхлэх зэрэг амьжиргааны өөр эх үүсвэр бий болгох чиглэлээр хөрөнгө оруулалт хийх хүсэлтэй байдгаа илэрхийлсэн бол зарим нь өөр ажилд орохыг хүсдэг байна (График 20). Харин цөөн тооны оролцогчид шинэ тоног төхөөрөмж худалдан авч, уурхайн үйл ажиллагаа сайжруулахыг хүсдэг гэсэн бол өөр хоёр эмэгтэй хүүхдүүдээ дээд боловсролтой болгох зорилгоор мөнгөө хуримтлуулж байна гэж хариулжээ.

График 20. Бичил уурхайчдын бичил уурхайгаас хүртэх ашиг, цаашдын хүсэл.



Ажлын байр хомс хүнд үед бичил уурхай хүмүүст хангалттай орлого олж, амьдрал ахуйгаа залгуулах боломжийг олгосон. Урьдчилан бэлтгэсэн асуулгын дагуу 34 хүнтэй ярилцлага хийхэд ердөө дөрөв нь л хүүхдээ бичил уурхайчин болгоно гэжээ. Хүүхдүүдээ бичил уурхайчин болгохыг хүсдэггүй хэмээн хариулсан хүмүүс ч ажлын байр хомс хүнд үед бичил уурхай нь боломжийн орлоготой амьжиргааны арга гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Ярилцлаганд орсон хүмүүсээс ердөө ганц л эрэгтэй хүү нь саяхан экскаватор жолоодох гэрчилгээгээ (сертификат) авсан тул хүүгээ цаашид уурхайд ажиллуулах сонирхолтой гэдгээ илэрхийлжээ.

Ярилцлаганд хамрагдсан бичил уурхайчдын дийлэнх нь хүүхдүүдээ хүнд нөхцөлд, биеийн хүч ихээр шаарддаг энэхүү ажлыг хийлгэх хүсэлгүй тул хүүхдүүдээ бичил уурхайчин болгохыг хүсдэггүй аж. Тэд хүүхдүүдээ сургуульд сурч, мэргэжил эзэмшин, эрүүл мэндэд аюулгүй, биед амар ажил хийгээсэй хэмээн хүсдэг байна. Бидэнтэй уулзсан хоёр ч бичил уурхайчны яриснаар, уурхайн ажил эмэгтэй хүнд тохиромжгүй тул охидуудаа ажиллуулахгүй гэлээ.

4.8 Бэлгийн дарамт, хүчирхийлэл ба аюулгүй байдал

Баримт бичгийн судалгаанаас харахад жендерт суурилсан хүчирхийлэл (бие махбодь, сэтгэл зүйн) Монгол улсын тулгамдаж буй ноцтой асуудлуудын нэг бөгөөд зарим байгууллагуудын үзсэнээр сүүлийн үед улам ихээр нэмэгдэж байна. Гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллийн үндсэн шалтгаан нь ажилгүйдэл, эдийн засгийн хямрал болон архидалттай холбоотой. Хүчирхийлэл үндэсний хэмжээнд ялангуяа бичил уурхайн суурингуудад улам ихэсч байна (жишээ нь: НҮБ-ын ХАС 2003, 2007 он).

Өнөөдрийг хүртэл хийгдсэн судалгаануудаас харахад албан бус бичил уурхайд архины хэрэглээ, архидалт их байна. ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын судалгааны тайланд “ихэнх бичил уурхайчид хүнд хүчир ажлаа тэсвэрлэх, дулаацах зорилгоор архи уудаг. Ингэснээр өөрийгөө болон өрөөлийг ч ихээхэн эрсдэлд оруулж, улмаар хэрүүл маргаан, зодоон цохионд хүрч, хүчирхийлэл гардаг” гэжээ. Мөн Мэри Хайн (2012: 13) судалгаанд “Бичил уурхайчид эр, эм гэлтгүй ажлын дараа оройдоо архи уух бөгөөд архидалт зарим тохиолдолд маргааш өглөө хүртэл үргэлжилдэг. Тэр бүү хэл олон хоногоор архидан согтуурах нь ч бий” гэж бичсэн байна. Мэри Хайн өөр нэгэн илтгэлд “Өдөр бүр бичил уурхайчдын дунд хямд, хулхи архи уух явдал гарах бөгөөд ажлын дараа архи уусны улмаас маргааш нь согтуу нь гараагүй уурхайчид олонтаа таарна. Миний тооцоолсноор бичил уурхай дээр архинд хамгийн

их мөнгө зарцуулдаг” гэжээ (Хай 2008 он). Архийг хэтрүүлэн хэрэглэж, согтуурхан улмаар “бие биенээ үл хүндэтгэн” хэрүүл, зодоон үүснэ. Ялангуяа өөр газраас шилжин ирсэн бичил уурхайчдын дунд энэ үзэгдэл ихэд газар авчээ (Хай 2012 он). Саяхны өөр нэг судалгааны хүрээнд, архи ууж хэрүүл зодоон хийх нь энгийн иргэдээс илүүтэйгээр нинжа нарын дунд түгээмэл болохыг Кэйн ажигласан байна (pers.com 2013 оны 12 сарын 17). Архи, согтууруулах ундааны хэтрүүлсэн хэрэглээ болон жендерт суурилсан хүчирхийллийн хоорондох хамаарлыг хэдийнээ тогтоосон. Иймд албан бус бичил уурхайн газруудад архи уух нь жендерт суурилсан хүчирхийлэл гарах нөхцлийг бүрдүүлэх магадлал өндөр.

Жендерийн тэгш байдлын судалгааг хийсэн уурхайнуудад бэлгийн дарамт, хүчирхийллийн талаар ямар нэг тодорхой баримт, мэдээлэл олдоогүй. Магадгүй энэ нь бичил уурхайн нөхөрлөл болон түүний дээвэр байгууллага болох ТББ-ын зүгээс архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосонтой холбоотой байж болно. Судалгаанд оролцогчдын хэлснээр бичил уурхай анх үүсч байхдаа ямар ч зохион байгуулалтгүй байсан бөгөөд архидан согтууралт хавтгайрч, улмаар хүчирхийлэлийн шалтгаан болж байжээ. Харин бидний ажилласан бичил уурхай дээр архийг хориглож, хүчирхийлэл ч буурсан байна. Өөр бусад нөхөрлөлүүд ч бас өөрийн бичил уурхайн ордуудад дээр архины хэрэглээг хориглосон тухай мэдээлэл бидэнд ирсэн.

Нэгэн нөхөрлөлийн тэргүүн эмэгтэйн яриснаар уурхайчид уурхайн ойролцоо сууринд амьдардаг эсэх нь тухайн хүний амьдралд их чухал нөлөө үзүүлдэг байна. Түүний толгойлдог нөхөрлөлийн ажилладаг алтны шороон орд сумын төвөөс 10 км-ийн зайд байрладаг бөгөөд уурхайчид орой бүр гэртээ харина. Зарим шаардлагатай үед уурхай дээрээ дээд тал нь 2 хоног л хонодог аж. Ийнхүү ажиллангаа гэр бүлтэйгээ ойр хамт байснаар тодорхой хэмжээний нийгмийн хамгааллыг бий болгож, гэр бүлийн уур амьсгалд ч эерэгээр нөлөөлдөг. Харин бичил уурхайчид тэр дундаа олон эрчүүд нэг дор олон хоногоор хамт байх нь нэг нэгнийгээ уруу татан архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх, жендерт суурилсан хүчирхийлэл үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг байна. Үүнтэй холбоотойгоор НҮБ-ын Хүн амын сан (2007 он) албан бус бичил уурхайд ажиллаж, эрэгтэй уурхайчидтай мөр зэрэгцэн амьдарч буй эмэгтэйчүүдийн талаар “Бэлгийн хүчирхийллээс зайлсхийж, аюулгүй байдлаа хангах нь” (НҮБ-ын ХАС 2007: 56) тайланг гаргажээ.

Нэгэн нөхөрлөлийн тэргүүн эмэгтэй “Бидэнд бэлгийн дарамттай холбоотой асуудал гардаггүй, гэхдээ ашигт малтмал олборлохоор газрын гүн рүү ороход зарим нэг эрчүүд бидэн рүү чулуу шидэж, хэл амаар доромжлох тохиолдол бий. Гэхдээ энэ нь олборлолт хийх газрын төлөөх өрсөлдөөнтэй холбоотойгоор зарим нэгэн бичил уурхайчид ийм авир гаргадаг байх, гэхдээ тийм ч түгээмэл биш” гэв.

Алтны шороон ордны уурхай дахь бичил уурхайн ТББ-ын өөр нэгэн тэргүүн эмэгтэйн хэлснээр уурхай дээр сексийн талаарх онигоо ярих нь энгийн нэгэн хошигнол байдаг бөгөөд хэн нэгнийг доромжлох гэсэн зорилго агуулдаггүй. Түүнчлэн хүчирхийллийг хэзээ ч хүлээн зөвшөөрөх учиргүй, алтны орд дээр хатуу чанга дэг журамтай учраас бэлгийн дарамт, хүчирхийлэл гардаггүй гэнэ. “Хэрэв дүрэм журмаа мөрдөхгүй бол, тухайн орд дээр ажиллахаа больж болно” хэмээн тэрээр нэмж хэлсэн юм. Гэхдээ алтны шороон ордны нөхөрлөлийн эмэгтэй гишүүдийн 20 орчим хувь нь ганц бие эмэгтэйчүүд байх бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл нь харьцангуй өндөр аж.

Түнхэл багийн бичил уурхайн (алтны үндсэн орд) нөхөрлөлийн тэргүүн орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран ажилладаг тухай, тэд ч эргээд долоо хоногтоо хэд хэдэн удаа уурхай дээр нь хяналт тавьдаг талаар ярьсан. Нөхөрлөлүүд үйл ажиллагаагаа тогтвортой явуулахын тулд нэгдүгээрт 18-аас доош насны хүүхдийг уурхайд ажиллуулахгүй байх, хоёрдугаарт архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох гэсэн хоёр дүрмийг чандлан мөрдөх шаардлагатай аж. Орон нутгийн удирдлагуудаас гадна бичил уурхайн ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүд ч мөн давхар хянадаг байна. Өдрийн цагаар ихэвчлэн хоёр хүн, шөнийн цагаар дөрвөн хүн манаанд гарч, архины хэрэглээг хянахаас гадна бүртгэлгүй иргэд нөхөрлөлийн талбайд


ажиллахаас урьдчилан сэргийлнэ.

Уурхай дээрх хяналттай холбоотойгоор албан зохион байгуулалтанд орсон бичил уурхайн газруудад жендерт суурилсан хүчирхийлэл гарах магадлал бусад бичил уурхайн газруудтай харьцуулахад бага аж. Гэхдээ нөхөрлөлийн 19 тэргүүнтэй хийсэн ярилцлагын үеэр зохион байгуулалтанд орсноор жендерт суурилсан хүчирхийлэл гарах нь багассан эсэхийг тодруулахад эсрэг тэсрэг хариултыг өгсөн (График 21). Ярилцлага өгсөн тэргүүнүүдийн гуравны нэг орчим хувь нь бичил уурхай зохион байгуулалтанд орохоосоо өмнө ч охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл тийм их байгаагүй, одоо ч байдал өөрчлөгдөөгүй гэлээ. Харин бусад нь нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсноор эмэгтэйчүүдийн нөхцөл байдал дээрдсэн хэмээн үзэж байна. Үүнд алтны шороон ордыг төлөөлөл хоёр хүн, алтны үндсэн ордыг төлөөлөл нэг хүн нөхцөл байдал “маш их” сайжирсан гэжээ. Тэдний яриснаар, зохион байгуулалтанд орохоос өмнө эмэгтэйчүүдийг үргэлж хэл амаар доромжлон, заримдаа бие махбодийн хувьд хүчирхийлдэг байсан бол зохион байгуулалтанд орсноор илүү албажиж байдал дээрдсэн аж. Бас нэгэн ТББ-ын тэргүүн эмэгтэй хэлснээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах зорилгоор орон нутгийн удирдлагын зүгээс ихээхэн шахалт үзүүлсэн нь нөхцөл байдал сайжрахад нөлөөлсөн байна.

Монголын уул уурхайн суурин дахь жендерт суурилсан хүчирхийлэл болон уурхайн дэд бүтэц сэдэвт судалгаа хийхдээ Кэйн уурхайн томоохон компаниудын ойролцоох суурингуудад жендерт суурилсан хүчирхийллийн цөөхөн тохиолдлыг илрүүлсэн бол харин томоохон уурхай дээрх нийгмийн тогтсон хэв маягаас гажууд зан, хэв маяг нь хүчирхийлэл, биеэ үнэлэлт болон БЗХӨ зэрэг нэмэгдэх үндэс шалтгаан болдгийг тогтоожээ. (pers.com 2013 оны 12 сарын 17). Хэдийгээр энэхүү судалгаа бичил уурхайг хамраагүй ч зарим үр дүн нь тодохой хэмжээгээр холбоотой юм. Нэгэн уурхайн томоохон компани уурхай дээр архины хэрэглээг хориглосноор уурхайн ойр орчмын газруудад гардаг архи согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэргийн тоо эрс буурсныг Кэйн болон түүний судалгааны багийнхан тогтоожээ. Үүнээс харахад архины хэрэглээг хязгаарласнаар уул уурхай болон түүний эргэн тойронд нийгмийн амгалан байдлыг хадгалахад эерэг нөлөө үзүүлдэг байна.

Ерөнхийдөө тухайн бичил уурхай нь уурхайчдынхаа амьдардаг суурьшлын бүстэй ойрхон тохиолдолд бичил уурхайчид гол төлөв гэр бүлээрээ, ялангуяа эмэгтэйчүүд нөхрийн хамт ажиллах бөгөөд жендерт суурилсан хүчирхийлэл төдийлөн гардаггүй аж. Мөн бичил уурхайчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсноор орон нутгийн удирдлагын зүгээс жендерт суурилсан хүчирхийллийг бууруулах чиглэлээр нөлөөллийн ажил их хийх боломж нэмэгддэг байна. Дээр дурдсанчлан бичил уурхай дээр архины хэрэглээг ч мөн хориглоно.

График 21: Богино хэмжээний судалгааны асуулгын хариулт “Бичил уурхай албан зохион байгуулалтанд орохоос өмнө эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл их байсан гэж та боддог уу?” (N=19)



- Үгүй, юу ч өөрчлөгдөөгүй
- Тийм, гэхдээ бага зэрэг. Зарим эмэгтэйчүүдийг эвгүй хэлдэг ч тэр нь ихэвчлэн тоглоомоор
- Тийм, нилээд их. Эмэгтэйчүүдийг хэл амаар доромжилдог.
- Тийм, маш их. Эмэгтэйчүүдийг байнга хэл амаар доромжилдог, зарим тохиолдолд бие махбодийн хүчирхийлэл гардаг

4.9 Эрүүл мэнд ба байгаль орчин

Судалгааны өмнөх хэсгүүдэд бичил уурхай эмэгтэйчүүдэд тохиромжгүй ажил болохыг эрүүл мэндэд учрах эрсдэлтэй нь холбон тайлбарлав. Гэтэл бичил уурхай эрчүүдийн эрүүл мэндэд ч мөн нэгэн адил сөргөөр нөлөөлдөг. Хариултаас харахад эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг илүү хамгаалсан өнгө аястай хариултауд голлож байлаа. Нүх ухах зэрэг биеийн хүч ихээр шаарддаг ажлыг эмэгтэйчүүд хийхэд тохиромжгүй гэж үздэг нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн системийг гэмтээх, жирэмсэн эмэгтэйчүүдийн хувьд үр зулбах эрсдэлтэй хэмээн үздэгтэй холбоотой аж.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн хамгийн чухал асуудал нь тухайн эмэгтэй жирэмсэлснийхээ дараа бичил уурхайд үргэлжлүүлэн ажилладаг эсэхтэй шууд холбоотой. Өөрөөр хэлбэл үргэлжлүүлэн ажилласан тохиолдолд ямар ажлыг жирэмсний аль үе шат хүртэл хийх вэ гэдэгт анхаарах шаардлагатай юм. Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхайн нөхөрлөлүүдийн 12 тэргүүн судалгааны үеэр жирэмсэн эмэгтэйчүүд ямар ажил эрхэлдэг талаар мэдээлэл өгсөн. Мэдээллийг нэгтгэсэн 5-р хүснэгтээс харахад тогтсон ажлын хуваарь байдаггүй аж.

Эмэгтэйчүүдийн жирэмслэлтэндээ хандах хандлага нь ч ялгаатай аж. Зарим эмэгтэйчүүд жирэмсэн болсноо мэдмэгцээ бичил уурхайд ажиллахаа больдог бол, нөгөө хэсэг нь газрын гадаргуугаас хүдэр цуглуулах гэх мэт арай хялбар ажил хийж, нилээд хэдэн сар үргэлжлүүлэн ажилладаг байна. Гэхдээ жирэмсэн эмэгтэйчүүд төрөн төртлөө олборлолт болон боловсруулалтын хэсэгт ажилладаг тухай нэг ч хүн дурдаагүй.

Хоёрдогч эх сурвалжаас харахад бичил уурхайчин эмэгтэйчүүд газар дор, усан дотор зэргээр хүнд нөхцөлд ажилладаг (НҮБ-ын ХАС 2007) тул бусад эмэгтэйчүүдээс илүүтэйгээр жирэмсний болон төрөхийн хүндрэлтэй тулгардаг байна. Ийнхүү зарим эмэгтэйчүүдийн хувьд хүнд нөхцөлд ажиллан өөрийн болон төрөөгүй хүүхдийнхээ эрүүл мэндийг эрсдэлд оруулна. Харин зохион байгуулалтанд орсон бичил уурхай дээр эмэгтэйчүүд ихэвчлэн нөхөр аль эсвэл хамаатан садныхаа хамт ажилладаг учраас хөнгөн ажил хийдэг ч ганцаараа бие даан ажилладаг эмэгтэйчүүд, тэр дундаа ганц бие өрх толгойлсон эхчүүд гэр бүлээ тэжээхийн тулд аргагүйн эрхэнд хүнд ажлыг ч үргэлжлүүлэн эрхэлдэг. Энэ нь тэдний хувьд төрөхийн хүндрэл гарах эрсдлийг нэмэгдүүлдэг аж.

Хүснэгт 5. Уурхайн олборлолт болон боловсруулах үйл ажиллагаанд жирэмсэн эмэгтэйчүүдийн оролцоо (N=12)

Жирэмслэлтийн талаар асуулгын хариулт	Тоо
Эмэгтэй жирэмсэн болсноо мэдмэгцээ уурхай болон түүний эргэн тойронд ажиллахаа больдог.	4
Жирэмсэн болсноос хойш тодорхой хугацаанд үргэлжлүүлэн ажилладаг бөгөөд ингэхдээ хөнгөн ажил хийдэг.	7
Жирэмсний сүүлийн саруудад бичил уурхайд ажиллахаа больдог. (6 сараас хойш)	2
Төртлөө ажилладаг.	0
Боловсруулах чиглэлээр үргэлжлүүлэн ажилладаг ч хөнгөн ажил хийдэг.	1
Жирэмсний сүүлийн саруудад боловсруулалтын үйл ажиллагаанд оролцдоггүй. (6 сараас хойш)	4
Төртлөө боловсруулах чиглэлээр ажилладаг.	0
Жирэмсэн эмэгтэйчүүд уурхайн ойр орчим хоол хийх, жижиг дэлгүүр ажиллуулах зэрэг өөр ажил эрхэлдэг.	3

Жирэмслэлттэй холбоотой өөр нэг хүндрэл нь эмэгтэйчүүд жирэмсэн болонгуутаа төрөхийн өмнөх болон төрснийхөө дараах үзлэг, хяналтанд тогтмол хамрагдаж чаддаггүй явдал аж. Гэхдээ энэхүү судалгааг хийсэн зохион байгуулалтанд орсон бичил уурхайнууд дээр жирэмсний үеийн болон төрсний дараах үзлэг, үйлчилгээг авах нь хүндрэлтэй асуудалд тооцогдоогүй. Учир нь хамгийн ойрын сум буюу эмнэлгийн үйлчилгээ авах газар нь бичил уурхайгаас нэг цаг орчмын зайд байрладагтай холбоотой байж болно. Харин алслагдсан бичил уурхайн хувьд эмнэлгийн үйлчилгээ авахад хүндрэл гарна. Суурин газруудын хоорондох зай болон зам, харилцаа хангалттай хөгжөөгүйн улмаас алслагдмал бичил уурхай дээр эмнэлгийн яаралтай тусламж цагт нь тусламж үзүүлж чадахгүй байх магадлал бий. НҮБ-ын ХАС (2007 он) тэмдэглэснээр албан бус бичил уурхайд ажилладаг эмэгтэйчүүд бүртгэлгүйн улмаас жирэмсэн болсоныхоо дараа эмнэлгийн үйлчилгээ авч чаддаггүй гэнэ. Зохион байгуулалтанд орсон бичил уурхайн уурхайчдыг албан ёсоор тухайн орон нутагтаа бүртгүүлэхийг шаарддаг ч хүнд суртал, чирэгдлийн улмаас зарим тохиолдолд бүртгүүлэхгүй байх нь бий (Хайрцаг 3). Нөхөрлөлийн харъяанд байдаг ч бүртгэлгүй л бол эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй гэсэн үг.

Баяжуулах цехэд ажилладаг эр, эм хүмүүсийн хувьд алт ялгахдаа мөнгөн ус ашигладаг нь хамгийн их сэтгэлийг нь түгшээдэг аж. Ялангуяа жирэмсэн эмэгтэйн биенд их хэмжээний мөнгөн ус нэвчин орвол ургийн өсөлтөд асар их хор хөнөөл учруулдаг тул нэн аюултай. Тэр дундаа метил мөнгөн усны хордлого буюу мөнгөн усаар бохирдсон загасыг хүнсэндээ хэрэглэх нь бүр ч их аюултай. Тусгай зориулалтын хамгаалалтын хэрэгсэлгүйгээр мөнгөн ус ашиглах болон алт ялгахад мөнгөн ус ашиглан ууршуулахад ялгарах хорт утаа зэрэг нь урт хугацааны хор уршиг дагуулдаг.


Баримт бичгийн судалгаанд дурдсанаар өнөөдрийг хүртэл хийгдсэн судалгаануудад эр, эм хүмүүсийн хэн нь мөнгөн устай илүү харьцдаг тухай мэдээлэл харилцан адилгүй байгаа юм. Гэхдээ эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол баяжуулах ажиллагаанд илүүтэй оролцдог тул мөнгөн устай илүү их харьцдаг байх магадлал өндөр (Навч ба бусад 2006 он; Бжеррегаард 2009 он). Судалгааны явцад бидний ажилласан бичил уурхай дээрх бичил уурхайчид зохион байгуулалтанд орж, мөнгөн ус ашиглахаа больсон байлаа. Тиймээс мөнгөн усны хэрэглээтэй холбоотой мэдээлэл болон ажиглалт хийгдээгүй (АНУ-ын Азийн сан, pers.com 2013 оны 12 сарын 9). Сэлэнгэ аймгийн Түнхэл сумын алтны үндсэн ордны бичил уурхайд алтыг хүдрээс ялгах зорилгоор сэгсэрдэг ширээг ашигладаг бол алтны шороон ордод мөнгөн ус хэрэглэлгүйгээр шлюз ашиглан хүндийн хүчээр алтыг хүдрээс ялган авдаг.

Бусад жижиг хэмжээний судалгаануудын дүнгээс харахад зохион байгуулалттай бичил уурхай дээр ч өнөөг хүртэл мөнгөн усыг хэрэглэж байгаа бөгөөд ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд мөнгөн усаар алт ялгах тохиолдол гарсаар байна. Жирэмсэн эмэгтэй мөнгөн ус хэрэглэж байгааг харсан эсэх талаар бичил уурхайн 12 ТББ-ын тэргүүнээс асуухад, нэг нь л өөрийн нүдээр хараагүй, телевизээр харсан гэсэн бол дөрөв нь зохион байгуулалттай бичил уурхай дээр жирэмсэн эмэгтэй мөнгөн ус хэрэглэж байхыг өөрийн нүдээр харсан, харин долоо нь зохион байгуулалттай болон зохион байгуулалтанд ороогүй бичил уурхай дээр аль алинд нь харсан гэжээ.

Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч буй хамгийн ноцтой хор нөлөөллийн талаар бичил уурхайчдаас асуухад, дийлэнх нь хөрсний эвдрэл, ухсан гүн нүхнүүдийг дурдсан байна. Харин цөөн тооны бичил уурхайчид буюу гол төлөв эмэгтэйчүүд л усны бохирдлыг хөндсөн нь ар гэрийн ажлаа голлон хариуцаж, хоол хийх, угаалга хийх зэргээр ус ихээр хэрэглэдэгтэй холбоотой байж болно. Гэхдээ бичил уурхайчид мөнгөн усны бохирдлын талаар огт дурдсангүй.

Жендерийн судалгаа хийхээр очсон газар бүрт бичил уурхайчид ядаж л ухсан нүхээ булж байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг нь бүрдүүлэх зэргээр тодорхой хэмжээний нөхөн сэргээлтийг хийсэн байлаа. Жоншны уурхайн нэгэн бичил уурхайчин хуучин ухаж байсан цөл газартаа мод тарьж, мал амьтан сүүдэрлэх газар бий болгохоор төлөвлөж байгаагаа ярьж, ихээхэн өөдрөг байсан юм. Бидний ажилласан бичил уурхайн газруудад эр, эм бичил уурхайчид нөхөн сэргээлтийн ажилд гар бие тэгш оролцжээ. Алтны шороон ордны тухайд гэвэл нөхөрлөл тус бүр нөхөн сэргээлтийн ажилд оролцох төлөөллөө сонгосон бөгөөд дээрх хүмүүсийн ихэнхи нь эмэгтэйчүүд байв.

График 22. Байгаль орчны тулгамдаж буй асуудлын талаар ярилцлаганд хамрагдсан эр, эм бичил уурхайчдын өгсөн хариултууд.



4.10 Уурхайд амжилттай ажиллахад тулгардаг жендерийн онцлог бүхий саад бэрхшээлүүд

Монгол орны эрс тэс уур амьсгалаас эхлээд бичил уурхайд ажиллахад олон саад бэрхшээл тулгарна. Зарим уурхайчдын хэлснээр уурхайд ажиллаж буй эр, эм хүмүүс хүнд хэцүү амьдрах орчин, биеийн хүчний ажил, эрүүл мэндийн эрсдлүүд гээд ижил төстэй бэрхшээлтэй нүүр тулгардаг гэнэ. Мөн эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал ихээхэн хүндрэл учруулдаг бөгөөд энэ талаар нэгэн бичил уурхайчин ярихдаа “Цаг зав, хөрөнгө мөнгөө үрэн байж гүнзгий нүх ухсаны дараа алтны хүдэр олж чадахгүй бол эр, эм хүмүүс адилхан хямардаг” гэв.

Тэхдээ ярилцлаганд хамрагдсан бичил уурхайчдын ихэнх нь эмэгтэйчүүдэд тулгардаг зарим нэг тодорхой хүндрэл, бэрхшээлүүд эрчүүдийнхээс өөр гэж хариулсан бөгөөд эмэгтэйчүүд ар гэрээ авч явах хариуцлага давхар хүлээхээс гадна бие бялдрын хөгжил, биеийн хүчний хувьд сул байдаг нь тэдэнд тулгардаг хамгийн том бэрхшээл гэнэ. Хариултаас иш татвал:

- “Хүнд хэцүү нөхцөл нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг”.
- “Эмэгтэйчүүд үр хүүхдээ харах, тэдний хичээл номонд туслах, гэрээ цэвэрлэх, хоол хийх зэрэг олон үүрэг хариуцлагыг давхар хүлээдэг”
- “Эмэгтэйчүүд уурхайд ажиллахад хоол унд бэлтгэх зав хомсхон болдогоос гадна үр хүүхдүүд нь хараа хяналт, анхаарал халамжгүй үлддэг” гэжээ.

Хайрцаг 2. Жоншны уурхай амьжиргаагаа залгуулах арга хэлбэр болох нь

Уранчимэг өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дахь жоншны бичил уурхай дээр ажиллаж байна. Өмнө нь тэрээр Улаанбаатар хотод гэр бүлийн хамт амьдарч, цалингийнхаа ихэнхийг тээврийн зардалд зарцуулдаг байжээ. Энэ үедээ жоншны уурхайд ажиллавал боломжийн орлого олохоос гадна амьжиргааны өртөг хөдөөд илүү хямд болохыг олж мэдсэн байна. Бичил уурхайн тэргүүний хэлснээр жоншны уурхай дахь нэг бичил уурхайчин сард дунджаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хоёр дахин их буюу 250 ам.доллар олдог аж.

Ийнхүү Уранчимэг нөхрийн хамт Айраг сум руу нүүхдээ хүүхдүүдээ Улаанбаатар хотод өвөө, эмээгийнх нь асрамжинд үлдээв. Түүнд хүүхдүүдээсээ хол байх нь хэцүү бөгөөд Айраг суманд ч хүнд сурталтай нилээд тулгарч, “Надад энэ бүхэн үнэхээр хэцүү байсан. Гэсэн хэдий ч хүүхдүүд маань хотод сургуульд сурахын тулд тэндээ бүртгэлтэй байх хэрэгтэй” гэж ярилаа. Хүнд суртлын улмаас Уранчимэг болон түүний нөхөр сумандаа бүртгүүлж чадаагүй байна.

Уурхай дээр Уранчимэгийн хийдэг үндсэн ажил нь жоншны сайн чанартай буюу гүн хөх, ягааныг нь цайвар өнгөтэйгээс ялгаж тусгаарлах юм. Тэрээр нүх руу орж ажилладаггүй ч, түүнтэй хамт ажилладаг зарим нэгэн эмэгтэйчүүд нүхэнд ажилладаг гэнэ. Ялангуяа жоншны материал нь зөөлөн байвал эмэгтэйчүүд ажиллахад тохиромжтой аж. Уурхайн ажлын хажуугаар эмэгтэйчүүд зохион байгуулалт хийх, орон нутгийн удирдлагуудтай бичил уурхайн эрхлэх газрын эрх авах талаар хэлэлцээр хийнэ. Уранчимэгийн хэлснээр өмнөх сумын засаг дарга бичил уурхайчдыг айлгаж, тоног төхөөрөмжийг нь хураалгахаар цагдаа явуулж байсан удаа бий гэнэ. Үүнтэй холбогдуулан бичил уурхайчин зургаан эмэгтэй дээд шатны удирдлагууддаа гомдол хүргүүлж, улмаар зохих шатны байгууллага гомдлын мөрөөр шүүн мөрдсөний эцэст засаг даргын буруутайг тогтоожээ. Ийнхүү буруутай үйл ажиллагаа явуулсан сумын засаг дарга огцорсон хэмээн Уранчимэг баяртайгаар ярьж байлаа.

Уранчимэгийн яриснаар нөхөрлөлийн зохион байгуулалтанд орох нь их ашигтай аж. Тухайн жоншны орд дахь 3-4 нөхөрлөл хүдэр зөөх экскаватор нийлж авсан бөгөөд ажлыг нь ихээхэн хөнгөвчилсөн байна. Айраг сумын бараг бүх газар уурхайн том компаниудад олгогдчихсон учраас бичил уурхайчдад уурхай эрхлэх газрын зөвшөөрөл авах боломжгүй аж. Гэхдээ Уранчимэг болон түүний хамтрагчид компаниудтай аман гэрээ байгуулан ажиллаж, цаашдаа ч амьжиргаагаа боломжийн хэмжээнд залгуулах боломжтой юм.

Чанарын судалгааны үеэр хөндөгдсөн эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээлүүд дээрхтэй адил байлаа. Нөхөрлөлүүдийн тэргүүний хэлснээр шинээр шилжин ирж, суурьшиж буй залуу эмэгтэйчүүд хүүхдээ эмээ, өвөө аль эсвэл өөр хэн нэгний асрамжинд үлдээх бөгөөд энэ нь тэдэнд эргээд хүндээр тусдаг ажээ. Ер нь эцэг, эх нь өөр газар ажиллахаар явахдаа үр хүүхдээ өвөө, эмээ аль эсвэл өөр хэн нэгэн хамаатных нь асрамжинд үлдээх явдал Монголд түгээмэл бөгөөд хүүхдээ орхиод бичил уурхайд ажиллаж буй эмэгтэйчүүд хүүхдээ хөдөө гэртээ үлдээгээд хотод ажиллахаар ирж байгаа эхчүүдтэй нэгэн ижил.

Ганц бие өрх толгойлсон эхчүүдэд бичил уурхай эрхлэх ихээхэн хүндрэлтэй байдаг талаар олонтаа дурдагдсан. Хамтрагчгүйн улмаас үүрэг хариуцлагаа хуваалцах хүнгүй, дээр нь эх байхын зэрэгцээ уурхайд ажиллах шаардлага давхар тулгардаг нь тэдний гол бэрхшээл аж. Тэдэнд нэгдэн орж, ажиллах нөхөрлөл хайж олохоос эхлээд эрчүүд л хийхэд тохиромжтой гэж тооцогддог зарим ажлыг бие даан ганцаар хийх зэрэг шаардлагууд бас тулгарна.

Бичил уурхайн нөхөрлөлүүдийн тэргүүнүүдийн хэлснээр зарим улс орнуудад сарын тэмдэг нь ирсэн үед эмэгтэйчүүдийг уурхай руу нэвтрүүлдэггүй зэрэг эмэгтэйчүүдэд тавьдаг зарим нэг мухар сүсэгтэй холбоотой ямар нэгэн хориг Монголд харин байдаггүй. Гэхдээ ярилцлагын үеэр нэг эмэгтэй бичил уурхайчин “эмэгтэй хүн газрын гүн рүү орвол алт алга болдог” гэж хэлсэн. Энэ тухай өөр уурхай дээр ажиллахдаа асуусан ч ийм асуудал байдаггүй гэв. Иймэрхүү хорио буюу мухар сүсэг хэзээ, хаана, хэрхэн яаж үүсдэг, дэлгэрдэг болон үр дагаварынх нь талаар илүү нарийвчилсан судалгааг хийх хэрэгтэй. Бидний олж мэдсэнээр эмэгтэй хүн бичил уурхайд ажиллаж, ашиг хүртэхийг хязгаарласан хуулийн зүйл заалт байхгүй.

5. Хэлэлцүүлэг ба дүгнэлт

Сүүлийн арван жилд бичил уурхай хүмүүсийн амьжиргаагаа залгуулах нэг чухал хэрэгсэл болов. Бичил уурхайчдын дунд ажилгүйчүүд, малгүй болсон малчид, оюутнууд зэрэг олон хүмүүс байдаг бөгөөд багагүй хувийг эмэгтэйчүүд эзэлнэ.

Энэ судалгаагаар эр, эм бичил уурхайчдын туршлага, төстэй болон ялгаатай байдал, нөхөрлөл доторх ажил, үүргийн хуваарь, хүндрэл бэрхшээл, гэр бүл болон ажлын байранд шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь оролцоо зэрэгт дүн шинжилгээ хийв. Түүнчлэн, эр, эм хүмүүсийн харилцаа, харилцаан дахь тэгш бус байдал зэргийг судалсан болно.

Судалгааг хийх цаг хугацаа давчуу байсан тул цөөн хэдэн бичил уурхай дээр ажилласан бөгөөд иймд судалгааны үр дүн улсын хэмжээний нийтлэг дүр төрхийг гаргаж чадахгүй байж болно. Судалгааг хийсэн бичил уурхайнуудад бичил уурхайчид зохион байгуулалтанд орж, нөхөрлөл, ТББ байгуулан ажиллаж байсан бөгөөд орон нутгийн удирдлагуудтайгаа ямар нэгэн байдлаар аман гэрээ байгуулжээ. Архи согтууруулах ундаа хэрэглэх, хүүхэд ажиллуулах болон мөнгөн усны хэрэглээг хориглохоос гадна биеэ үнэлэлт ч байгаагүй. Бичил уурхайчид эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, нөхөн сэргээлтийн ажилд оролцож байлаа. Гэхдээ энэ нь Монголын бүхий л бичил уурхайн газрын нийтлэг дүр зураг биш байхыг үгүйсгэхгүй. Ашигт Малтмалын Газрын Бичил уурхайн тасгаас 2012 онд гаргасан мэдээллээр нийт 11 аймгийн хэмжээнд албан зохион байгуулалтанд орсон 1272, зохион байгуулалтанд ороогүй хууль бус 4925 бичил уурхайчид бүртгэгджээ. Иймд хууль бус бичил уурхай дээр нөхцөл байдал өөр байхыг үгүйсгэхгүй бөгөөд энэ талаар тодорхой мэдээлэл өгөх боломжгүй юм.

Гэхдээ НБХСХ-ийн судалгаа болон өмнө нь хийгдсэн бусад судалгаа бидний хээрийн ажлын дүнд олж авсан мэдээллийг бататгасан. Тиймээс чанарын судалгааны мэдээлэл, баримт зохион байгуулалт бүхий бичил уурхай дахь жендерийн харилцааны бодит дүр төрхийг харуулсан гэдэгт бид итгэлтэй байна.

Тоо баримтаас харахад бичил уурхай дахь эрчүүд эмэгтэйчүүдээсээ (30.7 хувь) хоёр дахин их аж. Чанарын судалгааны мэдээллээс харахад алтны шороон орд дээр эмэгтэйчүүд илүүтэй ажилладаг буюу өөрөөр хэлбэл тухайн ордоос хамааран эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ шалтгаалдаг байна. Өмнөх судалгаануудад эмэгтэйчүүд алтны үндсэн ордоос илүүтэйгээр шороон ордод ажиллах нь илүү зохимжтой гэсэн гарсан ч манай тоо үзүүлэлтээр ашигт малтмалын төрлөөс шалтгаалсан жендерийн ялгаа төдийлөн анзаарагдаагүй. Гэхдээ алтны үндсэн ордод шороон болон жоншны ордтой харьцуулахад харьцангуй цөөн эмэгтэйчүүд ажилладаг. Эр, эм бичил уурхайчдийн хувьд нас болон боловсролын түвшин төдийлөн ялгаагүй бөгөөд ажлын байргүй, ажилгүй болсон аль эсвэл бүх малаа алдсан зэргээр бичил уурхай эрхлэх болсон шалтгаан нь ч хоорондоо төстэй байлаа. Ийнхүү бичил уурхайчид хүйсээс хамаарахгүйгээр энэ салбарт үргэлжлүүлэн ажиллах сонирхолтой байна.

Социализмийн үеэс уламжлагдан ирсэн жендерийн тэгш байдлыг хангах уламжлал бичил уурхайн нөхөрлөлүүдэд өнөөг хүртэл хадгалагджээ. Хэдийгээр бичил уурхай дахь ажил, үүргийн хуваарилалт жендерт суурилдаг ч орлогын хувиарлалт тэгш хувиарлагдана. Ашигт малтмалын төрлөөс үл хамааран, малталт хийх, газар дор ажиллах, хүдэр татаж гаргах, ачааны машинд ачих, буулгах зэрэг биеийн хүч ихээр шаарддаг ажлыг гол төлөв эрчүүд хийнэ. Нуралт үүсэх аюултай тул газар дор ажиллах нь хамгийн эрсдэлтэй. Гэхдээ эрэгтэй бичил уурхайчид осолд илүүтэй өртдөг гэх баримт нотолгоо байдаггүй. Бичил уурхайчин эмэгтэйчүүд гол төлөв чулууг цуглуулах, ялгах, дамарт өргүүр ашиглан хүдэр татаж гаргах, боловсруулах, хоол болон цэвэрлэгээ хийх зэрэг үйлчилгээний ажлуудыг хийнэ. Залуу хүүхнүүд газар доор түнелд ажилладаг гэсэн ч энэ талаар мэдээлэл олдоогүй.

Судалгааны үеэр бидний ажилласан бичил уурхай болон түүний эргэн тойронд нэмэлт ажил, үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс тийм ч их байсангүй. Байгаа хэдийг нь бичил уурхайн ТББ-ын хянана. Эрчүүд гол төлөв тээвэртэй холбоотой ажлыг харин эмэгтэйчүүд хоол хийх, ал худалдан авах зэрэг ажлыг хариуцаж байв. Уурхай эрхлэх болон бусад үйлчилгээг үзүүлэхэд ажил, үүргийн жендерт суурилсан тогтсон хуваарилалт байдаггүй бөгөөд бүгд бүх ажлаа хуваан хийж болдог. Манай судалгаагаар бичил уурхайд ажиллаж буй бичил уурхайчдын дунд эрчүүд нь эмэгтэйчүүдийгээ бодвол өдөртөө уртасгасан цагаар, долоо хоногтоо илүү олон өдрөөр ажилладаг бөгөөд энэ нь өмнөх судалгаануудын дүнтэй таарч байна.

Бичил уурхайчид бие даан ажиллахад ажилласан цаг, биеийн хүчний ялгаанаас шалтгаалан эр, эм хүмүүсийн орлого нь өөр байдгийг өмнөх судалгаануудад дурджээ. Харин нөхөрлөлийн харъяанд ажиллахад ажилласан цаг, ажил үүргийн хувиарлалтыг үл харгалзан өөрийн хувийг тэгш хүртэнэ. Бидний ажилласан бичил уурхайн гурван орд (алтны үндсэн болон шороон орд, жоншны орд) дээр уурхайгаас олсон ашгаа бүх гишүүд эн тэнцүү хуваадаг бөгөөд энэ нь ашигт малтмалын төрөл, эмэгтэйчүүдийн эзлэх хувь зэргээс огт хамааралгүй аж. Гэхдээ Монгол Улсад нөхөрлөлийн гишүүн бичил уурхайчид ашгаа тэнцүү хуваан авдаг гэсэн дүгнэлт гаргахаасаа өмнө илүү дэлгэрэнгүй судалгаа хийх хэрэгтэй.

Бичил уурхайчдын хүйсээс шалтгаалан ажил үүргийн хуваарилалт, ажиллах хугацаа ялгаатай байх хэд хэдэн шалтгаан бий. Юуны өмнө эмэгтэйчүүд биеийн хүчний хувьд эрчүүд шиг хүчтэй биш, хоёрдугаарт газар дор ажиллах нь их эрсдэлтэй бөгөөд эрчүүд эмэгтэйчүүдийг эрсдэлд оруулахыг хүсдэггүй, гуравдугаарт уурхайд ажиллах нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг, дөрөвдүгээрт, эмэгтэйчүүд ихэнх цагаа гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдийг асрах зэрэгт зарцуулдаг учраас ийнхүү ялгаатай байх аж. Өрх гэр дотор эрчүүд ус авах, мод хагалах, тавилга хэрэгслийн жижиг эвдрэл засах зэргээр уян хатан байдлаар ажиллах цагаа зохицуулан эрчүүдийн хийх гэрийн ажлуудыг боломжтой цагаараа хийнэ. Дээр дурдсан шалтгааны улмаас эр, эм хүмүүсийн дийлэнх нь уурхайн ажил эмэгтэйчүүд төдийлөн тохиромжтой биш гэж үзсэн байна. Эмэгтэйчүүдээс илүүтэйгээр эрчүүд өөрсдийгөө уурхайн ажилд илүү, эмэгтэйчүүдэд зохимжгүй гэж хариулжээ.

Энэ бүхнээс харахад эмэгтэйчүүд өөрсдийн чадвартаа эрчүүдээс илүү итгэлтэй, өөдрөг аж. Гэхдээ хүдэр баяжуулах, газрын гадаргуугаас чулуу цуглуулах, хоол хийх болон бусад ажил үйлчилгээ уурхайн ажилд тооцогддоггүй гэдгийг энд дурдах нь зүйтэй. Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын тал нь (эрчүүдээс илүү эмэгтэйчүүд) эр, эм хүмүүс уурхайд ажиллах ур чадварын хувьд адил гэв. Тухайлбал зарим уурхайчид эмэгтэйчүүдэд орлого хэрэгтэй, тэгээд ч уурхайн ажил тийм хүнд биш, эмэгтэйчүүд ур чадвар сайтай, хөрвөх чадвар сайн тул уурхайн ажил эмэгтэйчүүдэд ч тохиромжтой гэж үзжээ. Уурхай дээр эмэгтэйчүүд ихэвчлэн нөхрийн хамт ажилладаг ч өрх гэрээ тэжээх үүрэгтэй ганц бие эмэгтэйчүүд ч мөн ажиллана.

Эмэгтэйчүүд бичил уурхайд ажиллахаас авахуулаад бичил уурхайн нөхөрлөл болон ТББ-ыг ч тэргүүлэн ажиллаж байна. Зохион байгуулалтанд орох нь баталгаат ажлын байр бий болох, аюулгүй байдал нэмэгдэх, мэдээлэл, үйлчилгээний хүртээмж сайжрах зэрэг олон давуу талтай бөгөөд энэхүү давуу талууд нөхөрлөлийн гишүүн эр, эм бичил уурхайчдад ижил үйлчилнэ. Нөхөрлөлийн хүрээнд аливаа шийдвэрийг гаргахдаа ардчилсан зарчмыг баримтлах бөгөөд өрх гэр бүлийн түвшинд шийдвэр гаргахдаа эр, эм хүмүүс эрх, тэгш оролцдогтой адил оролцоотой. Харин өрхийн санхүү болон нийгмийн халамжтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад эмэгтэйчүүд арай илүү нөлөөтэй байх нь бий. Ийнхүү бичил уурхайн нөхөрлөл болон ТББ-ын гишүүн бүр эрх, тэгш оролцоотойгоор шийдвэр гаргадаг нь ажлын байрны аюулгүй байдал, байгаль орчны нөхөн сэргээлт зэрэг уурхайтай холбоотой олон асуудлуудыг хамтран хэлэлцэж, шийдвэрлэх боломжийг бий болгожээ. Бидний ажилласан уурхай дээр жендерт суурилсан хүчирхийллийг хүндрэлтэй асуудал хэмээн тодорхойлоогүй ч иймэрхүү эмзэг асуудлыг бичил уурхайн нөхөрлөл болон ТББ-ын хүрээнд хэлэлцэж болох нь судалгааны дүнгээс харагдав.

Нөхөрлөлийн тэргүүнээр ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо (30.6 хувь) бичил уурхай дахь нийт эмэгтэйчүүдийн тоотой харьцуулахад харьцааны хувьд тохиромжтой бөгөөд энэ дэд салбарт эмэгтэйчүүдийн удирдах албан тушаал хаших боломж эрчүүдтэй нэгэн адил аж. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн тал хувь нь нөхөрлөлийн тэргүүнээр ажиллахад хүйс төдийлөн чухал биш гээд, эмэгтэй тэргүүн харин ч хэл, яриа сайтай, аливаа асуудлыг зохицуулахдаа илүү хэмээн магтжээ. Хэдийгээр нийт бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь эрчүүд бөгөөд нөхөрлөлийн тэргүүнээрээ эр хүнийг сонгох сонирхол арай илүү байлаг ч тоо, баримтаас харахад аль ч хүйсийн бичил уурхайчид эмэгтэйчүүдийг нөхөрлөлийн тэргүүнээр ажиллах бүрэн чадамжтай гэж үздэг байна.

Эрчүүд илүү олон цагаар ажиллаж, хамгийн “хүнд” гэх ажлуудыг хийдэг ч нөхөрлөл дотор ашгийг тэнцүү хуваана. Ашиг хуваахад хүйс, хийдэг ажил, ажлын бүтээмж/гарц, нөхөрлөлийн тэргүүн эсэх зэргийг огт харгалзан үздэггүй. Социалзмын үеэс уламжилагдан ирсэн хандлага, ихэвчлэн гэр бүлээрээ нэг нөхөрлөлд ажилладаг зэрэгтэй энэ нь холбоотой байх магадлалтай. Гэхдээ өмнөх бусад судалгаануудад эмэгтэй бичил уурхайчид эрчүүдээс бага орлого олдог гэсэн тоо баримт бий. Бидний үзэж буйгаар дээрх судалгаануудад хамрагдсан эмэгтэйчүүдийн зарим нь нөхөрлөлийн зохион байгуулалтанд ороогүй, орлого нь бие даан олборлосон алтны хэмжээнээс хамаардагтай холбоотой болов уу. Эмэгтэйчүүд эрчүүдээс бага цагаар (дунджаар) ажилладаг учраас бие даан ганцаараа ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн орлого бага байх тохиолдол бий. Тиймээс эмэгтэйчүүдийн хувьд нөхөрлөлийн харъяанд ажиллах нь илүү ашигтай юм.

Бидний ажилласан бичил уурхайнуудад бэлгийн хүчирхийлэл болон дарамт хүндрэлтэй асуудалд тооцогддоогүй. Хүчирхийлэл нь гол төлөв архины хэрэглээтэй холбоотой гардаг бөгөөд дээрх бичил уурхайнуудад архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон байв. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн хэлснээр гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг хүчирхийлэл ч мөн зүй бус үйлдэл юм. Бидний ажилласан бичил уурхайнууд бүгд зохион байгуулалтанд орсон, эрүүл мэнд, нийгмийн асуудлуудаа харьцангуй эерэгээр шийдчихсэн байсан тул өмнөх бусад судалгаа буюу хууль бус “нинжа” нарын талаарх судалгаануудын дүнгээс өөр дүр зураг гарсан. Тухайлбал, бие үнэлэлт, архидалт болон мөнгөн усны хэрэглээ байгаагүйгээс гадна сумын төвтэйгөө харьцангуй ойрхон учраас сумандаа бүртгэлтэй бичил уурхайчид эрүүл мэндийн үйлчилгээ авах бүрэн боломжтой байлаа.

Ийнхүү бичил уурхай нь хүйсийн тэгш байдал хангагдсан дэд салбар мэт дүр зураг гарсан ч хэд хэдэн үзүүлэлтээр эрчүүд болон зарим нэг эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийг уурхайн ажил хийх тохиромжгүй хэмээн үздэг нь харагдав. Ярилцлага хийсэн хүмүүсийн нилээд олонхи нь уурхайн ажил эмэгтэйчүүдэд тохиромжгүй, энэ төрлийн ажилд эрчүүд илүү, нөхөрлөлийн тэргүүнээр эр хүн ажиллах нь зохимжтой гэх зэргээр хариулсан нь бий. Эмэгтэйчүүд уурхайд олон цагаар ажиллалаа ч гэрийн ажил, үр хүүхдээ асрах, угаалга цэвэрлэгээ хийх зэрэг давхар үүрэг үүрсээр л. Өөрөөр хэлбэл бичил уурхайчин эмэгтэйчүүд өөр салбарт бүтэн цагаар ажиллаж байгаа Монгол эмэгтэйчүүд төдийгүй дэлхийн өнцөг булан бүр дэх эмэгтэйчүүдтэй нэгэн адил давхар үүрэг хариуцлага хүлээж байна (баримт бичгийн судалгааг харна уу). Ганц бие эхчүүд уурхайн ажлын хажуугаар ар гэрийн бусад ажлаа хослуулан хийх зэргээр ихээхэн хүндрэлтэй тулгардаг учраас тун эмзэг аж. Гэхдээ бидний очсон уурхай дээр өөр газраас шилжин ирсэн ганц бие эмэгтэйчүүд таараагүй тул тэдний нөхцөл байдал хүнд хэмээн хэлэх боломжгүй юм.

Ерөнхийдөө эмэгтэйчүүд эрчүүдтэй адил ашиг хүртэх боломжтой, дээр нь олох орлого нь бусад ажлын байртай харьцуулахад харьцангуй их зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас бичил уурхай эмэгтэйчүүдийн хувьд амьжиргаагаа залгуулах боломжийн арга хэлбэрт тооцогдож байна. Түүнчлэн эмэгтэйчүүд бичил уурхайн нөхөрлөл, ТББ тэргүүлэн ажиллах бүрэн чадамжтай бөгөөд олон ч эмэгтэйчүүд сонгогдон ажиллаж байгааг хараад бахархах сэтгэл төрсөн. Ер нь бичил уурхайн дэд салбарт ажилласнаараа эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэл нь дээшилж, улмаар удирдан, манлайлах чадавх нь сайжирсан байна.

Зөвлөмж

1. Монгол улсын хэмжээнд бичил уурхай нь эр, эм хүмүүсийн хувьд амьжиргаагаа залгуулах боломжийн арга бөгөөд хатуу ширүүн цаг агаар, байгалийн үзэгдлийн улмаас малгүй болсон хөдөөгийн иргэд, шилжилтийн үеийн эдийн засгийн хямралд өртөж ажилгүй болсон олон мянган гэр бүлд ашиг тусаа өгч байна.
2. Энэ судалгаа нь бичил уурхайн дэд салбар дахь жендерийн нөхцөл байдлыг судлаж, тулгарч буй хэрэгцээ шаардлага, ажил үүргийн хуваарилалт, оролцоо, нөөц баялаг, өсч дэвших боломж, шийдвэр гаргах эрх мэдэл зэргийг тодорхойлох зорилготой.
3. Судалгааны зөвлөмжийн хэсэг нь “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II” төслийн хүрээнд жендерийн тэгш байдлыг хангаж, жендерт суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн болно.
4. Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд цуглуулсан бүхий л мэдээлэл, тоо баримт болон үр дүнг харгалзан үзээд,
 - Төслийн үр дүнг сайжруулах,
 - Санал болгож буй үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага, засгийн газрын агентлаг, хэлтсийг тодорхойлох,
 - Монгол дахь бичил уурхайн дэд салбарт ажиллаж буй эр, эм хүмүүсийг тэгш эрхтэйгээр хамруулсан хамгийн боломжит харилцааны стратегийг боловсруулахын тулд энэхүү зөвлөмжийг гаргасан болно.

Зөвлөмж дөрвөн хэсэгтэй. Үүнд:

1. **Богино хугацаанд үр дүн нь гарах бодлогын хамтын ажиллагаа.**

Энэхүү үйл ажиллагаа нь богино хугацаанд, бага хүчин чармайлтаар хэрэгжүүлэх боломжтой бөгөөд “Бодлого”-д бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу стратеги, “Хамтын ажиллагаа”-нд бичил уурхай болон жендерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамтран бичил уурхай дахь хүйсийн тэгш байдлыг хангах төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх чадавхийг нь сайжруулахад чиглэх юм. Харин “Судалгаа”-ны хэсэгт хүйсийн асуудлыг тусгасан Хяналт, үнэлгээний систем хэрэгжүүлэхийг дэмжин, улмаар Монгол дахь бичил уурхайн дэд салбарын жендерийн асуудлыг хөндөн судлах нэмэлт судалгаануудыг тодорхойлов.

Богино хугацаанд хэрэгжүүлж үр дүнгээ өгөх боломжтой дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

1. **МУ-ын Засгийн газар болон бусад байгууллагуудаас зохион байгуулж буй бичил уурхайтай холбоотой хурал, зөвлөгөөнүүдэд аль болох олон эмэгтэйчүүдийг оролцуулах үүднээс боломжийг нь нээж өгөх, тулгарах бэрхшээлийг нь багасгах, устгах**
 - a. Эмэгтэйчүүд (ялангуяа бага насны хүүхэдтэй бол) гэрийн ажил хийх, хүүхдээ асрах зэргээр завгүй байдаг тул Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй хурал, зөвлөгөөнүүдэд оролцох боломж тэр бүр олддоггүй. Иймд боломжтой тохиолдолд тухайн бичил уурхайчдын ажиллаж, амьдарч буй газрынх нь ойролцоо дээрх хурал, зөвлөгөөнийг зохион байгуулбал илүү үр дүнтэй.
 - b. Эмэгтэйчүүд үр хүүхдээ сургуульд нь бэлтгэх, хүргэж өгөх, өдрийн хоолоо хийх зэргээс шалтгаалан өглөө эрт зохион байгуулагдаж буй арга хэмжээнүүдэд оролцох боломж хомс. Иймд үдээс өмнө буюу өдрийн хоолны цагаас нэг цагийн өмнө аль эсвэл өдрийн хоолны цагийн дараа эмэгтэйчүүдэд хамгийн тохиромжтой байх магадлал өндөр.
 - c. Бага насны хүүхэдтэй эхчүүдийн хувьд амралтын өдрөөр хүүхдүүд нь гэртээ байдаг тул

- аливаа төслийн үйл ажиллагаанд оролцох нь боломж нь бас хомс байж болно.
- d. Бичил уурхайн нөхөрлөл, ТББ-ын эмэгтэй тэргүүнүүдтэй нягт хамтран ажиллаж, хурал, семинар зохион байгуулахад хамгийн тохиромжтой өдөр/цагийг тодорхойлбол тухайн арга хэмжээнд эр, эм хүмүүс аль аль нь тэгш оролцох боломж бүрдэнэ.
2. **Ганц бие ээжүүдийг ШХА-ийн ТБУ төслийн үйл ажиллагаанд оролцуулахад дэмжлэг үзүүлэх.** Тэд харьцангуй хүнд амьдралтайгаас гадна эмэгтэй бичил уурхайчдын нилээдгүй хувийг эзэлдэг. Иймд
 - a. Төслийн аливаа арга хэмжээний үеэр хүүхэд харах үйлчилгээг үзүүлэх (жишээ нь тусдаа өрөөнд хүүхдийн булан гаргах гэх мэт)
 - b. ТББ-ын тэргүүнүүдээр тухайн бичил уурхай дээр ажилладаг ганц бие эхчүүдийг тодорхойлж, улмаар төслийн үйл ажиллагаанд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэхийг хүсэх.
 3. Засгийн газрын байгууллагууд болон холбогдох газар, хэлтсүүд бичил уурхайтай холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхдээ **жендерийн хувьд дундыг баримталсан үг хэллэг хэрэглэж**, эр, эм хүмүүс тэгш эрхтэй гэдгийг харуулах. Үүнд:
 - a. Бичил уурхайчны талаар ярихдаа “тэр эрэгтэй” хэмээн хүйсээр нь төлөөлүүлэлгүй, харин аль ч хүйсийг илэрхийлэх дундыг баримталсан үг хэллэг хэрэглэх.
 - b. “Уурхай” гэдгийг ихэвчлэн газар шорооны ажил буюу газрын гүнд орж ажиллахыг хэлдэг гэсэн буруу ойлголт бий. Гэтэл дээрх ажлуудыг эмэгтэйчүүд төдийлөн хийдэггүй тул бичил уурхайчдад зориулсан аливаа хурал, семинарыг зохион байгуулахдаа бичил уурхайн бүхий л үйл ажиллагааг эрхэлдэг хүмүүсийг адил тэгш урьж буйгаа тодорхой илэрхийлэх нь зүйтэй.
 4. **Төслийн арга хэмжээг зохион байгуулахдаа эр, эм хүмүүсийн аль алинд нь тохиромжтой цаг хугацааг сонгох хэрэгтэй.**
 - a. Бичил уурхайчид хүйсээс шалтгаалахгүйгээр аль аль нь өвлийн улиралд ажилладаггүй бөгөөд ажилласан ч цөөн цагаар ажиллана. Бичил уурхай нь уурхайчдынхаа амьдардаг газартай ойрхон тохиолдолд уулзалт, семинар хийхэд тохиромжтой цаг нь өвлийн улирал байж болох бөгөөд бичил уурхайчдын ажлын цагт төдийлөн нөлөөлөхгүй.
 - b. Харин газар дээр нь хийгдэх бусад сургалт, таниулах үйл ажиллагааг зуны улирал буюу олон хүмүүс уурхай дээрээ ажиллаж байх үед хийх нь илүү тохиромжтой.
 5. **Тухайн сургалт, семинар аль нэг хүйсийн талаар давамгайлсан агуулгатай асуудлыг хэлэлцэх байсан ч тухайн арга хэмжээндээ эр, эм хүмүүсийг тэгш оролцуулах, урих хэрэгтэй.** Бидний олж мэдсэнээр уурхайн олон ажлыг аль ч хүйсийн хүн хийх боломжтойгоос гадна эмэгтэй хүн хийдэггүй байсан ч нөхөрлөл дэх өөрийн байр сууриар дамжуулан эрчүүдэд нөлөөлдөг байна.
 - a. Өрхийн эрэгтэй тэргүүн тухайн гэр бүлийн гол тэжээгч байдаг ч өрх гэр бүл болон нөхөрлөлийн түвшинд санхүүтэй холбоотой шийдвэрийг эр, эм хүмүүс хамтран гаргадаг. Иймд санхүүгийн чиглэлээрх сургалтанд (жишээ нь: хадгаламж, хөрөнгө оруулалт, бичил санхүү гэх мэт) эр, эм хүмүүсийг адилхан хамруулах хэрэгтэй.
 - b. Мөнгөн усны хэрэглээг бууруулахад чиглэсэн аливаа сургалт болон төслийн бусад үйл ажиллагаанд баяжуулахад ажиллаж буй бичил уурхайчид болон нөхөрлөлийн тэргүүнүүдийг хүйс харгалзалгүй хамтад нь хамруулах хэрэгтэй.

Бодлого

6. Бичил уурхай дахь эмэгтэйчүүдийн нөхцөл байдал сайжрах тул **Бичил уурхайчдыг зохион байгуулалтанд оруулах, нөхөрлөл байгуулах үйл явцыг дэмжих.**
 - a. МУ-ын Засгийн газрын зүгээс зохион байгуулалтанд орсон бичил уурхайчдад ашигт малтмалын газар геологийн хайгуул хийх, албан ёсны газрын зөвшөөрөл авахад нь хөнгөлөлт үзүүлэх замаар дэмжлэг үзүүлж болно.
 - b. Орон нутгийн удирдлагын зүгээс албан зохион байгуулалтанд ороогүй бичил уурхайчдад зохион байгуулалтанд орох талаар мэдээлэл өгөх шаардлагатай.
 - c. ШХА-ын ТБУ төслийн зүгээс албан бус бичил уурхайчдад зохион байгуулалтанд орж, нөхөрлөл байгуулах, улмаар шаардагдах хөрөнгө санхүүжилт болон ашиг тусынх нь талаар сургалт зохион байгуулж болно.
7. **Бичил уурхай дээр архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох.**
 - a. ШХА-ын ТБУ төслийн хүрээнд үндэсний болон орон нутгийн удирдлагын түвшинд бичил уурхай дээр архи хэрэглэхийг хориглох талаар нөлөөллийн ажил хийж болно.
 - b. Орон нутгийн удирдлагын зүгээс тухайн суманд үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай дээр архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох тухай журам гаргах.
 - c. Орон нутгийн удирдлагын зүгээс бичил уурхай дээрх архины хэрэглээг хянах талаар холбогдох байгууллагуудад (жишээ нь: цагдаа) үүрэг өгч, зохион байгуулах.
8. **“Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II” төслийн хүрээнд алтны уурхай дахь мөнгөн усны хэрэглээг зогсоох үүднээс үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагчдын чадавхийг бэхжүүлэх.** Харамсалтай нь өнөөдөр жирэмсэн эмэгтэйчүүд болон бусад бичил уурхайчид дээрх хорт бодисыг ашигласан хэвээр байна.
 - a. Минаматагийн конвенцтай холбоотойгоор мөнгөн усны асуудал хөндөгдөх болсон тул энэхүү завшааныг ашиглан үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагч нарын анхаарлыг дээрх асуудалд чиглүүлэх.
 - b. Минаматагийн конвенцийг мөрдөж ажиллах стратегийг боловсруулахад үндэсний бодлого боловсруулагч нарт дэмжлэг үзүүлэх. Стратегийг боловсруулахдаа Монгол улсын нийгэм эдийн засаг, улс төр болон хууль эрх зүйн байдалд нийцүүлэх, үүнд бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээнд онцгой анхаарал хандуулах.
 - c. Үндэсний болон орон нутгийн бодлого боловсруулагчдад мөнгөн ус ашиглахгүйгээр алт баяжуулах шинэ технологийн талаар мэдээлэл өгөх, сурталчлан таниулах, улмаар хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.
 - d. Төрийн албан хаагч нартай ажиллахдаа жирэмсэн эмэгтэйчүүд мөнгөн усны хорлогод өртөх магадлалтай болохыг онцлон тэмдэглэх.
9. **Төв суурингаас алслагдсан газарт бичил уурхай эрхлэгч жирэмсэн эмэгтэйчүүдийн төрөхийн өмнөх болон төрсний дараах эмнэлгийн үзлэг, үйлчилгээнд хамрагдах боломжийг нь нэмэгдүүлэх.**
 - a. Төв суурингаас алслагдсан бичил уурхайд ажиллаж буй хүмүүст анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх талаар ШХА-ын ТБУ төслийн зүгээс Монгол Улсын засгийн газарт нөлөөллийн ажил хийх.
 - b. Эрүүл мэндийн яамны зүгээс хөдөлгөөнт эмнэлэгийн үйлчилгээ буюу эмнэлгийн ажилтнуудыг тодорхой газруудаар (жишээ нь: сум) явж бичил уурхайн газруудад долоо хоногт дор хаяж нэг удаа очиж үйлчилдэг туршилтын төсөл эхлүүлэхийг зөвлөж байна. Иймэрхүү төслийг Өмнөд Америкийн Амазон мөрөн орчмын алслагдсан газрууд болон зарим уурхайн бүсүүдэд хэрэгжүүлдэг юм.

10. Бичил уурхайн ойр орчимд Мэдээлэл, Үйлчилгээний Төв байгуулах

- a. Бичил уурхайчидтай нягт хамтран ажиллах (зохион байгуулалтанд орсон болон ороогүй), ЗГ-ын уул уурхайн хэлтсийн зүгээс бичил уурхайд тавих хяналтыг сайжруулах үүднээс Уул уурхайн Мэдээлэл, Үйлчилгээний Төвийг байгуулж, төвөөрөө дамжуулан бичил уурхайчдад мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэх. Бичил уурхайчид уурхайтай холбоотой асуулт (уурхай эрхлэх газрын зөвшөөрөл хэрхэн авах гэх мэт) болон бусад асуудлаар (жишээ нь: хэрхэн бүртгүүлэх гэх мэт) тус төвд ханддаг байх. Монголын байгаль орчны консорциум нь үүнтэй ижил төстэй нэгэн санаачлага болох "Гэр Мэдээллийн Төв"-ийг ажиллуулж байна.
- b. Уул уурхайн Мэдээлэл, Үйлчилгээний Төвөөр дамжуулан бичил уурхайчдад хариуцлагатай уул уурхайн арга хэрэглэгдэхүүн, мөнгөн уснаас хэрхэн өөрсдийгөө хамгаалах, тэр дундаа жирэмсэн болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг хэрхэн хамгаалах талаар тогтмол мэдээлэл түгээж байх.

11. Өөр газраас шилжин суурьшиж буй бичил уурхайчдыг тухайн орон нутагт оршин суугчаар бүртгүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх. Бүртгэлгүйн улмаас эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхдийн өдөр өнжүүлэх/цэцэрлэг болон бусад нийгмийн хамгааллын үйлчилгээнүүдэд хамрагдах боломжгүй болдог бөгөөд энэ нь аль ч хүйсийн бичил уурхайчдад тэр дундаа эмэгтэйчүүдэд ихээхэн хүндрэл учруулна.

- a. Бичил уурхайчид шинэ суманд шилжин ирсэн тохиолдолд орон нутгийн удирдлагын зүгээс бүртгэл хийлгэхийг дэмжин өөгшүүлдэг байх.
- b. Уурхайчдыг хоёр суманд бүртгэлтэй байхыг зөвшөөрөх, тухайлбал аль нэг суманд нь зочин/түр оршин суугчаар бүртгүүлэх.

Хамтын ажиллагаа**12. Төслийн хүрээнд бичил уурхайн тэргүүнүүдээр (хүйс хамаарахгүйгээр) дамжуулан өөрчлөлт хийхийн төлөө ажиллах шаардлагатай.**

- a. Бичил уурхайн ТББ болон нөхөрлөлийн тэргүүнүүдийн сүлжээг үүсгэж, холбоо барих хаягийг нь бүртгэх.
- b. Бичил уурхайн ТББ болон нөхөрлөлийн тэргүүнүүдэд төслийн үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл өгч байх.

13. Жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг бичил уурхай дээр ажиллахад нь ШХА-ын ТБУ төслөөс дэмжлэг үзүүлэх. Ихэнх бичил уурхай дээрх ТББ-уудын үйл ажиллагаа явуулдаг газруудаас алслагдсан хол газар байрладаг.

- a. Жендерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын жагсаалтыг гарган үйл ажиллагааны чиглэлийг нь тодорхойлж, уул уурхай бүхий газруудад ажиллах сонирхолтой эсэхийг нь олж тогтоох.
- b. Холбогдох ТББ-уудыг уулзалтанд урьж хамтран ажиллах боломжыг тодорхойлох.
- c. Хөдөө орон нутагт томилолтоор ажиллахдаа жендерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тохиромжтой ТББ-ын төлөөллийг урих.

14. Бичил уурхайн газруудад Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг компанит ажил зохион байгуулах.

- a. Монгол дахь бичил уурхайнуудад жендерт суурилсан хүчирхийллийг зогсоох зорилгоор Тогтвортой хөгжлийн төлөөх Жендер төв, АНУ-ын Азийн сан болон ШХА/ТБУ төслийн хооронд хамтын ажиллагааг өрнүүлэх.

- b. Орон нутгийн удирдлагууд болон холбогдох төрийн байгууллагуудад ЖСХ-ийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар сургалт явуулах дотоодын зөвлөх хөлслөх (жишээ нь: ТХТЖТ)
- c. ШХА/ТБУ төслийн зүгээс бичил уурхайн зохион байгуулалтанд орсон болон ороогүй бичил уурхай дахь ЖСХ-ийн хэргүүдийг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэх, энэхүү асуудлыг анхаарлын төвд оруулахад үндэсний болон орон нутгийн удирдлагуудад нөлөөллийн ажил хийх.

Судалгаа

15. Бичил уурхай бүхий газрууд дахь ЖСХ-ийн талаар үндэсний хэмжээний судалгаа хийх.

- a. Бичил уурхай бүхий газруудад дахь ЖСХ-ийн талаар үндэсний хэмжээний судалгаа хийлгэхээр жендерийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай дотоодын зөвлөхийг урьж ажиллуулах.
- b. Судалгаанд зохион байгуулалтанд орсон болон ороогүй бичил уурхайнуудыг жигд хамруулж, ялгааг нь олж тогтоох.

16. Хяналт, үнэлгээ хийхдээ жендерийн асуудлыг тусгаж оруулах

- a. Хяналт, үнэлгээний систем боловсруулж, хэрэгжүүлэхдээ жендерт суурилсан үзүүлэлтүүдийг ашиглах. Тухайлбал:
 - Бичил уурхай эрхэлж байгаа эр, эм хүмүүсийн эзлэх хувь хэмжээ, үүнд уурхайн орчимд ажил, үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийг мөн хамруулах.
 - Эр, эм нөхөрлөлийн тэргүүнүүдийн эзлэх хувь хэмжээ.
 - Төслийн үйл ажиллагаанд хамрагдаж буй бичил уурхайчдыг хүйсээр нь ялган, эзлэх хувь хэмжээг тогтоох.
 - Гишүүд дотроо орлогоо эн тэнцүү хувиарладаг бичил уурхайн нөхөрлөлүүдийн эзлэх хувь, хэмжээ (зардлаа хассаны дараах)
 - Мөнгөн ус мэтийн химийн бодистой харьцдаг эр, эм хүмүүсийн эзлэх хувь хэмжээ.
 - Бэлгийн дарамтанд ямар нэг байдлаар өртөж байсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээ.
- b. Жендерт суурилсан үзүүлэлтүүдийг ашиглахын зэрэгцээ төслийн хүрээнд Хяналт, үнэлгээний систем ашиглан цуглуулсан бүхий л мэдээллээ хүйсээр нь ангилан ялгах хэрэгтэй юм. Тухайлбал осол гэмтэл, олох орлого, зээл авах боломж болон бусад мэдээллийг цуглуулахдаа хүйсээр нь ялган гаргавал бичил уурхай эр, эм хүмүүсийн ахуй амьдралд хэрхэн нөлөөлж байгааг тогтоох боломж бүрдэнэ.

17. Зарим бичил уурхайчид зохион байгуулалтанд орохгүй байгаа талаар судалгаа хийх. Зохион байгуулалтанд орох нь олон давуу талтай ч өнөөг хүртэл нилээд бичил уурхайчид тодорхойгүй шалтгаанаар бие даан ажилласаар байна.

- a. Бичил уурхайчдыг зохион байгуулалтанд оруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг төслийн хувьд ШХА/ТБУ төслийн зүгээс учир шалтгааныг тодруулах судалгааг санхүүжүүлэн хийлгэж болох юм.
- b. Судалгаанд албажсан болон албан зохион байгуулалтанд ороогүй бичил уурхайчдыг жигд хамруулан, нөхцөл байдал, байр суурийг харьцуулан үзэх хэрэгтэй.

Ашигласан материал

- ADB (Asian Development Bank) Mongolia (2010) Gender Equity in Mongolia: Unfinished Business. Ulaanbaatar: ADB Mongolia
- ADB (Asian Development Bank) Mongolia (2008). *Country Gender Assessment*. Unpublished report to ADB Mongolia. Ulaanbaatar: ADB Mongolia.
- Anderson and Anderson LLP (2010). Land law of Mongolia. Internet document. URL: <http://www.anallp.com/land-law-of-mongolia/>. Accessed 7 August 2013.
- Bjerregaard, Alisha (2009). *Gender and Mining: An Assessment of the Impact of Gold Mining on Women in Mongolia*. In: APWLD (Ed). Mining and Women in Asia: Experiences of women protecting their communities and human rights against corporate mining. Amphoe Muang, Thailand: Asia Pacific Forum on Women, Law and Development, Pp 35-69
- National Center Against Violence (NCAV), Citizens' Alliance (CCA), and Center for Human Rights Development (2009). *The situation of sexual violence and rape and relevant legislations in Mongolia*. Internet document. URL: http://www.stopvaw.org/Research_and_Reports_Mongolia
- Eftimie et al. 2012. Gender Dimensions of Artisanal and Small-Scale Mining. A Rapid Assessment Toolkit. The World Bank
- Government of Mongolia (2011). The Millennium Development Goals Implementation Fourth National Report. Ulaanbaatar
- Government of Mongolia (2002). *Law on allocation of land to Mongolian citizens for ownership*. Unofficial translation. Internet document. URL: http://www.mad-mongolia.com/wp-content/files_mf/lawofmongoliaonland:revisedversion:.pdf Accessed 7 August 2013
- Government of Mongolia (1999). *Labor Code*. State Bulletin, No. 25. Law of Mongolia, May 14, 1999. (ILO translation) <http://www.ilo.org/dyn/natlex/docs/SERIAL/57592/49012/F1417624175/MNG57592.pdf>
- Government of Mongolia (1992). The Constitution of Mongolia. State Bulletin No. 1, 1992. Internet document. URL: http://www.frc.mn/engnew/index.php?option=com_docman&task=doc_download&gid=217&Itemid=63 . Accessed 7 August 2013.
- Grainger David (22 December 2003). "The Great Mongolian Gold Rush". CNNMoney.com. Retrieved 12 August 2013.
- Grayson, Robin, Tsevel Delgertsoo, William Murray, Baatar Tumenbayar, Minjin Batbayar, Urtnasan Tuul, Daszeveg Bayarbat and Chimed Erdene-Baatar (2004). *The People's Gold Rush in Mongolia. The Rise of the 'Ninja' Phenomemnon*. World Placer Journal 4 (Nov. 2004)
- High, Mette M. (2012) *The Cultural Logics of Illegality: Living Outside the Law in the Mongolian Gold Mines*. In: Change in Democratic Mongolia: Social Relations, Health, Mobile Pastoralism, and Mining. J. Dierkes (Ed.). Pp. 249-270. Brill Publishers: Leiden
- High, Mette M. (2008) *Wealth and envy in the Mongolian gold mines*. Cambridge anthropology, 27(3). pp. 1-18.
- IPEC (International Programme on the Elimination of Child Labor) (2007). *Ending Child Labor in Mining: Field experiences and analysis of interventions from Mongolia*. Geneva: International Labor Office

- Kamata et al. (2010). *Managing urban expansion in Mongolia: best practices in scenario-based urban planning*. Washington DC: The World Bank
- MNEC (Mongolian Nature and Environment Consortium) (2011) *Improving the life of informal Gold miners in Zaamar Gold field*. Ulaanbaatar, Mongolia: MNEC
- Navch, T., Ts. Bolormaa, B. Enkhsetseg, D. Khurelmaa and B. Munkhjargal (2007). *Informal Gold Mining in Mongolia. A Baseline Survey Report Covering Bornuur and Zaamar Souns, Tuv Aimag*. Informal Economy, poverty and Employment. Mongolia Series, No. 1. Bangkok: International Labor Office.
- NSO (National Statistics Office of Mongolia) (2013). Main Statistical Indicators. Website. Accessed August 12, 2013.
- Purevjav, Bolormaa (2011). *Artisanal and Small-Scale Mining: Gender and Sustainable Livelihoods in Mongolia*. In: Gendering the Field. Towards Sustainable Livelihoods for Mining Communities. Lahiri-Dutt, K. (Ed.) Asia-Pacific Environment Monographs, No. 6. Canberra ACT: Australian National University E Press: Pp. 197–212
- Swiss agency for Development and Cooperation (2008). Combating Violence against Women. Internet document. URL : http://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&frm=1&source=web&cd=8&ved=0CG8QFjAH&url=http%3A%2F%2Fwww.swiss-cooperation.admin.ch%2Fmongolia%2Fressources%2Fresource_en_169615.pdf&ei=bDylUtOAJdKNkAeas4HYDw&usg=AFQjCNFNkkrReCJ389k-jhfhDxnAPeMQ2A
- The Asia Foundation (TAF) (2013). *Mongolia*. Internet document. URL: <http://asiafoundation.org/resources/pdfs/Mongolia.pdf>
- Uitterdijk Appel, P. 2005 Small-scale mining in Mongolia – A survey carried out in 2004
- DANMARKS OG GRØNLANDS GEOLOGISKE UNDERSTØTTELSE RAPPORT 2005/4
- Via: http://www.geus.dk/program-areas/common/geus_rep_2005-4.pdf
- UNDP (United Nations Development Program) (2013). *Human Development Report 2013* Internet document. URL: <http://hdrstats.undp.org/images/explanations/MNG.pdf>
- UNFPA (United Nations Population Fund) and School of public Health (2007). *Socio-Economic Situation of Artisanal Miners in Mongolia*. Ulaanbaatar: UNFPA/School of Public Health, Health Sciences University of Mongolia.
- World Bank (2013) GDP Per Capita, current US\$. Data table. Website. URL: <http://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD>. Accessed 12 August 2013

Хавсралт 1 Судалгааны хэрэглэгдэхүүн

Бичил уурхайд ажилладаггүй эмэгтэйчүүдтэй хийх ярилцлага

Ярилцлаганд хамрагдах эмэгтэйчүүд нь гэр бүлийн хамт бичил уурхай дээр ирсэн ч бичил уурхайд ажилладаггүй болон бусад үйлчилгээний салбарт ажиллаж буй эмэгтэйчүүд байх юм.

1. Байршил (аймаг, сум ба байршиж буй газрын нэр) ба огноог тэмдэглэх
2. Танай гэр бүл бичил уурхай руу нүүж ирсэн шалтгаан (жишээ нь: бичил уурхай эрхлэх, малын бэлчээр, г.м.)
3. Гэр бүлийн гишүүдийн хэн нь нүүх болон үлдэх шийдвэрийг гаргасан бэ? Эхнэр/нөхөр (хамтран амьдрагч) аль эсвэл хамтын шийдвэр байсан уу?
4. Гэр бүлийн гишүүдийн тоо? Бүгд бичил уурхайд ажиллаж байгаа эсэх?
5. Таны нэг өдөр хэрхэн өнгөрдөг вэ? Өглөө босохоос унтах хүртлэх ажлаа тодорхойлон тайлбарлана уу?
6. Та яагаад бичил уурхайд ажилладаггүй вэ? Хүндрэл бэрхшээл байна уу аль эсвэл өөр шалтгаантай юу?
7. Бичил уурхай эрхэлж буй болон тухайн газар ямар нэгэн бизнес/ үйлчилгээ эрхэлж буй эмэгтэйчүүд олон бий. Энэ салбарт эмэгтэйчүүд ажиллах нь хэр тохиромжтой вэ?
8. Та өмнө нь бичил уурхайд ажиллаж байсан уу? Хэрэв тийм бол яагаад ажиллахаа больсон бэ? Хэрэв үгүй бол яагаад гэдгээ тайлбарлана уу?
9. Бичил уурхайтай болон уурхайгүй газар амьдрахын ялгаа?
10. Бичил уурхай эрхлэхийн эерэг болон сөрөг нөлөөллүүд?
11. Бичил уурхай нь таны амьдарч буй газар нутагт болон таны ашигладаг, хэрэглэдэг ямар нэгэн байгалийн нөөцөд (бэлчээр, ундны болон гэр ахуйн хэрэглээний ус) хэрхэн нөлөөлж байна?
12. Та ирэх 5 жилийн хугацаанд энэ газраа сууршин амьдрах хүсэлтэй юу?
13. Таны хүүхэд/хүүхдүүд ирээдүйд энэ газар сууршин ажиллаж, амьдрахыг та хүсдэг үү? Яагаад тийм/ яагаад үгүй?

Мэдээлэл цуглуулах ярилцлагын тайлбар

1. Байршил (аймаг, сум ба газрын нэр) ба огноог тэмдэглэх
2. Энэ бичил уурхайд ажиллаж буй бүхий л бичил уурхайчид нөхөрлөлийн гишүүн үү? Аль эсвэл энэ уурхай дээр нөхөрлөлийн зохион байгуулалтанд ороогүй хувиараа болон хууль бусаар ажиллаж буй бичил уурхайчин иргэд байдаг уу?
3. Хэрэв байдаг бол хувиараа ажилладаг бичил уурхайчдын дунд эмэгтэйчүүд нь их үү аль эсвэл эрчүүд нь их үү?
4. Бичил уурхайчдын өдөр тутмын ажил (уулын ажлаас гадна) хүйсээс шалтгаалан өөр байдаг уу? Таны бодлоор эр, эм хүний ажиллах чадамж ижил үү? Хэрэв тийм бол яагаад гэдгийг тайлбарлана уу? Хэрэв үгүй бол яагаад?
5. Нөхөрлөлд орж ажиллах нь ашигтай юу? Нөхөрлөлийн давуу талыг эр, эм хүмүүс тэгш хүртдэг үү?
6. Хууль бусаар ажиллаж буй эр, эм бичил уурхайчдын уулын ажилтай холбоотой эрхэлж буй ерөнхий ажлууд нь юу вэ? Хөдөлмөрийн хувиарлалт нь хүйсээс шалтгаалан өөр үү? Аль эсвэл эр, эм гэлтгүй бүх бичил уурхайчид уурхайн ажлыг бүгдийг нь гүйцэтгэж чаддаг уу? Хүйсээс шалтгаалан ажил үүргийн хувиарлалт өөр бол шалтгааныг нь тайлбарлана уу?
7. Эр, эм хүмүүсийн нөхөрлөл доторхи ажил үүргийг тодорхойлно уу? Эмэгтэй бичил уурхайчин нөхөрлөлийн тэргүүн байж болох уу? Хэр түгээмэл вэ?
8. Нөхөрлөлийн гишүүдэд тулгарч байгаа санхүү болон нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд эр, эм гишүүдийн үүрэг оролцоо хэр байдаг вэ? *(гишүүд адил идэвхтэй болон нөлөөлөл сайтай оролцоог хангаж чадаж байгаа эсэх)*
9. Нөөц дуусахад дараагийн газрыг хаана авахыг хэн нь шийддэг вэ? Энэ шийдвэрийг гаргахад эр, эм гишүүд тэгш эрхтэй оролцдог уу?
10. Хууль бусаар болон хувиараа ажиллаж буй иргэдээс гадна дэлгүүр ажиллуулдаг, алт худалдан авдаг болон бусад үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн дунд эрчүүд их үү, аль эсвэл эмэгтэйчүүд нь их үү? Зөвхөн эрэгтэй хүмүүс эрхэлдэг бизнес үйлчилгээ гэж бий юу?
11. Олборлолт явуулж буй газар хэнийх вэ? Хаанаас эхэлж ухах талаар хэн нь шийддэг вэ? Хууль бус болон хувиараа ажиллаж буй бичил уурхайчин эр, эм иргэд дээрх шийдвэрийг гаргахад тэгш оролцдог уу?
12. Та өөрийн хувийн өмчтэй юу? Танай хашаа байшин/гэр, мал сүрэг хэний нэр дээр байдаг вэ? Эд хөрөнгө нь нэг хүний нэр дээр байдаг уу аль эсвэл эхнэр, нөхрийн хоюулангийнх нь нэр дээр байдаг уу? Эд хөрөнгөө зарах, ашиглахтай холбоотой шийдвэрийг хэн нь гаргадаг вэ?
13. Таны гэр бүл, найз нөхөд, хамтран ажилладаг хүмүүсийн гэр бүлд хүчирхийлэлтэй холбоотой ямар нэг асуудлууд гардаг уу? Тийм бол дэлгэрэнгүй ярьж өгнө үү?
14. Ямар нэгэн байдлаар (жишээлбэл, үгээр шоглох гэх мэтээр) эрэгтэй бичил уурхайчид эмэгтэйчүүдэд хүйсийн дарамт шахалт үзүүлдэг үү? Энэ дарамт шахалтанд гэрлэсэн бичил уурхайчин эмэгтэйчүүд илүү өртдөг үү? Аль эсвэл гэрлээгүй бичил уурхайчин хүүхнүүд илүү өртдөг үү?
15. Та гэр бүлтэй юу? Хэрэв тийм бол эхнэр/нөхөр эсвэл хамтран амьдрагчийнхаа үйлдлийг эсэргүүцэх, санаа бодолтой нь зөрөлдөхөд танд ямар нэгэн дарамт шахалт ирдэг үү?
16. Бичил уурхайн газарт биеэ үнэлэгчид байдаг уу? Хэрэв тийм бол тэдний нас 18 наснаас дээш үү? Аль эсвэл 18 наснаас доош насны эмэгтэйчүүд байдаг уу? Тэд энэ нутгийн иргэд үү аль эсвэл өөр аймаг, сумынх уу?
17. Таны бодлоор эмэгтэй бичил уурхайчид эрчүүдтэй харьцуулбал бичил уурхай эрхлэн орлого олох нь илүү хүнд байдаг уу?/ хязгаарлаж байгаа хуулийн зүйл анги бий юу?/

АСУУЛГА БОЛОН ЯРИЦЛАГА ХОСОЛСОН ХЭЛБЭР

Байршил: _____ аймаг _____ сум **Огноо:** _____

Нэр: _____

Ярилцлага өгч байгаа хүний талаархи ерөнхий мэдээлэл

1. Хүйс (дугуйлна уу): _____ Эрэгтэй / Эмэгтэй
2. Нас: _____
3. Та энэ суманд оршин суух бүртгэлтэй юу?
 1. Тийм
 2. Үгүй _____
4. Та бичил уурхайн газарт хэнтэй хамт амьдардаг вэ?

1. Ганцаараа	5. Найзууд/ нөхөрлөлийн гишүүд
2. Эхнэр/нөхөр	6. Хамаатнууд
3. Эхнэр/нөхөр болон хүүхдүүд	7. Бусад: _____
4. Хүүхдүүд	8. Мэдэхгүй/Хариулж чадахгүй
5. Та бичил уурхай эрхлээд хэр удаж байна вэ?

1. 1 жилээс бага	4. 5 жилээс дээш
2. 1-2 жил	5. Санахгүй байна
3. 3-5 жил	6. Хариулж чадахгүй
6. Та ямар шалтгааны улмаас бичил уурхай эрхлэх болсон бэ?
(Хамааралтай хариултуудыг дугуйлна уу)
 1. Өмнөх ажлаасаа халагдсан
 2. Малаа алдсан
 3. Өөр ажлын байр байхгүй
 4. Бусад боломжит ажлыг бодвол бичил уурхай эрхлэх нь илүү орлоготой
 5. Өөрөө бие даан ажиллах сонирхолтой
 6. Бусад: _____

7. Бичил уурхай дээр та ямар ажил хийдэг бэ? (Хамааралтай хариултуудыг дугуйлна уу)

1. Ашигт малтмал ухах

2. Угаах

3. Хүдрийг бутлах

4. Хүнсний бараа зарах

5. Тамхи зарах

6. Хувцас/гутал зарах

7. Алт худалдан авах

8. Унаа тээврээр үйлчлэх

8. Бусад _____

8. Бичил уурхайн зарим ажил нь эмэгтэй хүмүүст илүү тохиромжтой бол зарим нь эрчүүдэд илүү тохиромжтой. Та үүнтэй санал нийлдэг үү?

1. Тийм

2. Үгүй

9. Хэрэв тийм бол, жишээ өгч дэлгэрэнгүй тайлбарлана уу (асуулт #8-ын хариулт дээр үндэслэн): _____

10. Уурхай дээр эмэгтэй хүний хариуцан хийх гол ажил үүрэг юу вэ? _____

11. Уурхай дээр эрэгтэй хүний хариуцан хийх гол ажил үүрэг юу вэ? _____

12. Бичил уурхай эрхлэх болон уурхай дээр бусад үйлчилгээ/ бизнес эрхлэх нь эмэгтэй хүнд тохиромжтой/зохистой юу?

1. Тийм

2. Үгүй

13. Асуулт #12-ын хариултыг дэлгэрэнгүй тайлбарлана уу?

14. Бичил уурхайн салбар дахь эмэгтэй бичил уурхайчдын тоо эрэгтэй бичил уурхайчдын тоотой харицуулахад бага. Яагаад гэдгийг нь тайлбарлана уу?

1. Эр хүмүүс биеийн хүчний ажил хийхэд бие бялдар болон чадвараар илүү
2. Эр хүмүүс уурхайн ажилдаа илүү сайн
3. Эмэгтэй хүнд уурхайн ажлаас гадна давхар гүйцэтгэх үүрэг хариуцлага их (жишээ нь: гэр орон, хүүхэд харах г.м.)
4. Орлого олох нь эр хүний үүрэг
5. Бичил уурхай дахь хүнд хэцүү нөхцөл эм хүнд тохиромжгүй
6. Бусад: -----

15. Эмэгтэйчүүдийн хувьд бичил уурхай эрхлэхэд тулгарах бэрхшээл, орлого олоход тулгарах хүндрэл юу вэ?

1. Тийм, дараах бэрхшээлүүд эмэгтэй бичил уурхайчдад тулгардаг: -----

2. Үгүй, Эр, эм бичил уурхайчдад тулгарах хүндрэл бэрхшээл адилхан.

16. Та өнгөрсөн долоо хоногт ойролцоогоор хэдэн төгрөг олсон бэ?

1. Юу ч олоогүй
2. 8,000 төгрөгнөөс доош
3. 8,000 – 22,400 төгрөг
4. 22,400 – 73,500 төгрөг
5. 73,500 – 158,400 төгрөг
6. 158,400 – 318,400 төгрөг
7. 318,400 – 800,000 төгрөг

17. Бичил уурхай таны гэр бүлийн орлогын гол эх үүсвэр мөн үү?

1. Тийм 2. Үгүй _____

18. Танай гэр бүлд орлогоо зарцуулахад хэн голлон шийдвэр гаргадаг вэ?

1. Би ганцаараа шийддэг
2. Эхнэр эсвэл нөхөр шийддэг
3. Эхнэр болон нөхөр хамтдаа шийддэг
4. Хамаатан садан шийддэг
5. Бусад _____

19. Бичил уурхайгаас олсон орлогоо та юунд ихэвчлэн зарцуулдаг вэ?

1. Хүнсний болон бусад наад захын хэрэглээний зүйлс
2. Сургалтын төлбөр болон бичиг хэрэг (сурагчын дүрэмт хувцас)
3. Мал
4. Хувьдаа зарцуулдаг
5. Машин, мотоцикл ба бусад тээврийн хэрэгслэл авахаар хадгалж байна
6. Бусад: _____

20. Та дараагийн 5 жилд бичил уурхай үргэжлүүлэн эрхлэх бодолтой байна уу?

1. Тийм, яагаад гэвэл:

2. Үгүй, яагаад гэвэл:

21. Таны ажиллаж буй уурхайн ордны нөөц дуусвал та юу хийхээр төлөвлөж байна?

22. Та бичил уурхай эрхэлсэнээр 5 жилийн дараа өөрийгөө хаана юу хийж байна гэж төсөөлж байна вэ?

1. Хангалттай малтай болох
2. Бичил уурхайн салбарт өөрийн гэсэн байр суурьтай болох
3. Бичил уурхай эрхлэхэд хэрэгцээтэй тоног төхөөрөмж авах
4. Хүнтэй гэрлэх, гэр бүлтэй болох
5. Хотод байр, орон сууцтай болох
6. Жижиг хувийн бизнес эрхлэх
7. Бусад _____

23. Та өөрийн хүүхэд/хүүхдүүдийг бичил уурхайчин болгохыг хүсдэг үү?

1. Тийм, яагаад гэвэл: _____
2. Үгүй, яагаад гэвэл: _____

24. Таны ажиллаж буй бичил уурхайд байгаль орчны ямар доройтол, хохирол учирсан бэ?

1. Усны бохирдол
2. Мөнгөн усны бохирдол
3. Хөрсний эвдрэл, доройтол
4. Бичил уурхайн улмаас үүссэн нүхнүүд
5. Бэлчээрийн газрын доройтол
6. Бусад: _____

25. Дээрх дурьдсан байгаль орчны доройтол нь таны болон таны гэр бүлийн гишүүдийн амьдралд хэрхэн нөлөөлж байна вэ?

АЖИГЛАЛТЫН ХУУДАС**Ерөнхий**

1. Газрын нэр: _____
2. Огноо: _____
3. Ашигт малтмалын төрөл: _____
4. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлийн тоо: _____

Хүн ам

5. Тухайн бичил уурхайн бичил уурхайчдын тоо: _____
6. Бичил уурхайчдын хүйсийн харьцаа: _____ % эмэгтэй, _____ % эрэгтэй (7)
8. Тухайн бичил уурхай дээр ажил, үйлчилгээ үзүүлэгч иргэдийн тоо: _____
9. Ажил, үйлчилгээ эрхлэгч иргэдийн хүйсийн харьцаа: _____ % эмэгтэй, _____ % эрэгтэй (10)
11. 18-аас доош насны хүүхдүүд ажилладаг эсэх (<): Тийм/ Үгүй
12. Бичил уурхайчдын дотор хүүхдүүдийн эзлэх хувь: нийт бичил уурхайчдын _____ %
13. Бичил уурхайд ажиллаж буй хүүхдүүдийн хүйсийн харьцаа: __% охид, __% хөвгүүд (14)

Үйлчилгээ авах боломж болон харилцаа холбоо

15. Улаанбаатар хотоос хэр зайтай (км): _____
16. Тогтмол явдаг тээврийн хэрэгслээр зорчвол Улаанбаатар хотоос ирж очиход хэдий хэрийн хугацаа зарцуулдаг бэ? _____
17. Тогтмол явдаг тээврийн хэрэгслээр хамгийн ойрын суурин болон тосгонд хүрэхэд хэр их хугацаа орох вэ? _____
18. Засмал замтай юу? Тийм / Үгүй
19. Үүрэн холбооны сүлжээтэй юу? Тийм / Үгүй
20. Нийтийн тээврээр хүрэх боломжтой юу? Тийм / Үгүй
21. Хэрэв тийм бол тайлбарлана уу: _____

22. Уурхайд ажиллаж байгаа хүмүүсийн хамгийн түгээмэл ашигладаг тээврийн хэрэгсэл болон зорчих үнэ:

Нийтийн үйлчилгээ

23. Хамгийн ойрын эрүүл мэндийн төв хүртэлх зай (км):

24. Хаймгийн ойрын эрүүл мэндийн төв рүү очих хугацаа: -----

25. Хамгийн ойрын эмнэлэг хүртэлх зай (км): -----

26. Хамгийн ойрын эмнэлэг хүрэхэд шаардагдах хугацаа: -----

27. Бүртгэл хийлгэхэд хамгийн ойр сумын төв/захиргаанд хүрэхэд шаардагдах хугацаа: ____

28. Хамгийн ойрын сургууль руу хүрэхэд шаардагдах хугацаа: -----

29. Цахилгаан эрчим хүчинд холбогдсон эсэх (тайлбарлана уу): -----

30. Ундны усны хүртээмж (тайлбарлана уу): -----

Микро-эдийн засаг

31. Алт худалдан авах цэг буюу алт худалдан авагч иргэд байдаг эсэх: Тийм/Үгүй

32. Тайлбарлана уу: -----

33. Ашигт малтмалын орон нутгийн үнэ ----- нэгжийн

34. Бичил уурхай эрхлэхэд гардаг дундаж зардал: -----

35. Бүтэн цагаар ажилладаг бичил уурхайчдын дундаж орлого (долоо хоногт 6 өдөр, өдөрт 10 цаг) -----

Жендерт суурилсан ажил үүргийн хуваарь

36. Уурхай дээр эмэгтэйчүүдийн голлон хийдэг ажил (ажиглалт): _____

37. Уурхай дээр эрчүүдийн голлон хийдэг ажил (ажиглалт):

38. Уурхай дээр 18-с доош насны охидын хийдэг ажил: _____

39. Уурхай дээр 18-с доош насны хөвгүүдийн хийдэг ажил: _____

40. Газар дор ажилладаг хүмүүс? (холбогдох хариултыг дугуйлна уу)

а. Хэн ч ажилладаггүй б. Эрэгтэй с. Эмэгтэй d. Хөвгүүд e. Охид

41. Уурхай дээр бага насны хүүхдүүд/ нялх хүүхдүүд байсан эсэх? Тийм / Үгүй

42. Хэрэв тийм бол, хэн тэднийг асардаг вэ? _____

43. Бичил уурхайчид хаанаас/хэрхэн хоол унд болон уух зүйлсээ авдаг вэ? (жишээ нь: уурхай дээрээс авдаг, өрхийн эрэгтэй, эмэгтэй гишүүн уурхай дээр авчирдаг)

Амьдрах орчин

44. Амьдарч буй орон байрныхаа нөхцлийг тодорхойлно уу (жишээ нь: майхан/гэр/ байшинд амьдарч байгаа хүмүүсийн хувь хэмжээ; барилгын материалын төрөл)

45. Бусад ажиглалтууд:

Хавсралт 2

1. Таны ажиллаж буй бичил уурхай дээр эмэгтэй бичил уурхайчид болон уурхайн ойр орчим ажил, үйлчилгээ үзүүлдэг эмэгтэйчүүд жирэмсэлснийхээ дараа юу хийдэг вэ? Тэд үргэлжлүүлэн ажилладаг уу? Хэрэв тийм бол хэдэн сартай болтлоо ажилладаг вэ? Тохирохыг нь тэмдэглэнэ үү.

- (a) Жирэмсэн болсон даруйдаа ажиллахаа больдог.
- (b) Жирэмсэн байх хугацаандаа үргэлжлүүлэн ажилладаг ч аль болох хөнгөн ажил хийдэг.
- (c) Гэдэс нь томорсны дараагаар ажиллахаа больдог (6 сартайгаас хойш).
- (d) Төрөх хүртлээ уурхайд ажилладаг.
- (e) Хэсэг хугацаанд баяжуулах хэсэг дээр ажилладаг ч аль болох хөнгөн ажил хийдэг.
- (f) Гэдэс нь томорсны дараагаар баяжуулах хэсэгт ажиллахаа больдог (6 сартайгаас хойш)
- (g) Эмэгтэйчүүд төртлөө баяжуулах хэсэгт ажилладаг.
- (h) Бус
- (i) ад: _____

2. Зохион байгуулалтанд орсон бичил уурхай бичил уурхай дахь жирэмсэн эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлсөн бэ? Холбогдох хариултыг тэмдэглэнэ үү.

Зохион байгуулалтанд ороогүй бичил уурхай дээр эмэгтэйчүүд жирэмсэн болсныхоо дараа ч үргэлжлүүлэн ажилладаг уу?	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Зохион байгуулалтанд ороогүй бичил уурхай дээр жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсний сүүлийн хугацаа болтол уурхайн аль нэг хэсэгт ажилласаар байдаг уу? (жишээ нь: танай уурхай зохион байгуулалтанд орохоос өмнө)	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Зохион байгуулалтанд ороогүй бичил уурхай дээр жирэмсэн эмэгтэйчүүд баяжуулах хэсэгт үргэлжлүүлэн ажилладаг уу?	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Зохион байгуулалтанд ороогүй бичил уурхай дээр жирэмсэн эмэгтэйчүүд үргэлжлүүлэн ажилладаг уу? (танай уурхай зохион байгуулалтанд орохоос өмнө)	Тийм	Үгүй	Мэдэхгүй

3. Та жирэмсэн эмэгтэй алттай хүдэр баяжуулахад ажиллаж байхдаа мөнгөн ус хэрэглэж байхыг харсан уу? Хэрэв тийм бол хаана?

- (a) Үгүй, жирэмсэн эмэгтэй алттай хүдэр баяжуулахдаа мөнгөн ус хэрэглэж байгааг харж байгаагүй.
- (b) Тийм, жирэмсэн эмэгтэй алттай хүдэр баяжуулахдаа мөнгөн ус хэрэглэж байгааг зохион байгуулалтанд ороогүй бичил уурхай дээр харж байсан.
- (c) Тийм, жирэмсэн эмэгтэй алттай хүдэр баяжуулахдаа мөнгөн ус хэрэглэж байгааг зохион байгуулалтанд орсон газар харж байсан.

- (d) Тийм, жирэмсэн эмэгтэй алттай хүдэр баяжуулахдаа мөнгөн ус хэрэглэж байгааг зохион байгуулалтанд орсон, ороогүй газруудад аль алинд нь харж байсан.
- (e) Мэдэхгүй.
4. Танай бичил уурхай зохион байгуулалтанд орохоос өмнө эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, догшин авир илүүтэй гардаг байсан уу?
- (a) Үгүй, энэ тал дээр ямар ч өөрчлөлт гараагүй.
- (b) Тийм, бага зэрэг. Зарим эмэгтэйчүүдтэй зүй бусаар харьцдаг байсан гэхдээ ихэвчлэн тоглоомоор.
- (c) Тийм, нилээд их. Эмэгтэйчүүдийг хэл амаар доромжилдог байсан.
- (d) Тийм, маш их. Эмэгтэйчүүдийг байнга хэл амаар доромжилж, зарим тохиолдолд бие махбодийн хүчирхийлэл ч гардаг байсан.
- (e) Буад: _____

5. Та өмнөх хариултаа тайлбарлах аль эсвэл жишээ татна уу?

АНУ-ын Азийн сан
Ориент Плаза, 3-р давхар
Г.Чагдаржавын гудамж-9
Төв шуудан, ш/х 1003
Улаанбаатар, 14210 Монгол улс
www.asiafoundation.org